

ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

СУДАЛ

№ 04

KONRAD
ADENAUER
STIFTUNG

*Тэгш эрх
Тэгш боломж*



РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ:



Профессор
Ж.Төртогтох,
МУИС-ийн Улс
төр судлалын
тэнхимийн
эрхлэгч



Профессор
Ц.Ганболд,
МУИС-ийн Улс
төр судлалын
тэнхимийн
зөвлөх
профессор



Доктор
П.Амаржаргал,
Монгол Улсын
Их Хурлын
Тамгын газар



С.Ганзаяа,
Монгол Улс
дахь Конрад-
Аденауэр-
Сангийн
хөтөлбөрийн
менежер

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангаас эрхлэн гаргав.

Энэхүү бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул эшлэл авалгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

Бүтээлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

Агуулга

Тэгш байдлыг хангах зарчим ба эмэгтэйчүүдийн эрхийн харилцан хамаарлын зарим асуудал	6-22
С.Номынбаясгалан	
Эмэгтэйчүүдийн эрх: Түүхэн хөгжил болон эрх зүйн баримт бичгүүд	23-36
Б.Болорсайхан	
Улс төрийн сонгуульд хандах эмэгтэй шинэ сонгогчийн хандлагыг тодорхойлох судалгаа (Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн жишээн дээр)	37-48
Б.Уянга	
Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эсрэг шинэ хориг саад: цахим хүчирхийлэл, тролл	49-55
Т.Туяачимэг	
Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх тэдний нийгэм, улс төрийн оролцоонд нөлөөлөх нь буюу Womenomics ойлголтын тухайд	56-67
Д.Уртнасан	
Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг үнэлэх нь	68-76
Г.Цэлмэг	
Зүйр цэцэг үг болон Монголын түүхэн сурвалжуудад илэрч буй эмэгтэйчүүдийн дүр, үүрэг	77-83
Д.Цэрэнжамц	
Автомашинны засварчин, гагнуурчин мэргэжлээр элсэн суралцах охидын асуудал	84-94
Г.Уранчимэг	

Мэндчилгээ



Конрад-Аденауэр-Сан нь 1993 оноос Монгол Улсад иргэний нийгэм, ардчиллыг дэмжих ажлын хүрээнд захиргааны болон нийгэм, улс төрийн шинжлэх ухааны туршлагажсан болон залуу эрдэмтэн судлаачдын дунд академик хэлэлцүүлгийг олон талт хэлбэрээр зохион байгуулж ирсэн бөгөөд уг үйл ажиллагаагаар дамжуулан эрдэмтэн судлаачид Монгол Улсад тулгарч буй сорилтыг тодорхойлж, үзэл бодлоо илэрхийлэх, асуудлыг шийдвэрлэх боломж бий болдог билээ. 2018 оноос эрхлэн гаргаж

буй энэхүү мэргэжлийн сэтгүүл нь дээрх хэлэлцүүлэг, үзэл бодлоо солилцох нэгэн хэлбэр юм.

Төрийн байгуулал судлал сэтгүүлийн энэ удаагийн дугаараар Эмэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш харилцааны олон талт сэдвүүдийг дэлгэрүүлэн судалж бичсэн өгүүлэл, нийтлэлийг эмхэтгэн гаргалаа. Монгол Улсад төдийгүй дэлхийн олон улс оронд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн цалингийн зөрүү байсаар байгаа. Түүнчлэн улс төрийн болон эдийн засгийн салбар дахь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо илт доогуур байна. Тэгш байдлын талаар хууль тогтоомжид зааж өгснөөр энэ нь тэгш харилцаа бий болгож байгаа баталгаа биш юм.

Эдгээр сэдвүүдэд цаг заваа зориулж, шийдвэрлэх асуудлыг дэвшүүлэн нийтлэлээ ирүүлсэн нийт судлаачиддаа талархлаа илэрхийлэн уншигчиддаа энэ сэтгүүлийн 4 дэх дугаарыг өргөн барьж буйг хүлээн авна уу.

Виктор Франк
Монгол дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч

Өмнөх үг



Уншигч Танд Төрийн байгуулал судлал сэтгүүлийн 4 дэх дугаарыг өргөн барьж буйг хүлээн авна уу. Энэхүү дугаар нь эмэгтэйчүүдийн оролцооны асуудлын талаарх тусгайлсан дугаар болж байгаа бөгөөд нийгмийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо, эрхийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн өгүүллүүд болон судлаачийн ажиглалт, дүгнэлт бүхий нийтлэлүүдийг сэтгүүлийн редакц хүлээн авч, сонгон шалгаруулалтын үндсэн дээр хэвлэн нийтлэлээ.

Тэдгээр нь тэгш байдлыг хангах зарчим ба эмэгтэйчүүдийн эрхийн харилцан хамаарал, эмэгтэйчүүдийн эрхийн түүхэн хөгжил, улс төрийн сонгуульд хандах эмэгтэй шинэ сонгогчийн хандлага, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эсрэг шинэ хориг саад, цахим хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх, нийгэм, улс төрийн оролцоо, эмэгтэйчүүдийн Монгол улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд оруулж буй хувь нэмэр зэрэг

нийгэм, улс төр, эдийн засгийн салбар дахь эмэгтэйчүүдийн эрх, оролцоо, тэгш байдлын олон тулгамдсан асуудлуудыг хөндсөний зэрэгцээ судлаачдын судалгаа, ажиглалт, харьцуулалт, дүгнэлт, дүн шинжилгээнд үндэслэсэн байр суурь, үзэл бодлыг илэрхийлж буй юм.

Үндэсний судлаачдын судалгаа, шинжилгээний үр дүн бүхий өгүүлэл, нийтлэлийг хэвлэн нийтэлж, бусад судлаач, суралцагч, сонирхогч олон нийтийн хүртээл болгоход үнэтэй хувь нэмэр оруулж ирсэнд ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газрын хамт олонд редакцын зөвлөлийн гишүүдийн өмнөөс гүн талархал илэрхийлж цаашдын хамтын ажиллагаанд амжилт хүсье.

***МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,
Ардчилал судлалын төвийн захирал, профессор Жанарын Төртогтох***

Тэгш байдлыг хангах зарчим ба эмэгтэйчүүдийн эрхийн харилцан хамаарлын зарим асуудал

С.НОМЫНБАЯСГАЛАН

Хууль зүйн магистр (LL.M)

Хураангуй: Энэхүү нийтлэлийн сэдвийг “Үндсэн хуулиуд ба Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын харилцан хамаарлын асуудал” гэж томъёолон, агуулгыг “эмэгтэйчүүдийн эрхийн тэгш байдлын” асуудлаар хязгаарлав.

Түлхүүр үгс: Хүний эрх, засаглал, эмэгтэйчүүдийн оролцоо, хөгжлийн бэрхшээл, үндсэн эрх, хүний эрхийн олон улсын гэрээ, хамтын ажиллагаа, улс төрийн эрх, улс төрийн оролцоо, бүх шатны сонгууль, сонгох, сонгогдох эрх, улс төрийн (эрх зүйн) антропологи, улс төрийн нам, жендэр.

- I. Оршил
- II. Үндсэн асуудал
- III. Дүгнэлт

I. ОРШИЛ

Эмэгтэйчүүдийн эрх бол хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагын үндсэн хэсэг юм. Хэдийгээр жендэрийн тэгш байдал Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)-аар хүлээн зөвшөөрөгдсөн боловч Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)-ийг бэлтгэх явцад л энэ асуудлыг дэлхий нийт цогцоор нь авч үзэж эхэлсэн юм.¹ Анх 1980-аад оны төгсгөл үед олон улсын харилцааны ухаанд яригдах болсон жендэрийн тэгш байдал хийгээд феминизмын асуудал нь өнөөдөр түүний бие даасан салбар судлагдахуун болжээ. Феминист хандлагын нэг онцлог бол түүнийг нэгтгэн илэрхийлэхүйц нийтлэг онол, арга зүйн чиг хандлага үгүй бөгөөд маш олон янзын судалгаа шинжилгээний асуудлууд, арга зүйн хандлагуудаас бүрддэг. Тиймээс ч олон улсын харилцааны онолд хүлээн зөвшөөрөгдөх байдал нь харьцангуй удаан явагдаж ирсэн² нь үүнтэй холбоотой. Энэ утгаараа энэ асуудлын талаар олон улсын харилцааны онолын үүднээс авч үзэж,³ тайлбарлаж болно гэж үздэг. Иймд чухамхүү энэ агуулгаар нь илүүтэй хөндөхийг энд эрмэлзлээ.

¹ Шабир Чиймаа (G. Shbbir Cheema), Ардчилсан засаглал ба иргэнийг холбох нь, НУБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар, Уб., 2008, 40 дэх тал

² Бямбажав Д., Олон улсын харилцаа ба феминист хандлага, Шинэ толь сэтгүүл, Уб., 2006, №54, 11 дэх тал

³ Хууль Сахиулахын Их Сургууль, Эрх зүйн процессын шинэтгэл, хэрэгжилт, (Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл), Уб., 2019, 15 дахь тал

Эмэгтэйчүүд болон эрх зүйн хоорондын харилцааг судалдаг эрх зүй судлалын нэгэн хэсгийг “феминист эрх зүй судлал”⁴ гэж үздэг. Энэхүү нийтлэлээр Үндсэн хуулиуд ба Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын харилцан хамаарлыг феминист онолын үүднээс Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулиудын дүнгийн нээлттэй өгөгдлийн сангийн мэдээлэл⁵ болон Улс төрийн намын тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиуд, хамаарах эрх зүйн зохицуулалтад үндэслэн авч үзэв. Чухамдаа энэхүү нийтлэлээр хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийн⁶ эрхийн харилцан хамаарлын асуудлыг авч гол зорилгоо болгов.

Учир нь феминист эрх зүй судлалд эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралд оролцох оролцооны байдал судалгааны нэг объект болж байдаг.⁷ Үүнд л энэ нийтлэлийн гол утга учир оршино. Учир нь Монгол Улсын хувьд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг Улсын төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн зайлшгүй хэрэгцээ байгааг Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнгүүд харуулсаар байна.⁸ Улс төрийн намууд зөвхөн “Монгол Улсын Их Хурлын” гэлтгүй “орон нутгийн Хурлын” сонгуульд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах асуудлыг шийдвэрлэхгүй байсаар багагүй хугацааг өнгөрүүлээд байна.

Мөн түүнчлэн статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээллээс үзвэл⁹ 2003–2020 онуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо жил бүр өсөн нэмэгдэж ирсэн байна. Энэ байдлыг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих төдийгүй сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусган улс төрийн үйл ажиллагаанд оролцох өргөн боломжийг хууль зүйн хувьд бүрдүүлсэн байна.¹⁰ Гэвч бодит амьдрал дээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн холбогдох зохицуулалт хэрэгжихгүй, үр нөлөө муутай байсаар байна. Энэ нь эрх зүйн (хуулийн) зохицуулалт дутагдалтай байгаагаас бус харин улс төрийн хүсэл зоригийн (төрийн бодлого) дутуу байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох бололцоог хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлсэн байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Иймд Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн “11.2.Намын дүрэмд дараахь нийтлэг зүйлийг тусгана: гээд 11.2.8.сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчим,” гэсэн зохицуулалтад “, **хөгжлийн бэрхшээлийн**” гэсэн нэмэлт оруулах саналыг гаргасан байдаг.¹¹ Энэ талаарх асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн болон хүний эрхийн олон улсын зарим гэрээний холбогдох зохицуулалттай холбон авч үзэв.

4 Лүндэндорж Н., Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, (Анхны хэвлэл), Уб., 2011, 101 дэх тал

5 Номынбаясгалан С., Цар тахал ба иргэдийн сонгуулийн ирц, оролцооны асуудал, Шинэ толь сэтгүүл, Уб., 2020, №81, 42–43 дахь тал

6 Эмэгтэйчүүдийн статистик мэдээллийг нийтлэлийн хавсралтаас үзнэ үү.

7 Лүндэндорж Н., Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, (Анхны хэвлэл), Уб., 2011, 110 дахь тал

8 Номынбаясгалан С., Монгол Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хангах асуудал, Эрх зүй сэтгүүл, Уб., 2021, №1, Хавсралтаас үз

9 Энэ талаарх статистикийн мэдээллийн дэлгэрэнгүйг доорх холбоосоор орж үзнэ үү.

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_3900_004V1&Disability_select_all=0&DisabilitySingleSelect=1_2_3_4_5_6_7_8_9&YearY_select_all=0&YearYSingleSelect=2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012_2011_2010_2009_2008_2007_2006_2005_2004_2003_2020&viewtype=table

10 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд “30.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 30.2.Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна. 30.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй. 30.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана” гэж заасан. <https://www.legalinfo.mn/law/details/11711> (Үзсэн огноо: 2021.10.14)

11 Номынбаясгалан С., Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг Улс төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байх уу?, Улс төрийн намын тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийн хүрээнд, Төрийн байгуулал судлал, Уб., 2021, №3, 49–50 дахь тал

II. ҮНДСЭН АСУУДАЛ

Дэлхийн улс орон бүр өөрийн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээр нь хүн амын амьдралын хэв маяг, зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээ, онолын хөгжлийн хувьд хоорондоо ихээхэн ялгаатай¹² учраас олон улсын түвшинд нэгдмэл (нийтийн болон хувийн) эрх зүй бүрэлдэж бий болох боломж “бага” юм. Ийм нөхцөлд олон улсын шинжтэй нийтийн эрх зүйн харилцааны зохицуулах арга журмыг зөв тогтоох, хэрэглэгдвэл зохих эрх зүйн хүрээг тодорхойлох асуудал үндэсний эрх зүйн шинжлэх ухааны өмнө зүй ёсоор тавигдана.

Төр, эрх зүйн онолын талаасаа үндэсний эрх зүй ба олон улсын эрх зүйн харилцааны асуудлууд нь улам бүр анхаарал татсаар байна. Өнөө үед хүн төрөлхтний өмнө дэвшин тавигдаж байгаа дэлхий нийтийг хамарсан глобал шинжтэй асуудлыг шийдвэрлэх нийтлэг зорилго нь улс орнуудын хоорондын болон олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн хамаарлыг улам бүр гүнзгийрүүлсээр байна. Энэ байдал нь үндэсний эрх зүйн тогтолцоо, эсвэл олон улсын эрх зүйн тогтолцооны аль нэгийг үгүйсгэх, эсвэл нэг нь дангаар ноёрхох ёстой гэсэн монист үзэл санааны утгаар бус харин энэ хоёр тогтолцооны уялдаа холбооны шинжээр нь, харилцан нягт холбоотойгоор нь авч үзэх болсон.¹³ Цаашлаад “үндсэн хуульт ёс” тогтон төлөвшихийн хэрээр эрх зүйн үйлчлэх нөлөөллийн хүчин зүйл үлэмж дээшлэн олон улсын болон үндэсний эрх зүй хоорондын харилцаанд нөлөөлөх боллоо. Энэхүү харилцан холбогдлын асуудал нь хууль зүйн шинжлэх ухаанд онолын маргаан өрнүүлсэн “зангилаа асуудал”¹⁴ болж хувирсан байна. Монголын үндэсний эрх зүйн зохицуулалтын дагуу үндсэн хууль нь энэ талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнээс давуу хүчтэй байгаа нь “олон улсын гэрээг заавал биелүүлэх” тухай нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим яах вэ гэсэн асуулт тавигдах ба энэ тохиолдолд эл зарчим зөрчигдөх нь гарцаагүй.¹⁵ Аливаа улс нь олон улсын гэрээгээр үүрэг хүлээхдээ уг гэрээ тэр улсын дотоодын хууль зүйд харшилж байгаа эсэхийг судалж тогтоосон байх ёстой учраас олон улсын гэрээг биелүүлээгүйгээ дотоодын хууль зүйн заалтаар цагаатгаж болохгүй¹⁶ билээ.

Монгол Улс хүний эрхийн талаарх олон улсын гэрээ конвенцуудад нэгдэн орсноор зөвхөн өөрийн улсын иргэн төдийгүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах үүргийг олон улсын эрх зүйн үүднээс хүлээнэ. Энэ үндсэн дээр олон улсын шинжтэй нийтийн эрх зүйн хэрэг маргааныг зөв оновчтой шийдвэрлэхийн тулд тухайн харилцаанд илүү нягт холбоо бүхий олон улсын гэрээг хэрэглэж болохыг хүлээн зөвшөөрч үндэсний хууль тогтоомж, тэр дундаа үндсэн хуульд энэ талаар дараах зохицуулалтыг тусгажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “. . . Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж, энэ хуулийн Жаран зургадугаар зүйлд “Үндсэн хуулийн цэц . . . Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх . . . асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна. . . . Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих . . . шийдвэр хүчингүй болно” гэж тус тус заажээ. Энэ нь Монгол Улсын хувьд олон улсын гэрээ байгуулахад баримтлах онцгой зарчим бол үндсэн хуулийн давуу

12 Мэндсайхан Т., Монгол Улсын иргэний эрх зүй дэх Гадаад улсын хууль, олон улсын гэрээ хэрэглэх асуудал, (Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл), Уб., 2003, 1 дэх талаас үзнэ үү.

13 Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2017, 256 дахь тал

14 Баярсайхан Д., Эрх зүйн онол, (IV хэвлэл), Уб., 2016, 82–83 дахь тал

15 Сарантуяа Ц., Төрийн ерөнхий онол, Уб., 1998, 51 дэх тал

16 Нямдоо Г., Олон улсын гэрээний зарим асуудал, Уб., Улсын хэвлэлийн газар, 1979, 54 дэх тал

байдал (примат)-ыг хангах явдал¹⁷ чухал болохыг харуулна. Энэ примат байдал бүхий үндсэн хуулийн (10.4) заалт байх шаардлагатай эсэхэд эргэлзсэн ч бий.¹⁸ Үндсэн хуулийн хяналтын үүднээс хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын гэрээг үндсэн хууль зөрчиж байна гэж шийдвэрлэсэн ч, энэ нь уул гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхийг болиулах үндэслэл болохгүй. Үндсэн хуулиа зөрчсөн буюу дотооддоо хэрэгжүүлэх боломжгүй байгаа үүргийг олон улсын эрх зүйгээр хүлээх нь тухайн төр улсдаа ч дарамттай.¹⁹ Иймээс энэ асуудлыг судлах, Үндсэн хуулийн цэцийн практикт Монгол Улсын олон улсын гэрээг зөв тайлбарлан хэрэглэх явдал²⁰ тулгамдсан шинжтэй болсон байна. Энэ байдлыг харгалзан хүний эрхийн салбар дахь олон улсын ба үндэсний эрх зүйн уялдаа холбоо, харилцан хамаарлын асуудлыг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс тодруулж, тодорхой үндсэн хуулийн маргаан бүхий жишээнд тулгуурлан гаргахыг оролдлоо.

Олон улсын болон үндэсний эрх зүйн (системийн) уялдаа холбоо, харилцан хамаарлын талаар хөндсөн дотоодын судлаачдын цөөхөн ном, бүтээлүүд²¹ байна. Энэ нь практик хэрэглээ бага байснаас хамаарч энэ чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хомс хийгдсэн байж болох юм. Монгол Улсын хувьд олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоох байгууллага, шүүхийн хүрээнд гаргасан зохицуулалт байгаа ч тэдгээрийг шүүхэд хэрэглэх асуудлаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс (2005 онд “Шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж ба холбогдох олон улсын гэрээний зөрчилдөөний талаар судалж, шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох: Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”, 2010 онд “Шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх үндэслэл, арга зүй: Олон улсын худалдааны эрх зүйг арбитрын шүүхэд хэрэглэх асуудал”, 2015 онд “Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал”²² сэдэвт судалгаа) өмнө нь хийгдэж байсан судалгаануудыг эс тооцвол онол, практикийн асуудлыг хөндсөн дорвитой бүтээл хараахан гараагүй байна. Зөвхөн олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудлыг (2012 онд) судалсан байна.²³ Өөрөөр хэлбэл, практикийн зарим асуудлыг хөндсөн цөөхөн бодлогын судалгаа хийгдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хууль ба олон улсын гэрээний харилцан хамаарлын тухай Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуульд “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө. Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй БНМАУ-ын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж заажээ.²⁴ Энэ хууль нь Үндсэн хуулийн хүчин чадалтай боловч Үндсэн хууль биш. Тиймээс хавсралт хууль Үндсэн хуулийн заалт, шаардлагын дагуу хэрэгжих ёстой гэж Үндсэн хууль, түүний хавсралт хуулийн харилцан хамаарлыг тодорхойлсон Үндсэн хуулийн цэцийн тайлбар

17 Амарсанаа Ж., ба бусад, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Уб., 2011, 12 дахь тал

18 Дүгэрсүрэн М., Хосбаяр О., Олон улсын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), Уб., 1999, 3 дахь тал

19 Сарантуяа Ц., Үндсэн хуулийн процессын эрх зүй: Суурь ойлголт, тулгамдсан асуудал, Уб., 2005, 114 дэх тал

20 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар магадлал

21 Сарантуяа Ц., Төрийн ерөнхий онол, Уб., 1998, 48–54 дэх тал, Дүгэрсүрэн М., Хосбаяр О., Олон улсын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), Уб., 1999, 3–4 дэх тал, Амарсанаа Ж., Хүний эрх: Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал, Уб., 2000, 55–76 дахь тал, Гантулга Н., Нармандах Б., Олон улсын нийтийн эрх зүй, Уб., 2003, 13 дахь тал, Баярсайхан Д., Эрх зүйн онол, (IV хэвлэл), Уб., 2016, 82–87 дахь тал, Ундралсайхан Д., Орчин үеийн олон улсын эрх зүй, Уб., 2016, 16–17 дахь тал, Баасанхүү Г., ба бусад, Олон улсын харилцааны үндэс ба даяаршил, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2016, 179–181 дахь тал, Мөнхбат М., Олон улсын гэрээний эрх зүй, Уб., 2017, 218–149 дэх тал, Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2017, 256–260 дахь тал, . . . гэх мэт.

22 <http://nli.gov.mn/?p=4384>

23 <http://nli.gov.mn/?p=2035>

24 Энэ хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсэгт, Төрийн мэдээлэл сэтгүүл, Уб., 1992, №1 дугаараас үзнэ үү.

бий.²⁵ Тийм учраас Үндсэн хууль оршин байгаа шалтгааныг “Үндсэн хууль байх ёстой учраас байгаа юм” гэсэн үндсэн хэм хэмжээг удирдлага болгодог. Яг үүн шигээр олон улсын эрх зүй байгаа нь үндсэн хэм хэмжээ нь “Улс гүрнүүд өөрийн харилцан хамаарлыг олон улсын харилцаанд оршин байгаа заншилтай нийцүүлэх ёстойн үүднээс л байгаа” гэж үздэг.²⁶

Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуульд (Аравдугаар зүйлд) үндэсний болон олон улсын эрх зүйн уялдаа холбооны талаар “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” хэмээн тодорхойлжээ. Харин зарим тохиолдолд эргэлзээ бүхий байдал үүсдэг.²⁷

Энэ хуулийн дээрх зүйлийг үндэслэн Монгол Улсын хууль тогтоомжид императив хэм хэмжээ хэмээн нэрлэгдэх “Монгол Улсын нэгдэн орсон улсын улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн диспозитив зохицуулалтыг тусгасан байх нь бий.²⁸ Хэрэв Монгол Улсын олон улсын гэрээний заавал биелэгдэх шинж нь үгүйсгэгдсэн, эсвэл уул гэрээнээс гарсан бол холбогдох харилцааг зохицуулсан дотоодын хууль тогтоомжийг баримтална. Ийнхүү императив хэм хэмжээнээс диспозитив хэм хэмжээ үүсч болохыг үгүйсгэх аргагүй. Зарим нь төрийн онолын үүднээс “олон улсын эрх зүйн зохицуулалтыг үндэсний эрх зүйгээс дээгүүр тавьсны илрэл мөн” гэж үзжээ.²⁹

Энэ утгаараа, үндэсний эрх зүйн хэм хэмжээ олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэн бий болох гол нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээ эргээд үндэсний эрх зүйн хэм хэмжээнд нөлөөлдөг гэж үздэг.³⁰ Түүнчлэн зарим Үндсэн хууль олон улсын эрх зүйг дотоодын эрх зүйгээс (энэ нь тухайн улсын соёрхон баталсан хуулиас гадна олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудад хамаатай) дээгүүрт тавьдаг. Олон улсын эрх зүйн хүний эрхийн талаарх хэм хэмжээг тухайн улс өөрийн хууль тогтоомждоо багтаасан бол тухайн хэм хэмжээ улсын дотоодын эрх зүйгээр дамжин үйлчилж (олон улсын эрх зүйн холбогдох баримт бичгүүдэд гарын үсэг зурж соёрхон баталсан улсуудад ингэж үйлчлэхээр ихэнхдээ заасан байдаг) болно.³¹ Түүхэн байр сууринаас үзвэл олон улсын эрх зүй, үндэсний эрх зүйн харьцааны талаар хоёр үндсэн урсгал (үзэл баримтлал) бий.³²

25 Номынбаясгалан С., Үндсэн хуулийн маргаан: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, Уб., 2018, 74 дэх тал, (МУҮХЦ, Тогтоол №01/1993.01.13., ТМ 1993 он №02)–ын хянавал/үндэслэлээс дэлгэрүүлж үзнэ үү.

26 Лундэндорж Н., Jurisprudence/Эрх зүй судлал: философи – онол, Уб., 2011, 84 дэх тал

27 Жишигээр, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд 1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэргэ үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бүснцуулахыг хатуу хориглоно; гэж заажээ. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 1 дүгээр сарын 5–ны өдөр НҮБ–ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 15–ны өдрийн 44/128 тоот тогтоолоор батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орсон. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2012, №17 дугаарт нийтлэгдсэн. Чухамдаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг халах нь зохистой гэснийг онцлон тэмдэглэж, цаазаар авах ялыг халахад чиглэсэн бүхий л арга хэмжээ нь хүний амьд явах эрхийг хангах баталгаа болох ёстойг ухамсарлаж, цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын өмнө хүлээхийг хүсэж хэлэлцэн тохиролцсон гэж ойлгогддог.

28 Эрх зүйн нэгдсэн мэдээллийн систем дэх хуулийг судалсан болно. <http://www.legalinfo.mn/law/?cat=27>

29 Лундэндорж Н., Төрийн онол (Theory of State), Уб., 2005, 56 дахь тал

30 Олон улсын нийтийн эрх зүй, (Гарын авлага), Уб., 2007, 77 дахь тал

31 Цоетоо Ш., Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй, Уб., 2018, 165 дахь тал

32 Үүнийг дуализм, монизмын онол хэмээдэг. Монизмын онол дотроо олон улсын эрх зүй давуу, үндэсний эрх зүй давуу гэсэн хоёр чиглэлтэй. Дуализмын онолоор олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь бие биеэсээ тусдаа, үл хамааран оршиж байдаг. Ийнхүү үзэхдээ зохицуулах объект, эрх зүйн харилцааны субъект, эрх зүйн эх сурвалж өөр гэдгийг иш үндэс болгодог. Гэхдээ энэ үзлийг баримтлагчид олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь бие биедээ огт хуртээлгүй, ерөөс ямар ч хэлхээ холбоо байхгүй зүйл гэж үздэггүй. Үндэсний эрх зүйн хэм хэмжээг бий болгоход олон улсын эрх зүйгээс авч болно, олон улсын эрх зүй хэрэгжиж биеллээ олохын тулд үндэсний эрх зүйгээс дэмжлэг авна гэж үздэг. Монизмын онолоор олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь эрх зүйн нэг бүхэл бүтэн систем бөгөөд тодорхой нөхцөл байдлаас хамааран олон улсын эрх зүй, эсвэл үндэсний эрх зүйг дээдлэх

Тэгвэл эдгээр үзэл баримтлалыг олон улсын эрх зүйн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл, Монист онол (**monist theory**) олон улсын болон үндэсний эрх зүйн хоёр систем нь нэгдсэн нэг систем гэж үздэг. Харин дуалист онол (**dualist theory**) дээрх хоёр хуулийн системийг тус тусдаа бие даасан хоёр хуулийн систем гэсэн байр суурийг илэрхийлдэг ба уг хоёр систем нь зэрэгцээ шугамаар хөгжиж ирсэн гэж үздэг. Ингэхдээ үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг бий болгоход энэ хоёр систем бие даасан байдаг боловч хуулийг хэрэглэх үед харилцан нягт уялдаа холбоотой болдог хэмээн номлодог.³³ Асуудлыг хэлэлцэх үед үндэсний эрх зүйн тогтолцоо нь дуалист, эсхүл монист урсгалд багтаж байгаагаас хамааран тухайн улсын хууль тогтоомжийн харилцан уялдааны асуудал хөндөгддөг гэж үздэг.³⁴ Үнэн хэрэгтээ дуалист монист хандлага нь олон улсын гэрээг шүүхэд хэрхэн хэрэглэх арга зүй биш харин олон улсын гэрээний хэм хэмжээг дотоодын шүүхэд эрх зүйн эх сурвалжийн хувьд хэрхэн үнэлэх талаар гаргасан шийдэл гэж үзэж болно. Энэ ямар шийдэл вэ гэдэгт тухайн улсын эрх зүйн эх сурвалж тэр дундаа үндсэн хууль хариулт өгдөг.³⁵

Зарим бүтээлд “Олон улсын гэрээг хүчингүйд үзэх үндэслэлүүдийн дотор олон улсын гэрээ байгуулах улсын бүрэн эрх зөрчигдөх явдал тодорхой байр эзэлдэг. Олон улсын гэрээний хууль ёсны эсэхийг тогтооход улсын дотоодын хууль тогтоомжийн заалт хамаагүй мэтээр үзэж болохгүй. Улс бүр олон улсын гэрээ байгуулахтай холбогдсон зүйлийг үндсэн хуульдаа тусгасан байдаг. Хэрэв үндсэн хуулийн энэ зүйл олон улсын гэрээ байгуулахад илт зөрчилдсөн байвал тэр олон улсын гэрээг тухайн улс хүчингүйд үзэх эрхтэй байна. Энэ талаар зөвлөлтийн хуульчид бичихдээ <<Ийнхүү онол, практикийн аль алинд үндсэн хуулийн заалтыг биелүүлэх явдал бол олон улсын гэрээ хуулийн хүчинтэй байхын зайлшгүй шаардлага юм. Энэ шаардлагыг зөрчиж байгуулсан олон улсын гэрээ нь шинж чанараараа тэгш бус, хүчингүй гэрээ байх болно. Иймээс ийм гэрээг холбогдох улс дуртай цагтаа цуцалж болно>> гэжээ.³⁶ Энэ үндэслэл олон улсын гэрээний хууль зүйн тухай Венийн конвенцын 46 дугаар зүйлд бататгагдаж орсон байна” гэсэн дүгнэлтийг хийсэн байна.³⁷

Олон улсын гэрээний тухай хуулийн Монгол Улсын дэлгэрэнгүй тайлбарт “Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын талаар хоёр онол байдаг. Нэг нь “дуализм” буюу олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй хоёр хоёлаа эрх зүйн бие даасан тусдаа салбар. Энэ онолын хүрээнд олон улсын эрх зүй нь дотоодын эрх зүйд шууд хамааралгүй байдаг тул олон улсын аливаа гэрээг дотоодын хууль тогтоомждоо авч тусгах хэрэгтэй болно. Нөгөө онол нь “монизм” буюу олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй нь нэг салбар бөгөөд бүх эрх зүй нь нийтлэг нэг норматив шинжтэй гэж ойлгодог. Иймд олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжид тусгах шаардлагагүй болж байгаа юм. Монгол Улс энэ хоёр онолын монизм гэдэгт багтаж байна. Учир нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тодорхой заасан нь нэгэнт олон улсын олон талт гэрээнд нэгдэн орсон тохиолдолд олон улсын гэрээнээс дотоодын хууль тогтоомжид тусгайлан авч тусгах шаардлагагүй болж байгаа юм” гэсэн дүгнэлтийг хийсэн байна.³⁸ Энэ талаар монист зарчмын³⁹ үүднээс тайлбарлаж болохоор байна.

(давуу байх) ёстой. Амарсанаа Ж. “Ардчилсан эрх зүйт ёс” Уб., 2009, 233–234 дэх тал

33 Олон улсын харилцааны үндэс ба даяаршил, (Анхны хэвлэл) Уб., 2016, 180 дахь тал

34 Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт, Уб., 2014, 27 дахь тал

35 <http://nli.gov.mn/?p=4384>

36 Курс международного права, Том IV, Изд – во <<Наука>> М, 1967 г, стр 179

37 Нямдоо Г., Олон улсын гэрээний зарим асуудал, Уб., 1979, Улсын хэвлэлийн газар, 63 дахь тал

38 Амарсанаа Ж., ба бусад Олон Улсын гэрээний эрх зүйн тухай Монгол Улсын дэлгэрэнгүй тайлбар Уб 2011, 35–36 дахь тал

39 Төрийн үүслийн талаархи (2) онол, үзэл баримтлал бий. Монист зарчим нь “төр улсын үүслийг бүхэлд нь нэг хүчин зүйлээр тайлбарлахыг оролддог” гэж үздэг. Лүндэндорж Н., Төрийн онол (Theory of State), Уб., 2008, 82 дахь тал

Үндсэн хуульд тэгш байдлыг хангах асуудлыг тусгасан нь

Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн (14.2.) заалт тэгш эрхийн агуулгыг илэрхийлээд зогсохгүй, түүний гол баталгаа нь болж байна.⁴⁰ Энэ заалтад “бэлгийн чиг баримжаа”, “хөгжлийн бэрхшээл” зэргийг тухайлан заагаагүй боловч тэгш эрхийн ерөнхий үзэл баримтлалын хүрээнд эдгээр “онцлог шинж”-ээр нь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглодог. Үүний үндсэн хуулийн үндэслэл нь “тэгш байдал” гэж үзээд тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай холбон тайлбарлаж ирсэн байна.⁴¹ Зарим улс (ХБНГУ)-д “үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим”⁴² гэж нэрлэдэг. Ийнхүү “Тэгш байдлыг хангах нь эрх чөлөөг хангах зарчмаас эх үндэстэй учраас эрх, эрх чөлөөг хангасан цагт тэгш байдал хангагдана” гэж үздэг.⁴³ Тэгш эрхийг (хүн бүрд эрх тэгш хандах) хэрэгжүүлэхийн тулд тэгш байдлын (адил тэгш хүмүүст адил тэгш, адил тэгш бус хүмүүст адил бус хандах) зарчим хэрэгжих ёстойг харуулдаг.⁴⁴ Энэ нь тэгш байдал “тэнцүү боломж” олгодог гэж үзэж болох юм. Иймд үндсэн хуульд “хөгжлийн бэрхшээл” гэж шууд нэрлэн тусгагдаагүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд (Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн конвенцод заасан эрх “үндсэн эрх”-ийн түвшинд хамгаалагдана⁴⁵ гэсэн үг) тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн “бусдын нэгэн адил” эдлэх, хамгаалуулах боломжтой юм.⁴⁶ Үүнээс гадна энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн (2018 оны) судалгаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар үндсэн хуулиар заагдсан хүний эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан нь “хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх утгыг бүрэн дүүрэн илэрхийлж өгсөн” байна”⁴⁷ гэж тэмдэглэсэн байна. Албан ёсны статистикийн мэдээлэл буюу нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамааруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлж, тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, харин амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна.⁴⁸

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн

40 Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, (Хянасан: Сөвд Г., Жамбалдорж О.), Уб., 1993, 61 дэх тал (Цаашид “Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

41 Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, Арван дөрөвдүгээрийн 1 дэх хэсэгт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш гэж тус тус заасан. Эдгээр заалт нь хүн бүрийн амьдрал адилхан чухал, хүн бүр хувь хүнийхээ хувьд адил үнэ цэнэтэй, хүн бүрт бүрд хүний ёсоор хандах үзэл санааг илэрхийлдэг. Мөн түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 болон 26 дугаар зүйлд заасан хүн бүрийн шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрх “энэ” хүрээнд хамаарна.

Энхбаатар Ч., Амаржаргал П., Батчимэг М., Даваадулам Ц., Мөнхсайхан О., Солонго Д., Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Уб., 2016, 46 дахь тал (Цаашид “Энхбаатар Ч., Амаржаргал П., Батчимэг М., Даваадулам Ц., Мөнхсайхан О., Солонго Д., Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

42 Сүнжид Д., ХБНГУ-ын Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим, Эрх зүйн үзэл баримтлал: Шинэ хандлага, (Эрдэм шинжилгээний илтгэлийн эмхэтгэл), Уб., 2012, 49 дэх тал (Цаашид “Сүнжид Д., Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

43 Энхбаатар Ч., Үндсэн хуулийн эрх зүй, Уб., 2007, 120–121 дэх тал

44 Агар-Эрдэнэ Г., Банзрагч Л., Эрх зүйн философи, (Гарын авлага), Уб., 2013, 62–63 дахь тал

45 Монгол Улс дахь үндсэн эрхийн хүрээ нь үндсэн хуульд “нэрлэгдсэн” болон “нэрлэгдээгүй” эрхээр тодорхойлогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Иймд үндсэн хуульд томъёологдоогүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг (үндсэн хуульд дурдагдаагүй учраас хамгаалагдахгүй гэж үзэж болохгүй) Монгол Улсад байгаа бүх хүн нэгэн адил эдлэх, хамгаалуулах боломжтой гэж үздэг.

46 Энхбаатар Ч., Амаржаргал П., Батчимэг М., Даваадулам Ц., Мөнхсайхан О., Дурдсан бүтээл, 47 дахь тал

47 Хууль зүйн судалгааны төв, Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Судалгааны тайлан, Уб., 2018, 8 дахь тал <http://nli.gov.mn/?p=4411>

48 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, (Мэдээллийн лавлах), Уб., 2019, 12 дахь тал, <http://www.mls.gov.mn/uploads/news/files/ebd75d51031049df68dc58d9242d2ff55d31b9aad.pdf>

зөвшөөрөгдсөн эрхийг үндэс угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гэж тусгагдсан байна. Ийнхүү үндсэн хууль болоод олон улсын гэрээгээр баталгаажсан “хүн бүр ялгаварлан гадуурхагдахгүй байх” зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл журмыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна. Үүнийг бас хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах (**Disability Equality**) гэж нэрлэж болох юм. Улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн (цаашид “ХБХЭТК” гэх) талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлд “Үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлан ялгаварласан заалт одоогоор байхгүй бөгөөд хуулийн хүрээнд тэгш хамгаалуулах, . . . зэрэг төрийн зүгээс үзүүлэх аливаа үйлчилгээнд тэгш хамрагдах боломж хуулиар нээлттэй байна” гэж тэмдэглэсэн байна.⁴⁹

Эмэгтэйчүүдийн эрх ба хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах асуудлыг антропологийн үүднээс судлах хэрэгцээ шаардлага:

Эмэгтэйчүүдийн эрх ба хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах асуудлыг улс төр, эрх зүйн талаас судалсан цөөнгүй судалгаа байгаа хэдий ч антропологийн арга зүйд суурилсан, тэр дундаа хууль зүйн антропологийн үүднээс хийгдсэн судалгаа хомс байна. Хууль зүйн антропологи нь XIX зууны дунд үеэс хөгжсөн бөгөөд нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсрын ижилсэл, ондоошлыг, нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг “антропологийн” болон “хууль зүйн” шинжлэх ухааны салбар дундын бие даасан хавсарга шинжлэх ухаан юм.⁵⁰ Энэ салбар шинжлэх ухааны үүднээс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Улс төрийн намын тухай хуулиуд дахь “эмэгтэйчүүдийн эрх ба хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал”-ыг хангах үзэл санаа, түүний хэрэгжилт, харилцан хамаарлын асуудлыг судалж үзсэн судалгаа хэвлэгдээгүй байна. Энэ нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг үндэсний хууль тогтоомжид тусгахдаа монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, монголчуудын сэтгэлгээ, хандлагад нийцүүлэн “монгол хөрсөнд” буулгаж чадсан уу, хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг Улсын төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байх уу гэх мэт асуулт түгээмэл тохиолдох боловч өнөөг хүртэл мэргэжлийн түвшинд хариултгүй байсаар байгаа нь “хууль зүйн антропологийн судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага” үгүйлэгдэж байгааг харуулж байна. Дээрх асуултад хууль зүйн “антропологийн” судалгааны үр дүн зохих хариултыг өгнө гэж үзэж байна.⁵¹

Жендэрийн ба хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлын хамаарал

Феминистуудын олон улсын харилцаанаас хайж буй үндсэн шийдэл бол дэлхийн улс төр, эдийн засгийн тогтолцоо эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж буй хийгээд энэ нөлөөг саармагжуулах ямар арга замууд байж болохыг илрүүлэх явдал юм.⁵² Ийнхүү жендэрийн тэгш бус байдлыг арилгах нь энх тайван хийгээд нийгмийн зүй ёсыг тогтооход чухал хувь нэмэртэй. Эрчүүд, эмэгтэйчүүд ижил тэгш оролцоотой байх нь үндэсний дотоод гадаад бодлого хийгээд олон улсын түвшний асуудлыг шийдвэрлэхэд

49 Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл, (1977–2014), (Турав дахь хэвлэл), Уб., 2014, 780 дахь тал

50 Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021, 5 дахь тал

51 Номынбаясгалан С., Улс төрийн намын тухай хуульд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг тодорхойлсон нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2021, №3, 56 дахь тал

52 Бямбажав Д., Олон улсын харилцаа ба феминист хандлага, Шинэ толь сэтгүүл, Уб., 2006, №54, 11 дэх тал

чухал⁵³ гэдгийг онцолдог. Феминист эрх зүй судлалд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг бий болгоход ихээхэн бэрхшээл учруулдаг зүйл бол үндэстнүүдийн соёлын нөлөө, зан заншил юм.⁵⁴

НҮБ-ын Дүрмийн 8 дугаар зүйлд “НҮБ –ын гол болон туслах чанарын байгууллагуудад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ямар ч албан тушаалд адил тэгш нөхцөлөөр оролцох эрхийн талаар тус байгууллага ямар нэгэн хязгаарлалт үл тогтооно” гэж заасан. Энэ заалт амлалт хэвээр үлдсэн гэж судлаачид бичсээр байна. Тухайлбал, олон улсын шүүхийн гишүүнээр эмэгтэй хүн зөвхөн нэг удаа сонгогдож байсан бөгөөд одоо хүртэл олон улсын хууль зүйн комиссын гишүүнээр нэг ч эмэгтэй сонгогдож ажиллаагүй байна. НҮБ –ын хүний эрхийн байгууллагад ч эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай бус байна. Гэтэл НҮБ –ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл үүнийг хэтэрхий өрөөсгөл төлөөлөлтэй хэмээн шүүмжилж байсан төдийгүй эрэгтэй гишүүдийг нэр дэвшүүлэхийг уриалж байсан гэдэг. Тийм ч учраас НҮБ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны тэгш эрхийг хангах талаар одоо ч анхаарахгүй төдийгүй, эрэгтэйчүүдийн дангаар ноёрхлыг далдуур дэмждэг гэсэн шүүмжлэлээс салаагүй байна.⁵⁵

Эмэгтэйчүүд болулсүндэстнийэдийн засгийн өсөлт, хөгжилтөд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн гэр бүлийн хүрээнд хоол хүнс, эрүүл мэнд, хүүхдийн сурлага боловсролд шууд оролцдог утгаараа тухайн гэр орон, нутаг дэвсгэртээ нөлөө нь байнгын шинжтэй учраас зөвхөн одоо цагаар зогсохгүй тэрхүү нөлөө нь ирээдүй ч ул мөрөө үлдээдэг онцлогтой гэж үздэг.⁵⁶ Засгийн газрын шинэчлэлийн асуудлаарх Дэлхийн 7 дугаар чуулганд “Улс төрийн үйл ажиллагаанд жендэрийн тэгш оролцоог хөндөхөд нилээд олон тооны улс парламент дахь эмэгтэйчүүдэд ногдох суудлын тоо өссөн хэдий ч жендэрийн тэнцвэртэй харьцаа бүрэн хангагдсан тийм улс дэлхий дээр хараахан байхгүй байна” гэсэн дүгнэлтийг хийв.⁵⁷

Жендэрийн тэгш байдлыг ханган эмэгтэйчүүдийн эрхийг өргөтгөх асуудал

Оролцоот хөгжил, ардчилсан засаглал бол Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх гол хүчин зүйл гэдгийг улам ихээр хүлээн зөвшөөрөх болов.⁵⁸ Мянганы хөгжлийн тунхаглалд хүний эрхийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох жендэрийн тэгш байдлыг хангаж эмэгтэйчүүдийн эрхийг өргөтгөх асуудлыг нэг мөр шийдвэрлэхээр заасан. Эмэгтэйчүүдэд эрх, эрх чөлөөг нь шударгаар хуваарилснаар Мянганы хөгжлийн зорилтуудад бодитойгоор хүрэх нэгэн чухал урьдчилсан нөхцөл бүрдэнэ гэж үздэг.⁵⁹ Ийнхүү тэдэнд тэгш эрх бололцоог олгох нь өмнө өгүүлсэн үүрэг оролцоог нь өргөтгөн бэхжүүлж хөндөн буй ядуурал, өлсгөлөн, өвчин эмгэгийг устгах том зорилтуудад хүрэх үйл явцыг товчилж хөгжлийг улмаар жинхэнэ ёсоор тогтвортой болгоход зохих түлхэц үзүүлэх нь дамжиггүй.⁶⁰

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хууль тогтоомжид тусгасан байдал

53 Бямбажав Д., Олон улсын харилцаа ба феминист хандлага, Шинэ толь сэтгүүл, Уб., 2006, №54, 12 дахь тал

54 Лүндэндорж Н., Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, (Анхны хэвлэл), Уб., 2011, 109 дэх тал

55 Лүндэндорж Н., Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, (Анхны хэвлэл), Уб., 2011, 110 дахь тал

56 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал: Үндсэн сэдэв ба шилдэг турлилага, (Засгийн газрын шинэчлэлийн асуудлаархи Дэлхийн 7 дугаар чуулган), Уб., 2008, 37 дахь тал

57 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал: Үндсэн сэдэв ба шилдэг турлилага, (Засгийн газрын шинэчлэлийн асуудлаархи Дэлхийн 7 дугаар чуулган), Уб., 2008, 38 дахь тал

58 Массимо Томмасоли (Massimo Tommasoli), Төлөөллийн ардчилал ба хариуцлагатай улс төр бий болгох чадавхийг хөгжүүлэх нь, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар, Уб., 2008, 52 дахь тал

59 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал: Үндсэн сэдэв ба шилдэг турлилага, (Засгийн газрын шинэчлэлийн асуудлаархи Дэлхийн 7 дугаар чуулган), Уб., 2008, 37 дахь тал

60 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал: Үндсэн сэдэв ба шилдэг турлилага, (Засгийн газрын шинэчлэлийн асуудлаархи Дэлхийн 7 дугаар чуулган), Уб., 2008, 37 дахь тал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн Есдүгээр бүлэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх” гээд 29 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг зохицуулсан байна. Энэ зүйлд “29.1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: гээд 29.1.1. хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх; 29.1.2. хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах; 29.1.3. гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх; 29.1.4. гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх” гэж заасан байна.

Харин Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн зарим олон улсын гэрээнд тухайлбал, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай **конвенцын 3** дугаар зүйлд “Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэх баталгааг олгох зорилгоор тэдний бүрэн хөгжил, дэвшлийг хангахын тулд бүхий л салбарт, тухайлбал, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авна” гэж, мөн **конвенцын 7** дугаар зүйлд “Оролцогч улсууд тухайн улсын улс төр, олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс зохистой бүхий л арга хэмжээг авна, тухайлбал, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд дараахь эрхээр хангана гээд (а) бүх сонгууль, ард нийтийн санал хураалтад санал өгөх болон нийтээр сонгох бүх байгууллагад сонгогдох; (b) төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох . . .” гэж, мөн **конвенцын 15 дугаар зүйлд** “Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд хуулийн өмнө эрэгтэйчүүдтэй тэгш байх эрх олгоно” тус тус зохицуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын **конвенцын 3** дугаар зүйлд “Энэхүү конвенцийн зарчмууд нь: е) тэгш боломж олгох; . . . g) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх; . . .” гэж, мөн **конвенцын 6** дугаар зүйлд “1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид нь давхар алагчилалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулан тэдэнд хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна. 2. Оролцогч улсууд нь энэхүү конвенцид заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохих бүхий л арга хэмжээг авна” гэж, мөн **конвенцын 12 дугаар зүйлд** “1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна” гэж, мөн **конвенцын 29 дүгээр зүйлд** “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараахь үүрэг хүлээнэ: гээд а) бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараахь хэлбэрээр хангана: гээд (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх . . . , b) хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх үндсэн дээр ямар нэг алагчилалгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжиж, тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог дараахь хэлбэрээр дэмжих: гээд (i) улс орны улс төрийн болон төрийн хэрэг, . . . үйл ажиллагаанд оролцох;" гэж заасан байна.⁶¹

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Эцэст нь тэмдэглэхэд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэх баталгааг олгох зорилгоор тэдний бүрэн хөгжил, дэвшлийг хангахын тулд бүхий л салбарт, тухайлбал, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авах тухай гэж тус тус зохицуулсан байна. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн "29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэсэн зохицуулалтын "нийгэм гэсний дараа ", улс төрийн"" гэсэн нэмэлтийг оруулах саналтай байна.

IV. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 1/ Лүндэндорж Н., Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, (Анхны хэвлэл), Уб., 2011
- 2/ Номынбаясгалан С., Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг Улс төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байх уу?, Улс төрийн намын тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийн хүрээнд, Төрийн байгуулал судлал, Уб., 2021, №3
- 3/ Номынбаясгалан С., Цар тахал ба иргэдийн сонгуулийн ирц, оролцооны асуудал, Шинэ толь сэтгүүл, Уб., 2020, №81
- 4/ НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал: Үндсэн сэдэв ба шилдэг туршлага, (Засгийн газрын шинэчлэлийн асуудлаархи Дэлхийн 7 дугаар чуулган), Уб., 2008
- 5/ Массимо Томмасоли (Massimo Tommasoli), Төлөөллийн ардчилал ба хариуцлагатай улс төр бий болгох чадавхийг хөгжүүлэх нь, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар, Уб., 2008
- 6/ Бямбажав Д., Олон улсын харилцаа ба феминист хандлага, Шинэ толь сэтгүүл, Уб., 2006, №54
- 7/ Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021

61 <https://mlsp.gov.mn/uploads/files/186924b7c9448142182ac9ad7d5598b4187d7c00.pdf>

IV.ХАВСРАЛТ

Хавсралт – 1

Монгол Улсын хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр /1989 оноос 2021 он хүртэл/⁶²

Хүйс	Насны бүлэг	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүгд	Бүгд	2,760,968	2,811,666	2,867,744	2,930,277	2,995,949	3,057,778	3,119,935	3,177,899	3,238,479	3,296,866	3,357,542
	0-4	276,321	288,129	305,258	319,422	345,968	386,866	394,514	393,984	391,125	385,681	381,639
	5-9	228,193	222,256	231,805	248,674	271,346	298,808	322,575	341,311	358,379	373,012	388,928
	10-14	248,224	237,733	237,751	234,216	224,132	219,332	220,429	232,601	252,548	279,299	299,512
	15-19	275,828	260,952	252,710	253,439	244,337	239,910	236,400	233,001	228,402	223,078	219,508
	20-24	305,891	315,540	309,393	298,383	278,214	267,844	255,144	244,980	244,971	239,604	236,839
	25-29	260,640	280,465	287,776	298,203	305,778	313,709	314,540	310,730	294,550	277,392	264,277
	30-34	234,435	248,370	252,204	255,161	257,858	263,538	273,997	283,360	295,098	304,728	310,085
	35-39	212,991	225,425	228,657	233,392	233,392	232,634	236,622	241,307	244,225	251,684	260,361
	40-44	188,396	192,568	197,184	201,152	208,711	208,439	214,112	217,532	221,914	224,191	228,355
	45-49	164,611	168,908	171,718	176,018	178,475	178,411	181,405	186,765	191,780	198,122	202,734
	50-54	126,740	128,834	137,432	144,970	154,443	152,601	159,075	161,016	164,214	165,647	171,428
	55-59	77,400	82,449	89,643	96,870	108,144	115,125	119,888	128,739	135,542	142,399	144,036
	60-64	52,405	52,399	55,896	58,876	66,563	65,496	73,940	79,856	87,790	96,433	106,144
	65-69	41,151	39,965	39,354	40,373	42,307	43,089	43,711	47,326	50,307	55,279	58,377
	70+	67,742	67,673	70,963	71,128	76,281	71,976	73,583	75,391	77,634	80,317	85,319
Эрэгтэй	Бүгд	1,342,081	1,364,723	1,393,453	1,425,843	1,466,455	1,503,612	1,533,983	1,562,370	1,591,848	1,619,573	1,648,979
	0-4	140,006	146,292	154,772	162,383	176,583	198,115	201,936	202,282	200,715	198,005	195,957
	5-9	115,518	112,623	117,201	125,866	137,336	152,485	164,768	174,304	183,100	190,812	199,072
	10-14	125,645	120,084	119,963	118,223	113,306	111,675	112,576	118,653	128,855	142,513	152,788
	15-19	137,353	129,957	125,525	125,977	122,289	121,780	119,966	118,408	116,247	113,464	111,747
	20-24	149,261	154,492	151,936	147,194	138,277	135,073	128,877	123,701	123,951	120,958	119,766

62 https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=1_2_3&AGE_GROUPS_select_all=0&AGE_GROUPSSingleSelect=1_6_7_8_9_10_11_12_13_14_15_16_5_4_3_2&YearY_select_all=0&YearYSingleSelect=2020_2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012_2011_2010&viewtype=table

Хүйс	Насны бүлэг	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	25-29	125,481	135,782	140,633	145,593	150,842	157,118	157,575	155,846	147,740	139,284	132,802
	30-34	113,540	119,618	121,895	123,525	126,832	130,591	136,030	140,867	146,913	151,725	154,702
	35-39	102,520	107,727	109,981	112,810	114,170	114,492	116,417	118,861	120,394	124,138	128,212
	40-44	89,458	91,426	94,001	96,267	101,320	100,801	103,502	105,370	107,578	108,904	111,300
	45-49	78,030	79,741	81,051	82,948	84,934	84,610	86,238	88,673	91,409	94,545	96,633
	50-54	59,482	60,367	64,039	67,890	72,471	71,155	74,040	74,828	76,170	76,596	79,541
	55-59	35,968	37,969	41,126	44,371	49,511	51,524	53,671	57,844	61,015	64,109	65,015
	60-64	23,473	23,194	24,881	26,168	29,526	28,448	32,125	34,356	37,601	41,536	45,480
	65-69	18,662	17,906	17,477	17,571	18,066	17,781	17,837	19,410	20,586	22,645	23,967
	70+	27,684	27,545	28,972	29,057	30,992	27,964	28,425	28,967	29,574	30,339	31,997
Эмэгтэй	Бүгд	1,418,887	1,446,943	1,474,291	1,504,434	1,529,494	1,554,166	1,585,952	1,615,529	1,646,631	1,677,293	1,708,563
	0-4	136,315	141,837	150,486	157,039	169,385	188,751	192,578	191,702	190,410	187,676	185,682
	5-9	112,675	109,633	114,604	122,808	134,010	146,323	157,807	167,007	175,279	182,200	189,856
	10-14	122,579	117,649	117,788	115,993	110,826	107,657	107,853	113,948	123,693	136,786	146,724
	15-19	138,475	130,995	127,185	127,462	122,048	118,130	116,434	114,593	112,155	109,614	107,761
	20-24	156,630	161,048	157,457	151,189	139,937	132,771	126,267	121,279	121,020	118,646	117,073
	25-29	135,159	144,683	147,143	152,610	154,936	156,591	156,965	154,884	146,810	138,108	131,475
	30-34	120,895	128,752	130,309	131,636	131,026	132,947	137,967	142,493	148,185	153,003	155,383
	35-39	110,471	117,698	118,676	120,582	119,222	118,142	120,205	122,446	123,831	127,546	132,149
	40-44	98,938	101,142	103,183	104,885	107,391	107,638	110,610	112,162	114,336	115,287	117,055
	45-49	86,581	89,167	90,667	93,070	93,541	93,801	95,167	98,092	100,371	103,577	106,101
	50-54	67,258	68,467	73,393	77,080	81,972	81,446	85,035	86,188	88,044	89,051	91,887
	55-59	41,432	44,480	48,517	52,499	58,633	63,601	66,217	70,895	74,527	78,290	79,021
	60-64	28,932	29,205	31,015	32,708	37,037	37,048	41,815	45,500	50,189	54,897	60,664
	65-69	22,489	22,059	21,877	22,802	24,241	25,308	25,874	27,916	29,721	32,634	34,410
	70+	40,058	40,128	41,991	42,071	45,289	44,012	45,158	46,424	48,060	49,978	53,322

Хүйс	Насны бүлэг	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Бүгд	Бүгд	2,373,493	2,403,105	2,432,397	2,465,657	2,495,091	2,521,733	2,551,081	2,583,254	2,620,446	2,665,955	2,716,275
	0-4	246,023	230,273	228,703	227,994	230,716	233,180	235,893	216,960	232,963	247,698	263,186
	5-9	285,664	267,504	255,618	264,648	267,807	270,667	273,818	243,465	246,879	240,358	233,139
	10-14	317,434	314,253	311,938	312,107	315,837	319,207	322,924	276,262	269,186	262,156	253,856
	15-19	263,358	276,123	282,865	288,606	292,054	295,168	298,606	307,890	306,703	297,965	286,918
	20-24	235,751	248,994	255,334	262,002	265,130	267,961	271,080	257,726	265,674	280,924	296,937
	25-29	216,652	219,423	224,839	227,669	230,389	232,848	235,558	224,551	231,123	238,304	249,737
	30-34	187,872	190,256	192,949	195,815	198,152	200,269	202,598	211,470	215,578	220,314	229,054
	35-39	172,606	172,291	176,967	178,905	181,042	182,973	185,103	190,864	193,898	197,863	206,788
	40-44	127,220	139,129	145,158	146,413	148,161	149,743	151,485	175,113	175,188	178,823	181,803
	45-49	82,888	90,069	99,163	100,330	101,524	102,612	103,804	147,546	151,765	155,847	161,242
	50-54	57,835	66,853	68,214	68,424	69,239	69,978	70,793	102,683	103,642	111,691	116,687
	55-59	55,895	57,098	57,272	57,338	58,022	58,643	59,323	68,566	69,163	72,471	76,029
	60-64	42,292	46,152	47,348	48,744	49,324	49,851	50,433	52,542	50,679	51,559	50,658
	65-69	35,415	35,110	35,428	36,047	36,476	36,867	37,295	43,330	43,739	44,263	44,186
	70+	46,588	49,577	50,601	50,615	51,218	51,766	52,368	64,286	64,266	65,719	66,055
Эрэгтэй	Бүгд	1,177,981	1,190,244	1,204,702	1,223,235	1,237,838	1,251,052	1,265,614	1,259,653	1,277,249	1,301,305	1,328,140
	0-4	124,482	116,370	115,498	113,584	114,939	116,168	117,519	109,435	117,838	125,642	133,924
	5-9	144,315	135,082	129,340	131,608	133,178	134,600	136,168	122,971	124,720	121,329	118,564
	10-14	159,294	157,638	156,627	156,449	158,320	160,007	161,872	138,632	135,581	132,336	129,289
	15-19	133,327	138,299	141,549	146,876	148,631	150,215	151,965	152,143	151,895	149,006	143,854
	20-24	118,023	122,458	126,174	131,979	133,554	134,981	136,551	125,025	128,555	136,897	144,577
	25-29	107,962	108,765	111,039	113,080	114,430	115,652	116,998	108,903	112,110	115,381	121,034
	30-34	92,473	93,564	95,456	97,441	98,604	99,657	100,817	102,855	104,712	107,024	111,169

Хүйс	Насны бүлэг	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
	35-39	84,846	85,110	87,162	88,529	89,587	90,543	91,596	91,998	93,180	95,406	99,773
	40-44	62,619	68,428	71,301	72,210	73,074	73,853	74,712	83,822	83,740	85,762	86,705
	45-49	40,562	44,566	49,018	49,974	50,570	51,111	51,704	70,842	72,580	74,259	76,710
	50-54	27,707	32,615	33,235	33,393	33,790	34,151	34,549	49,675	49,558	53,022	55,668
	55-59	27,379	28,047	27,928	27,980	28,315	28,617	28,949	32,596	32,632	34,175	35,777
	60-64	20,778	22,377	23,026	22,753	23,023	23,271	23,541	24,496	23,479	23,704	23,281
	65-69	15,982	16,353	16,508	16,531	16,727	16,905	17,103	20,089	20,541	20,622	20,559
	70+	18,232	20,572	20,841	20,848	21,096	21,321	21,570	26,171	26,128	26,740	27,256
Эмэгтэй	Бүгд	1,195,512	1,212,861	1,227,695	1,242,422	1,257,253	1,270,681	1,285,467	1,323,601	1,343,197	1,364,650	1,388,135
	0-4	121,541	113,903	113,205	114,410	115,777	117,012	118,374	107,525	115,125	122,056	129,262
	5-9	141,349	132,422	126,278	133,040	134,629	136,067	137,650	120,494	122,159	119,029	114,575
	10-14	158,140	156,615	155,311	155,658	157,517	159,200	161,052	137,630	133,605	129,820	124,567
	15-19	130,031	137,824	141,316	141,730	143,423	144,953	146,641	155,747	154,808	148,959	143,064
	20-24	117,728	126,536	129,160	130,023	131,576	132,980	134,529	132,701	137,119	144,027	152,360
	25-29	108,690	110,658	113,800	114,589	115,959	117,196	118,560	115,648	119,013	122,923	128,703
	30-34	95,399	96,692	97,493	98,374	99,548	100,612	101,781	108,615	110,866	113,290	117,885
	35-39	87,760	87,181	89,805	90,376	91,455	92,430	93,507	98,866	100,718	102,457	107,015
	40-44	64,601	70,701	73,857	74,203	75,087	75,890	76,773	91,291	91,448	93,061	95,098
	45-49	42,326	45,503	50,145	50,356	50,954	51,501	52,100	76,704	79,185	81,588	84,532
	50-54	30,128	34,238	34,979	35,031	35,449	35,827	36,244	53,008	54,084	58,669	61,019
	55-59	28,516	29,051	29,344	29,358	29,707	30,026	30,374	35,970	36,531	38,296	40,252
	60-64	21,514	23,775	24,322	25,991	26,301	26,580	26,892	28,046	27,200	27,855	27,377
	65-69	19,433	18,757	18,920	19,516	19,749	19,962	20,192	23,241	23,198	23,641	23,627
	70+	28,356	29,005	29,760	29,767	30,122	30,445	30,798	38,115	38,138	38,979	38,799

Хүйс	Насны бүлэг	1979	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998
Бүгд	Бүгд	1,595,006	2,043,954	2,153,466	2,177,217	2,158,362	2,171,898	2,206,892	2,242,998	2,276,016	2,307,484	2,340,134
	0-4	263,534	324,856	340,633	335,026	318,770	293,792	275,666	260,200	245,148	233,844	236,701
	5-9	234,986	275,179	291,335	298,627	299,441	308,809	314,084	318,226	317,828	311,920	289,751
	10-14	207,713	255,646	260,968	261,280	258,612	259,277	266,867	275,060	285,685	294,987	306,484
	15-19	184,416	221,580	237,545	242,429	238,775	241,210	241,367	246,021	249,583	254,509	257,144
	20-24	130,104	196,052	209,207	208,563	208,490	212,493	222,876	225,858	232,535	234,998	238,412
	25-29	92,611	179,543	186,973	191,321	186,938	188,793	193,488	200,382	202,258	207,981	213,505
	30-34	77,046	135,284	153,333	156,575	162,570	168,344	179,339	179,067	185,445	186,497	189,718
	35-39	76,594	92,615	96,370	107,005	111,105	120,960	130,501	144,597	150,237	161,213	168,875
	40-44	64,798	70,390	73,621	73,655	76,653	79,472	86,318	88,980	100,184	107,081	117,620
	45-49	58,652	68,296	64,904	64,063	60,247	62,011	61,558	67,051	67,791	72,605	75,880
	50-54	45,547	55,430	59,474	59,787	61,490	60,652	62,068	57,870	57,766	55,813	57,961
	55-59	43,264	50,220	51,477	51,210	48,033	47,830	46,823	51,746	52,562	55,633	55,307
	60-64	36,659	36,235	39,094	39,331	41,589	43,134	44,889	42,953	43,194	41,455	41,732
	65-69	32,793	31,488	32,296	31,048	29,378	28,849	27,932	30,412	30,826	33,938	35,484
	70+	46,289	51,140	56,236	57,297	56,271	56,272	53,116	54,575	54,974	55,010	55,560
Эрэгтэй	Бүгд	798,868	1,020,669	1,073,647	1,085,404	1,075,995	1,082,495	1,096,797	1,114,370	1,129,848	1,145,568	1,161,666
	0-4	133,259	164,010	172,036	169,421	161,321	148,716	139,422	131,656	123,825	118,442	119,826
	5-9	119,153	139,287	147,084	150,691	150,976	155,734	156,910	159,311	159,256	156,130	146,284
	10-14	104,714	128,824	131,909	132,021	130,799	131,092	134,694	138,371	143,662	148,239	153,162
	15-19	93,889	112,509	119,445	121,901	120,157	121,404	121,521	124,158	125,896	128,515	129,481
	20-24	64,318	97,505	105,737	105,657	105,549	107,755	111,336	112,516	116,128	117,737	119,721
	25-29	45,546	88,747	93,054	94,985	92,778	93,809	96,244	100,251	101,161	103,746	106,518
	30-34	39,104	67,249	75,922	77,382	80,584	83,398	88,657	88,602	91,471	91,886	93,535
	35-39	39,784	46,614	47,943	53,469	55,039	59,872	64,284	70,834	73,450	79,049	83,200
	40-44	33,537	35,764	36,650	36,583	38,177	39,455	42,718	44,009	49,709	52,664	57,422
	45-49	30,121	35,413	33,237	32,512	30,433	30,983	30,420	32,983	33,238	35,711	37,288
	50-54	23,459	28,157	30,091	30,365	31,320	30,927	31,322	29,152	28,788	27,658	28,560
	55-59	21,216	24,569	25,138	25,127	23,737	23,763	23,121	25,559	25,995	27,693	27,635
	60-64	16,779	17,598	18,844	18,847	19,739	20,502	21,182	20,423	20,621	19,949	19,988

Хүйс	Насны бүлэг	1979	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998
	65-69	14,501	14,374	14,929	14,300	13,573	13,358	12,964	13,989	14,110	15,435	16,163
	70+	19,488	20,049	21,628	22,143	21,813	21,727	22,002	22,556	22,538	22,714	22,883
Эмэгтэй	Бүгд	796,138	1,023,285	1,079,819	1,091,813	1,082,367	1,089,403	1,110,095	1,128,628	1,146,168	1,161,916	1,178,468
	0-4	130,275	160,846	168,597	165,605	157,449	145,076	136,244	128,544	121,323	115,402	116,875
	5-9	115,833	135,892	144,251	147,936	148,465	153,075	157,174	158,915	158,572	155,790	143,467
	10-14	102,999	126,822	129,059	129,259	127,813	128,185	132,173	136,689	142,023	146,748	153,322
	15-19	90,527	109,071	118,100	120,528	118,618	119,806	119,846	121,863	123,687	125,994	127,663
	20-24	65,786	98,547	103,470	102,906	102,941	104,738	111,540	113,342	116,407	117,261	118,691
	25-29	47,065	90,796	93,919	96,336	94,160	94,984	97,244	100,131	101,097	104,235	106,987
	30-34	37,942	68,035	77,411	79,193	81,986	84,946	90,682	90,465	93,974	94,611	96,183
	35-39	36,810	46,001	48,427	53,536	56,066	61,088	66,217	73,763	76,787	82,164	85,675
	40-44	31,261	34,626	36,971	37,072	38,476	40,017	43,600	44,971	50,475	54,417	60,198
	45-49	28,531	32,883	31,667	31,551	29,814	31,028	31,138	34,068	34,553	36,894	38,592
	50-54	22,088	27,273	29,383	29,422	30,170	29,725	30,746	28,718	28,978	28,155	29,401
	55-59	22,048	25,651	26,339	26,083	24,296	24,067	23,702	26,187	26,567	27,940	27,672
	60-64	19,880	18,637	20,250	20,484	21,850	22,632	23,707	22,530	22,573	21,506	21,744
	65-69	18,292	17,114	17,367	16,748	15,805	15,491	14,968	16,423	16,716	18,503	19,321
	70+	26,801	31,091	34,608	35,154	34,458	34,545	31,114	32,019	32,436	32,296	32,677

Хавсралт - 2

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр /2003 оноос 2021 он хүртэл/⁶³

Хүйс	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Улсын дүн	37,934	39,900	42,583	43,560	44,709	45,296	45,235	57,310	45,957	45,980	47,190
Эмэгтэй											
Хүйс	2003	2004	2005	2006	2007	2008	2009				
Улсын дүн	27,989	30,386	33,656	32,924	33,001	35,192	37,079				
Эмэгтэй											

63 https://www.i212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3900_002171&SOUM_select=all=0&SOUMSingleSelect=0_183_182_181_185_184_265_264_263_262_267_261_342_345_344_348_346_343_341_421_422_423_5&SEX_select=all=0&SEXSingleSelect=1_3_2&YearY_select=all=0&YearYSingleSelect=2020_2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012_2011_20100&viewtype=table

Эмэгтэйчүүдийн эрх: Түүхэн хөгжил болон эрх зүйн баримт бичгүүд

Б.БОЛОРСАЙХАН

Хүний эрх хамгаалагч

1. Хүний эрхийг баталгаажуулсан түүхэн үйл явц

Дэлхийн дахинд өрнөсөн хүний эрхийн хөдөлгөөний үүсэл нь улс орон, ард түмний эрх чөлөөний хөдөлгөөн, түүхтэй уялдаатай байдаг. Ялангуяа хэмжээгүй эрх мэдлийг хязгаарлах, хүний амар амгалан, аюулгүй байдлыг хангах хэрэгцээнээс үүдэлтэйгээр эрт дээр үеэс санаачилга өрнөж байсныг өнгөрсөн түүхээс харж болно. Жишээлбэл, нийтийн тооллын өмнөх (НТӨ) 539 онд Эртний Персийн хаан Аугаа Кир Вавилон хотыг эзэлсэн хойно боолчлолыг халж, арьс үндсээс үл шалтгаалан хамтдаа зэрэгцэн амьдрах боломж олгосон төдийгүй шашны эрх чөлөөг баталгаажуулсан түүхтэй.¹ Энэхүү шинэчлэл нь Энэтхэг, Грек, Ром руу түгсэн, тухайн нийгмийн харилцаанд тусгалаа олж байсан жишээ бий. Тодруулбал, Эртний Ромын жам ёсны эрхийн тухай ойлголтыг ёс суртахуун, ёс зүйн талаас боловсруулах, цаашилбал нийгмийн хэм хэмжээ болоход нөлөөлжээ. Мөн Энэтхэгийн Маурын эзэнт гүрний Ашока хаан (НТӨ 268-232 он) чулуун хавтан, баганад бичиж, олонд таниулдаг байсан зарлигаар ард түмэндээ төрийн үйл хэрэгт оролцох, үл ялгаварлах, цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх, өршөөл үзүүлэх, эрүүл мэнд, хоол хүнс зэрэг нийгмийн халамжаар хангах зэрэг асуудлыг хуульчлан зохицуулж байсан туршлагатай билээ.² Тухайн үеийн хөрш улс, гүрэн – өнөөгийн Сири, Афганистан, Пакистан, Грек, Македон, Египет, Балба, Бенгал дахь ард түмэнд дам нөлөөлсөн ажээ.

Эдгээр улс дундаас хаант ёсыг халсан Ромын Бүгд Найрамдах Улс (НТӨ 509-27 он) нь Ромын эзэнт гүрэн болж, хожим нийтийн тооллын 258 онд зүүн, баруун гүрэнд хуваагдсан бөгөөд Дорнод эзэнт гүрэн 1453 онд нуран унах хүртэл оршиж байв. Ийнхүү жам ёсны эрхийн тухай үзэл санааг нэвтрүүлсэн гүрэн улсад эмэгтэйчүүд чөлөөт иргэний гэр бүлд төрж, өссөн тохиолдолд өөрийн овгийн нэрийг хадгалах, дамжуулах, хүүхдийн угсаагаа тооцуулах, инжээ захиран зарцуулах, гэрээслэл байхгүй үед охид, хөвгүүд нэгэн адил өв залгамжлагч болох, өмчтэй байх³, гэрээ байгуулах, аж ахуй эрхлэх эрхтэй байжээ. Эмэгтэйчүүд санал өгөх, төрийн үйл хэрэгт оролцох, цэрэг, улс төрийн алба хаших боломжгүй ч гурван хүүхэд төрүүлсэн тохиолдолд төрөөс дэмждэг байв.⁴

¹ Британийн музейн үзмэр, Кирийн бормого. Дэлгэрэнгүй: https://www.britishmuseum.org/collection/object/W_1880-0617-1941

² Ашока хааны зарлиг. Дэлгэрэнгүй: <https://www.cs.colostate.edu/~malaiya/ashoka.html>; Ven. S. Dhamikka, *The Edicts of King Ashoka*, Buddhist Publication Society, Kandy, Sri Lanka, 1993.

³ Severy, Beth (2002) *Augustus and the Family at the Birth of the Empire*. Routledge. p. 12. (ISBN 1-134-39183-8)

⁴ Johnston, David (1999) *Roman Law in Context*. Cambridge University Press. Ch. 3.3

Түүхэн баримтын зэрэгцээ хүний эрхийн талаарх эрх зүйн эх сурвалжийг нягтлан үзвэл Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас (ЮНЕСКО) дэлхийд өвд 2013 онд бүртгэсэн Леоны 1188 оны зарлиг (The Decreta or Decrees of León of 1188) дурдах нь зүйтэй.⁵ Дундад зууны үеийн Испанийн төрийн байгууллагад хаан, шашны мяндагтан, язгууртны хамт тосгон, хотоос сонгогдон гарсан энгийн ард шийдвэр гаргаж ажиллах боломжийг бүрдүүлсэн төр, захиргааны анхны загварыг тус баримт бичгээр бий болгосон юм.

Үүнээс улбаалан хожим боловсруулсан Британийн Магна Карта (1215)⁶, Эрх шаардах бичиг (1628)⁷, Английн Эрхийн жагсаалт (1689)⁸, Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) Үндсэн хууль (1787), Францын Хүний болон иргэний эрхийн тунхаглал (1789), АНУ-ын Эрхийн жагсаалт (1791) нь орчин цагийн хүний эрхийн тухай баримт бичгийн бичмэл эх сурвалжид тооцдог. Эдгээр баримт бичигт хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан хувь хүн бүр төрөлхөөсөө эрх чөлөөтэй, эрх эдлэх тухай үзэл санаа нь хожим үндсэн хуульт ёсыг бэхжүүлэх, улс орнууд өөрийн Үндсэн хуулиа боловсруулахад шилдэг туршлага байдлаар тусжээ. Өмнө дурдсан Кир хааны бортогон чулуун бичээсийн үгс нь 1948 онд баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) Хүний эрхийн түгээмэл тунхаглалын эхний дөрвөн зүйлд давтан буусныг харж болно. Эрт дээр үеэс улбаалан эмэгтэйчүүдэд эрх тэгш боломжийг олгосон, бүрдүүлсэн түүх маш ховор ч гэсэн Сэргэн мандлын үеийн соёлын нөлөөгөөр XVIII зуунаас хойш шашны сургаал, нөлөөнөөс ангид байдлаар олон нугачаа, бэрхшээл дунд эрх чөлөө, хүний эрх, феминист үзэл санаа улам боловсронгуй болсон нь хожим зарим улсад өрнөсөн эмэгтэйчүүдийн тэгш боломжийн төлөөх хөдөлгөөний хөрс суурь – хүний эрхийн хөдөлгөөний салшгүй нэг хэсэг билээ. Жон Лок XVII зуунд хааны эрх мэдлийг хязгаарлах, шашинд хүлээцтэй хандах, өмчийн жам ёсны эрхийг хамгаалах, XVIII зуунд Монтескье, Руссо зэрэг Францын сэтгэгчид эрх мэдлийг хязгаарлахын тулд чиг үүргийг зааглан эрх мэдлийг хуваарилах, Германы сэтгэгч Иммануэл Кант “рационал бодгаль бүрийг нэр төртэй гэж зөвшөөрөн эрх”-ийг хүндэтгэх философийн үзэл санааг түгээж, хувь хүний эрхийг хамгаалах хөдөлгөөн, хувьсгалыг эхлүүлсэн гэж болно.

Рационализм хөгжсөн учраас эрхийн асуудлыг хүн бүрд хамаатай гэж үздэг болсноор өмнө нь иргэн ч болж чаддаггүй байсан боол, түүнчлэн охид, эмэгтэйчүүд, барлаг, хамжлага гэж ялгах зааглахаа халж эхэлснээр сүүлд XIX зуунаас хүний эрх бол хүн бүрд хамаатай хэмээн хүлээн зөвшөөрдөг болсон байна. Хувь хүнийг хамгаалах, төрийн эрх мэдлийг хянах, хязгаарлах, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох, төр барих, нэр дэвших, санал өгөх зэргийг чухалчилж үзсэн нь өнөөдөр иргэний болон улс төрийн эрх хэмээн багцлан тодорхойлж хэвшжээ. Нийгэмд анги ялгарсан, ядуус байсан учраас тэднийг анхаарч, материаллаг орчныг сайжруулах шаардлагатай тулсан ба ард түмэн төрийг гар хумхин суух биш, заавал эерэг өөрчлөлт, ахиц дэвшил гаргах ёстой гэж шахдаг, зөвшөөрдөг болсон нь эдийн засаг, нийгэм, соёлын эрх гэж ай савыг үүсгэв. Сэргэн мандлын олон сэтгэгчид, тэдний рационал хандлага нь рационал бодгаль бүр эрх эдэлнэ гэсэн санааг уламжилж, Дэлхийн II дайны дараа 1948 онд Хүний эрхийн түгээмэл

5 ЮНЕСКО, Дэлхийн дурсамж, Бүртгэлтэй өвийн жагсаалт. Дэлгэрэнгүйг: <http://www.unesco.org/new/en/communication-and-information/memory-of-the-world/register/full-list-of-registered-heritage/registered-heritage-page-8/the-decreta-of-leon-of-1188-the-oldest-documentary-manifestation-of-the-european-parliamentary-system/>

6 Латинаар “Аугаа дүрэм” гэсэн утгатай баримт бичгийг Английн Жон хаан 1215 онд тулгарсан улс төрийн хямралын үеэр хаан ч гэсэн бусад хүний нэгэн адил хууль, шүүхийн өмнө адил тэгш байх зэрэг олон асуудлыг хүлээн зөвшөөрч, энхийн гэрээ хэлбэрээр тусгайлан заажээ. Дэлгэрэнгүйг: <https://www.bl.uk/magna-carta>

7 Хууль дээдлэх ёсыг дээдэлж, төрөөс хувь хүнийг хамгаалсан Английн үндсэн хуулийн шинжтэй баримт бичиг. Дэлгэрэнгүйг: <https://www.bl.uk/collection-items/the-petition-of-right>

8 Албан ёсоор “Тухайн этгээдийн эрх, иргэний эрх чөлөөг тунхаглаж, титэм залгамжлах асуудлыг зохицуулсан хууль” гэсэн нэртэй Эрхийн жагсаалт Английн үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэгт багтдаг. Дэлгэрэнгүйг: <https://www.britannica.com/topic/Bill-of-Rights-British-history>

тунхаглал боловсруулахдаа тусгасан төдийгүй энэ үзэл санаан дээр ч хожмын олон улсын гэрээ, пакт, конвенцыг баталсан ажээ.

Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс ХХ зуунд эрхэд суурилсан хандлага нэвтрүүлсэн явцаас эмэгтэйчүүдийн эрхийг⁹ баталгаажуулсан ахиц дэвшил гарсан байна. Хүний эрхийн хэм хэмжээг боловсруулах, баталгаажуулах, шинэ жишиг, хэм хэмжээ тогтооход олон улсын хамтын нийгэмлэгийн оролцоо, идэвх санаачилга маш үр дүнтэй байна.

Мөн 1950-1960 -аад он хүртэл эдийн засгийн хөгжлөөс нийгмийн хөгжил рүү голчлон анхаарсан бол 1980-1990 -ээд оны хооронд хүний төвтэй, зохистой хөгжлийн асуудалд анхаарах болжээ. Энэхүү өөрчлөлт нь нийгмийн асуудал, түүнд тохирсон шийдлийг олох, бодлогыг өөрчлөх, нийгмийн үйлчилгээнд төрөөс олгох төсвийг нэмэгдүүлэх, санаа бодлыг өөрчлөх компанит ажил зохион байгуулах, хөгжлийн төлөөх байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагааг үр нөлөөтэй болгосон байна.¹⁰

Хүснэгт №1. Эрхэд суурилсан хандлагын түүх

1920	Үндэстнүүдийн лигийн Хүүхдийн эрхийн тунхаглал ¹¹ (Женевийн) (1924)			
1940	НҮБ-ын Дүрэм: энх тайван, хүний эрх, хөгжил (1945) НҮБ-ын Эмэгтэйчүүдийн нөхцөл байдал хариуцсан комисс (1945) Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)			
1950	Хүйтэн дайн	Иргэний болон улс төрийн эрх	Эдийн засаг, нийгэм, соёлын эрх	Эдийн засгийн хөгжил
1960		НҮБ-ын Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1952)	НҮБ-ын Гэрлэсэн эмэгтэйчүүдийн харьяаллын тухай конвенц (1952)	
1970		Эмэгтэйчүүдийн төлөөх НҮБ-ын арван жил (1975-1985) НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)		Хүн төвтэй хөгжил
1980		Хөгжих эрхийн тунхаглал (1986)		
1990	Хүний эрхийн тухай Венийн бага хурал: хүний эрх, хөгжил хамтдаа (1993) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал (1993) Копенгагены дээд хэмжээний уулзалт (1995) Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөр (1995) НҮБ-ын шинэчлэл: эрхэд суурилсан хөгжил (1997) Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа (1998)			
2000	Амартья Сен: Хөгжил эрх чөлөө болох нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн илтгэл: Хүний эрх ба хөгжил Мянганы хөгжлийн зорилтууд (2000-2015) НҮБ-ын шинэчлэл: хөгжил, удирдлага, энх тайван, аюулгүй байдал (2017) Тогтвортой хөгжлийн зорилго (2015-2030)			

НҮБ-ын Жендэрийн эрх тэгш байдлыг, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлэх байгууллага буюу Эмэгтэйчүүдийн байгууллагын бүрдүүлсэн мэдээллийн санг шүүхэд 2014 оны байдлаар 195 улсаас 143 нь үндсэн хуульдаа жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулсан

⁹ Хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, охидын эрх, хэлний эсвэл бэлгийн цөөнхийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, дүрвэгсэдийн эрх, уугуул хүмүүсийн эрх хэмээн нэрлэж байгаа нь төрийн зүгээс баталгаатай эрхийг нь эдлүүлж чадахгүй байгаа, тухайн нийгэмдээ олон жилийн турши тогтолцооны шинэжтэй ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөж, хавчигдсан, адлагдсан бүлгийн эрхийг эн тэргүүнд баталгаажуулах, даруй анхаарч ажиллахтай холбоотой.

¹⁰ Хууль зүйн үндэсний хүүрээлэн, Эрдэс баялгийн эрх зүйн тойм, УБ, 2012 он. 195-196 дахь тал.

¹¹ Женевийн Тунхаглал буюу Хүүхдийн эрхийн тунхаглал. Дэлгэрэнгүйг: <http://www.un-documents.net/gdrc1924.htm>

ч хууль тогтоомж, бодлого, жендэрийн хэвшмэл үзэл (стереотип), нийгмийн хэм хэмжээ, туршлагаас үүдэлтэйгээр ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртсөөр байгааг онцолжээ.¹²

2. Монгол Улсын дотоодын эрх зүйн баримт бичиг

Манай улсын эрх зүйн хэм хэмжээг ангилах тогтсон эсвэл нэгдсэн ай сав (категори) боловсруулаагүй ч Хууль зүйн үндэсний хүрээлэн хронологийн буюу он дараалсан Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийг 16 ботиор 2010 онд хэвлэсэн байна. Гэсэн хэдий ч Монголын төрөөс тогтоосон аливаа хэм хэмжээг ХХ зууны 20-оод он хүртэл нэг мөр хэвшүүлэн мөрдөж байсан эсэхийг судалсан, ялангуяа өнөөдөр бидэнд мэдэгдээд байгаа эх сурвалжуудыг нарийвчлан судлаагүй болно. Үүнтэй уялдан эмэгтэйчүүдийн талаарх нарийвчилсан зохицуулалт бүхий дотоодын эрх зүйн хэм хэмжээг ерөнхийлөн дараах он тооллоор бүлэглэв:

- Их, бага хаадын үе (1206-1636)
- Манжийн эрхшээлд байсан үе (1636-1910)
- Богд хаант засгийн үе (1911-1919)
- Ардын засгийн үе (1921-1940)
- Социалист маягийн БНМАУ-ын үе (1940-1991)
- Орчин үе (1992-2021)

2.1. Их, бага хаадын үе (1206-1636)

ИХ ЗАСАГ ХУУЛЬ (1206)

“Их засаг” хуулийн уг эх сурвалж нь өнөө хүртэл олдоогүй ч олон зуун жилийн турш дэлхийн монгол судлаачдын анхаарлыг татсаар ирсэн. “Их засаг” хуулийн тухай дийлэнх мэдээлэл нь перс, араб хэлээр бичсэн хэдий ч тэд бүтээлдээ монгол сурвалжуудыг ашигласнаа дурдсан нь буй.¹³

Монголын нууц товчооноо давхар эшэлсэн, хаан ширээнд хэнийг залах тухай заалтад “Миний хаан ширээг **үр хүүхдийн** минь нэг нь залгамжилж, миний зарлигийг өөрчлөхгүй, задлахгүй, осолдож алдахгүй баримталж явсугай”¹⁴ гэж хүйс илэрхийлээгүй нэр томъёо байгаа ч хаан ширээг хөвгүүдэд шилжүүлж байсан туршлагатай байна.

Мөн “Монголын нууц товчоо” дахь “Тэмүжиний уг гарал” бүлгийн ургийн бичгээс гэргийг нэрлэсэн туршлагад хөвгүүдийн түлхүү онцолж байна. Жишээлбэл, хоёр гаруй үеийг тоочихдоо “Бөртэ-Чино, гэргий Гуа-Марал”, “Боржигидай мэргэний гэргий нь Монголжингуа”, “Торголжин баян, Борогчин гуа гэргийтэй”, “Алун-гуаг гуйж, Добу мэргэний гэргий болгосон”, “Тэр жирэмсэн эм Бодончарт ирж”, “Бодончарын авааль эмээс төрсөн”, “Хачи хүлүгийн хөвүүн Хайду, Намулун эхээс төрсөн”, “Есүхэй баатрын Өэлүн үжинээс Тэмүжин, Хасар, Хачиун, Тэмүгэ дөрвөн хөвүүн төрөв” гэж 6 эмэгтэйг нэрээр, 2 эмэгтэйг нэрлэхгүй тэмдэглэжээ. Тэмүжин хүртэлх гэргийн угсааг дурдсан нь Алун-гуа,

¹² НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, “Эмэгтэйчүүдийн хүний эрх”, мэдээллийн хуудас, 2015 он. Дэлгэрэнгүйг: <https://www.unwomen.org/en/digital-library/multimedia/2015/12/infographic-human-rights-women>

¹³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, 1 боть, УБ, 2010 он. 29 дэх тал.

¹⁴ “Монголын нууц товчоо”, шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш. Чоймаа, УБ,

Бөртэ гэсэн 2 тохиолдол байна. Тууль хайлах ёсны туршлагад гол дүрийн баатрыг хэний хүүхэд, хэнтэй нийлсэн, хэнийг төрүүлсэн хэмээн өгүүлэхдээ заавал эхийн талыг хамтатган бичдэг байсан хэлбэр нь XIII зуунд нэгэнт эрэгтэй талыг л анхаарч, илүү ач холбогдол өгч бичдэг болжээ хэмээн дүгнэж болох юм.

Хүснэгт №2. Тууль дахь ургийн бичгийн хэлбэр¹⁵

	Хан Харангуй	Гэсэр	Жангар
Эцэг эх	Хаан сайхан аав Хатан тунгал ээж	Сэнлон ноён Го баяны охин Амаржил	Тансаг Бумба хааны ач Үйзэн алдар хааны хүү
Хань ижил	Хан харангуй Толь гуа дагина (Агь буурал хааны)	Гэсэр (Нусан Жур) Рогма хатан	Жангар Агай Шавдал (Ном Төгс хааны)
Үр хойч	Хар Соно	Ажу мэргэн хатнаас хүү төрсөн ч үхсэн	Хар Жилган

“Их засаг” хуульд гүнж, үжин, хатан гэсэн эм хүйс илтгэх нэр томъёог дурдаагүй ба “хан эзэн”, “түмэдийн мянгатын, зуутын ноёдын хөвгүүд”, “чөлөөт хүмүүний хөвүүд”, “эрхт хэшигтэн”, “хорчин”, “буурчин”, “хэвтүүл”, “нуган хөвүүн”, “цэргийн дарга ноёд”, “анчин хүн” гэсэн гол төлөв эр хүйс илэрхийлсэн нэр томъёо зонхилж байна. Онцгой тохиолдолд “Нуган хөвүүн төрвөөс Хуйлдарын урагийн ураг хүртэл дагаж хүчээ өгтүгэй. Охин хөвүүн төрвөөс эцэг эх ану өөрийн дураар бүү худалдтугай. Хуйлдарын эм хөвүүний өмнө хойно зартугай” гэж эмэгтэй хүнийг худалдах, зарцлах талаар заажээ.

Татвар эмээс төрсөн хүүг бутач гэж тооцохгүй ч өв залгамжлахдаа эхнэр, татвар эмийн эрэмбэ, гэрлэсэн огноог нягтлахаар нарийвчлан заасан бөгөөд эцэг нас барсан тохиолдолд эхээс бусад эхнэрийг нь төрхөмд буцаах боломжтой байсан. Бэлэвсэн эхнэрийг талийгаач нөхрийн дүү, ах авч суух, үгүй бол дахин нөхөрт гарахад их хэцүү, гоонь үлдэх эрсдэлтэй байсан нь ургийн холбоог таслахгүй гэх уламжлалын нөлөө байжээ. Энэ үед олон эхнэртэй байх, эцгийн орыг бага хүү залгамжлах ёс хэдийнэ тогтсон байлаа. Сүй тавих, инж өгөх, эхнэр худалдан авах нь хуулиар зөвшөөрсөн ба эмэгтэй хүнийг хулгайлах, хүчирхийлэх, бурангуй харилцах, хоргойдох, нэг бол садарлах тохиолдолд алахаар заажээ.

Аливаа шашинд хүндэтгэлтэй хандаж, шашин бүрийн номтой санваартнуудыг татвар, алба гувчуурын дарамтаас чөлөөлж, дэмждэг байсан бол ноён тариачин байхаас үл хамааран талийгаачийн хөрөнгийг үр хүүхдэд, залгамжлах үр хүүхэдгүй бол шавь, боолд нь дамжуулдаг байв.

Цэвэр тунгалаг гоочууд буюу үзэсгэлэнтэй сайхан эмэгтэйг дээд шатны удирдах албан тушаалтанд шилэн хүргэж, хаан, ван таалвал хатанд шадарлуулахаар тусгайлан заажээ. Цэрэг захирагч, цэргүүд нь шинээр дагасан аливаа хот, гацааны эмс, охидыг хүчирхийлэх, мөн сайн дураар гэрлэх, гэр бүлийнхэнтэй нь зөвшилцөн зөвшөөрч суух, зарцыг худалдан авахыг хоригложээ.

Дайн тулаанд үрэгдсэн талийгаачийн шарилыг авчирсан хүнд үхэгсдийн эхнэр, боол, малыг хүртэл бүрнээр нь олгодог байсан нь бусдын хөрөнгийг хааны санд төвлөрүүлэхгүй, эзэнтэй байх зорилготой уялдаж байна.

15 Б.Болорсайхан, “Ялгаварлан гадуурхахгүй байх хүний эрхийн зарчим ба соёлын нөлөө”, “Хүний эрх” сэтгүүл, УБ, 2016/02. 38 дахь тал.

Эхнэр хүн нөхрийн эзгүйд гэр ахуйгаа авч явах, цэвэр цэмцгэр цэгцтэй байхыг шаардаж, муу зантай, ухаалаг бус, завхай, салан задгай бол нөхрийн нэрэнд муу гэж зохицуулсан нь ажил үүргийн хуваарийг шууд үүрэгжүүлэн заасан зохицуулалт байна. Мөн эмэгтэй хүн эд хөрөнгийнхөө талаар санаа тавьж, юм худалдан авч, хүссэн зүйлээрээ наймаа хийх боломжийг олгожээ.¹⁶

Боловсролын талаар огт дурдаагүй, төрийн үйл хэрэгт оролцох талаар зохицуулалт байхгүй нь хөвгүүдийг онцлон ан ав, цэргийн хэрэгт татан оролцуулдаг байсантай холбоотой. Ийнхүү нийгмийн харилцаанд татаж оруулах туршлагаа хожим Юань Улсын үед 1271 онд Хубилай хаан Монголын хөвгүүдийн сургууль, 1277 онд Монгол хөвгүүдийн сургуулийн хэрэг эрхлэх алба байгуулж, монгол ба хятад түшмэл, хишигтний хөвгүүд дүү нараас авьяас билэгтэйг сорчлон сургах үйл явцаар бэхжүүлсэн юм (Ж.Ганболд, Монголын Юань Улс, УБ, 2006). Тус сургууль нь монгол хэлээр сургадаг, элитист буюу дээдэс язгууртны хүүхэд л сургах тусгай сургууль ч нийгмийн байдал, угсаа, хүйсээр ялгаварлан гадуурхсан төрийн институц байсныг харуулж байна.

ӨГӨДЭЙ ХААНЫ ЦААЗ (1230, 1234)

Захирагч түшмэл, харьяат цэргүүд, хот хөдөөгийн түшмэд, ван сайдууд хамаарах захиргаа, цэргийн явдлыг нарийвчлан зохицуулсан ба хааны ордонд орж гарахад эр, эм ганцаар явах, самууран явахыг хориглосон байна.

МАНДУХАЙН ЦААЗ буюу таван дүрэм нь ахуйн зан үйлтэй холбоотой хориглох заалтуудаас бүрдсэн хэм хэмжээ бөгөөд эмэгтэй хүнд хамаарах заалт байхгүй болно.¹⁷

Юань Улсын үед МОНГОЛ УЛСЫН АРВАН БУЯНТ НОМЫН ЦАГААН ТҮҮХ хэмээх баримт бичгээр хоёр төр (хоёр ёсон) буюу төр болон шашин хэрхэн зэрэгцэн улс орныг залах, ард түмэнтэй яаж харилцах, удирдах, шажин төрийг ёсчлон дагах талаар заасан ажээ. Тусгайлсан эмэгтэй хүнд хамаарах заалт байхгүй болно.

Сүм хийдэд элчин буух, улаа шүүс барих, эд хөрөнгө, газар, тариалан, мал татах, ашиглах, сан тамга өгөхийг хориглож, өртөөнд хүчээр дайчлахыг хориглосон, шашны байгууллагыг алба гувчуураас чөлөөлсөн тухай зарлиг 1276-1368 онд буулгаж байжээ. Тусгайлсан эмэгтэй хүнд хамаарах заалт байхгүй болно.

АЛТАН ХААНЫ ЦААЗ (1507-1582) дахь:

- Эхнэрийн хүүхдийг устгаваас сарын тоогоор есөөр торгох;
- Эр нь эмэгтэйн үсийг тасалваас есөөр торгох;
- Эр эм садарлаваас долоон есөөр торгох;
- Сэтгэл бээр авбаас/оргуулбаас есөн есөөр торгож, нэг удаа занчих;
- Хүүхэн хүнийг оргуулбаас буруутай этгээдийг есөн есөөр торгож, тогтоосон тоогоор занчих;
- Ор дэвсгэрээс татваас гурван есөөр торгох;
- Эцэг эх охиноо элдэв аргаар эрд өгвөөс есөн есөөр торгох, ахин буцаж ирвэл цаазгүй;

¹⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, I боть, УБ, 2010 он. 29-43 дахь тал.

¹⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, I боть, УБ, 2010 он. 43-44 дэх тал.

- Санаа муу хүнтэй зөвшилцөн үйлдвээс долоон есөөр торгох;
- Цэвэр охины толгойг муу нөхөртэй нийлүүлсэн эцэг эх байвал цэргийн доод цаазаар эцэг эхийг шийтгэх;
- Бүсгүйг татаж дээрэлхвээс цаазгүй;
- Салсан үзэсгэлэнт эхнэрт хоёр морь өгөх;
- Эхнэрээ нөхөр бээр хурц үзүүртэй мод, чулуугаар цохивоос гурван есөөр торгох;
- Эхнэр бээр нөхрийгөө амаараа доромжилвоос нэг эдээр торгох;
- Цэргийн эхнэр нөхрийн эзгүйд төрвөл эцэг эх нь асарч нөхөрт хүүхдийг өгвөл цаазгүй. Цэрэг цааз шаардвал шийтгэх, эдээр торгох;
- Эд нуух, нуусан эмтэй нөхөрлөвөөс нэг мориор торгох зохицуулалт нь гэр бүл, иргэний харилцааг улам нарийвчлан зааж, малын тоо зааж, эдийн шийтгэл ногдуулах буюу торгох нь эдийн засаг, амьжиргаатай уялдсан хэм хэмжээний шинэ туршлага болсон байна.
- Эцэг эхийн хяналт өндөр байх, гэр бүлээс гадуурх харилцааг үл зөвшөөрөх, хүчирхийллийг таслан зогсоох, тэр дундаа нийтлэгээр эмэгтэй хүнийг хүчирхийлж байгааг шууд таслан зогсоох зорилготой заалт ихэд нэмжээ.¹⁸

2.2. Манжийн эрхшээлд байсан үе (1636-1910)

ХАЛХЫН ҮЙСЭН ДЭЭР БИЧСЭН ЦААЗУУД (1603-1667) дотор эмэгтэй хүнийг оргуулан ханилсан бол шийтгэхгүй байх, угсаа гарвал сайтай хүн, эхнэр, авхайг хараах, занчих тохиолдолд алах, эсвэл их хэмжээгээр торгох шийтгэлтэй болжээ. Гэрчтэй хуримыг хууль ёсны гэж үзэх, эм хүн эр хүний өвөрт орвол гурван есөөр торгох, харц хүний эмтэй унтвал хагасын хагас анзаар торгох, ноёд хүний сүйт бүсгүйг бусдад өгвөл гурван зуун анзаар торгуулах, эмийг нь хариулваас торгуулахгүй байх, ноён хүний сүйт бүсгүйтэй явалдвал арван гэр хүн, мянган анзаар торгох, ноёд, тавнан залуу эхнэртэй болвол өмнөх эхнэрийг эцэг нь инжгүй авах, нөхөр нь хулгай хийвэл эхнэр торгууль төлөлцөх, эм хүнийг занчиж хээл унагаваас хэдэн сартай бөгөөс тэдэн ес авах, гэргий авсан сахилтан руу дайрвал морь авах, энэ үйлдлээ давтвал хоёр нугалах, эд инжээ гэрлэгч хоёр тал тохирох, хорь хүрсэн эмэгтэйг даруй гэрлүүлэх арга хэмжээ авах, эмэгтэйг хүчиндсэн бол ес авахаар зохицуулжээ.

Түүнчлэн хүргэн үхвэл өгсөн малаа хариулж авах, охин үхвэл хагасыг авах, хорин насанд хүрсэн ч сүйт охин гэрлэхгүй бол эцэг эх нь өөрийн дураар өгөх, харц хүний эмийг татсан ван 9 ес, засгийн ноёд, хошууны тайж, гүн 7 ес, тайж нар бол 5 есөн бод авах, эм хүн ураг унагаваас 1 ес авах, эр нь эмээ зүхэн санаагаар албаас хариу хөвчдөж алах, харц хүн хатад лугаа нэгдвээс явалдсан эрийг огтчиж, хатныг чавчиж алах, нөхөр эхнэрээс салвал инж, хөрөнгийг эхнэрт өгөх зэргээр ихэс дээдэс, харцын хоорондын, гэр бүлээс гадуурх харилцаа, мөн эмэгтэй хүнтэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

ХАЛХ ЖУРАМ (1709) -аар ноёд, тавнан дахин эхнэр авбал үлэмж хэмжээгээр торгох, шинэ эхнэрийг инжийн хамт буцаах, харин тавнан эхнэрээс салах тохиолдолд ташуураас өөр өмчгүй салах (тавнан авайг гэвээс ташуураа барьж гарах), ноёд бусдын эхнэр, охинтой явалдвал үлэмж хэмжээгээр торгох, алах, хүний эм ба охиныг босгуулсан бол явалдсантай адил шийтгэх, хөнжлийн захаас татвал 3 есөөр торгох, ихэс дээдсийн охинтой харц хүн

¹⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, 1 боть, УБ, 2010 он. 82-86 дахь тал.

гэрлэх бол заасан инж өгч гэрлэх, түүнчлэн 1764-1794 онд холбогдох Монгол цаазын бичигт харц хүн харц хүний эмд орвоос гучин бэрх, гурван зуун анзаар яллах, явалдсан эмийг эрд нь тушааж алуулах, эс албал ялын малыг ноёд өгөх гэсэн тусгай зохицуулалттай ажээ. Үүгээр харц, ихэс дээдсийн харилцааг чанд зааглах, эрх мэдлээрээ далайлган бусдын сүйт бүсгүй, охин, эхнэртэй явалдах, гэр бүлээс гадуур харилцааг хориглосон нь тухайн нийгмийн нийтлэг бурангуй үзэгдэл тул уламжлал, зан заншлаар зогсоож чадахгүй ийнхүү хуульчилсан байх магадлалтай.¹⁹

Үүний зэрэгцээ 1777 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Худалдааны иргэд монгол эмэгтэйг гэргий болгон авахыг хориглон зарласан бичигт "...монгол эм авч суусан хятад буй аваас даруй монгол эмийг хойш буцааж төрхөмд өгөөд, хятадыг уг газарт хөөж илгээгтүн", "аливаа худалдааны иргэдэд монгол эм өгөхийг цаазалсан хуулийг чандлан цаазлаад үүрд дагаж явуулгтун" гэж тусгайлсан шийдвэр гаргаж байжээ.²⁰

Монгол цаазын бичгийн 1795 оны Нөгөө дэвтрийн товчид зоригоор чавганц болохыг цаазлах, салж жил удсан төрлийн ардыг үл нийлүүлэх, үргүй хүн бусад хүний хөвгүүнийг авч тэжээх, үр тасарсан хүний гэр, бараа, мал, өвийг өвлүүлэх, Монголчууд худ боллоцход богтлох, мал өгөх, эм гээх, вангуудын сүйг бус вангууд авах, бус хүний сүйг авах, вангуудын хүүхдэд инж дагуулах, тэнгийн хүний эм лүгээ явалдах, вангууд харц хүний эм лүгээ явалдах, харц хүн хатад лугаа явалдах, муу самуугаар явсан ардыг Хунан, Шандунд цөлүүлэх, хор хийж ураг унагах талаар зохицуулж, эмэгтэй хүний шашин шүтэх, нөхрөөс салах, хүүхэд үрчлэх, өмчтэй болох, өв залгамжлах, гэр бүлээс гадуурх харилцах эсвэл сүйт бүсгүйг хүчээр авсан тохиолдолд хатуу шийтгэх, гэрлэх, инж өгөх боломжийг нарийвчлан зохицуулж, хуульд заагаагүй үйлдэлд торгох, салгах, цөлөх, алах шийтгэл заажээ. Нийгмийн харилцааг нарийвчлан зохицуулсан шинэ жишиг нэвтрүүлсэн эрх зүйн хэм хэмжээтэй болж байгаа нь суурин амьдралын хэв маяг, Манжийн захиргааны нөлөөг харуулна. Бүгдийн дээд хууль, Бүгдийн доод хууль дахь 1811 оноос хойших зүйл заалтад тусгайлан заасан Улсын хөвгүүдийг хүмүүжүүлэх яам, Найман хошууны Оросын бичиг үсгийг сурах сургуулийн хөвгүүд, Төвдөд илгээж чадал сурах Тангад сургуулийн хөвгүүдтэй холбоотой асуудлыг нарийвчилсан, хэргэм зэрэг хөвгүүдэд өв залгамжлуулах, бэлэвсэн эм өнчин хөвгүүнийг үр болгож тэжээлгэх, газар тариалан эрхлэх, тариа арилжих квот тогтоосон нь эмэгтэй хүний сурч боловсрох, өв залгамжлах, аж ахуй эрхлэх эрхийг баталгаатай эдлүүлээгүй, хүйсээр ялгаварласан туршлагатай байсныг илтгэнэ. Гагцхүү гүнж, гэг нарт тусгай хангамж, тэтгэмж үзүүлдэг байсан нь Манжийн хавчсан, гадуурхсан бодлогын тод жишээ юм.

2.3. Богд хаант засгийн үе (1911-1919)

Мандухай сэцэн хатан зэрэг төрийн өндөр дээд албан тушаалд монгол эмэгтэй хүнийг тохоон томилсон, эрх мэдэл олгосон түүхэн баримт XV зууны сүүл – XX зууны эхэн үеийн эрх зүйн эх сурвалжаас тэр бүр олдохгүй байна. Манжийн эсрэг 1911 оны 3 дугаар сарын 5-ны өдрөөс 1919 оны 11 дүгээр сарын цэрэг дайны үйл ажиллагаа, тусгаар тогтнолын төлөөх зэвсэгт тэмцэл, эдийн засаг сэргээх, гадаад улстай харилцах талаарх олон шийдвэр, хууль гарсан бөгөөд Богд хаанаас Улсын дээд, доод хурлын газрыг нээх зарлиг гуйсан бичиг, Улсын дээд доод хурлын газрын найман зүйлийн дүрэмд (1914.03.23) гагцхүү сайд ноёд түшмэл төлөөлж, төрийн алба хаших, үйл хэрэгт оролцохоор заажээ. Үүгээр эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг баталгаажуулах санаачилга байхгүй байсныг харуулна.

19 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, I боть, УБ, 2010 он. 86-201 дэх тал.

20 Ар монгол дахь хятадын худалдаа-мөнгө хүүлэл (1751-1911). Баримт бичгүүд. УБ., 1988. 187-188 дахь тал.

Автономит засгийг устгахыг гуйж Да жунтанд өргөсөн бичгийг (1919.11.17) гардуулахаас өмнө 1918 онд 65 дэвтэр бүхий Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг баталж мөрдсөн юм. Үүнд төрийн алба хаших этгээд нь тайж угсаа гарвал бүхий ихэс дээдэс байхаар зааж, бичээч эрчүүдийг сонгон шалгаруулахаар зохицуулсан ба Нийслэл хүрээний баг, дунд зэргийн сургуулийн хөвгүүдээс сонгон шалгаж, хүний нөөцөө бүрдүүлэхээр шийдсэн үйл явдлаар Монголын Юань Улсын төрт ёсны туршлага үргэлжилсээр буюу эмэгтэй хүнд иргэний болон улс төрийн эрхийг баталгаажуулаагүй байсныг илтгэнэ. Мөн хөвүүн төрсөн эмийг худалдаж үл болох, бусад хүний хөвгүүнийг үр болгож тэжээх, үр болсон хөвгүүн болгосон эцэг эхэд нийлэхгүй болох, үр тасарсан хүний эд өрхийг эзэрхэх, өнчин хөгшнийг хурааж тэжээх, ураг барих ёслолын хууль, гурван ихэр хөвүүн төрсөнд амуу бөс шагнах, эм охин зоригоор чавганц болох, ламын сүмд эмс халгаж агуулах, эр нь эмийг зоримоогоор алах, хор хийхийн учир харвисийг (үр) унагах, эм охин цөлөх ял халдах, явалдах, хүн худалдах, ёс алдах буюу ахас ихсийг ёсолж хүндэтгэхгүй байх зэрэг харилцааг сайтар заажээ.

Эмэгтэйчүүдийн гэмт хэргийг анх удаа бүлэглэж, жирэмсэн хүнийг төрсний дараа шийтгэх, ял эдлүүлсний дараа хүүхэд тахир дутуу төрвөл эсвэл үхсэн бол түшмэлийг шийтгэхээр тусгажээ. Хүчин, хүн амины хэрэг үйлдсэн бол шоронд хорьж, хөнгөн гэмт хэрэгт ташуурдах, торгохоор найруулсан байна.²¹

2.4. Ардын засгийн үе (1921-1940)

Монголын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам (1920.12.20) нь хаант ёсыг халсан ардын, бүгд найрамдах, ардчилсан, эрх чөлөөт, шинэ мандах өөртөө эзэрхэн Монгол Улс байхаар боловсруулан, олон нийтэд сэтгүүлээр түгээж байжээ. Засгийн хэргийг бүгд түр захиран шийтгэх газраас монгол газраа суулгах төлөөний түшмэдийн дагаж явах дүрэм хэмжээний 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Нутаг орны хөвгүүд **охид** ба хөгшид залуус, лам хар эр **эм** бүгдээрийг өөрийн үндэс хэлний бичгийг үзэж танхимын замд алин болох түргэн цагт жолоодон оруулна. Иймийн тул сонгон багшлуулах эрх буй”, мөн 5 дугаар зүйлд “Аль ч хүн нар нэгэн адил эрхтэй бөгөөд хошуу шавь ба монгол, төвд, хятад, орос ноёд, ард хэмээн ялгаварлан үзэхийг нийтээр зогсоовоос зохихын тул хэтэрхий хүнд ёслон хэрэглэж үл болно” хэмээн ялгаварлан гадуурхахаас ангид байх, сурч боловсрох эмэгтэйчүүдийн эрхийн хууль зүйн баталгааны үндсийг бүрдүүлсэн байна. Ажлын цагийн ба он тооллын тухай (1921.05.20) шийдвэртээ ням гарагт амрах, ажлын өдөр 09:00-16:00 цагт хүртэл ажиллах, Монгол Улсын олноо өргөгдсөнийг ба Европын он хоёрыг хавсран бичихээр тогтжээ.²² Газрыг хувийн өмч болгохыг устгасан тухай (1921.05.21) шийдвэртээ Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгахаар заав.²³ Олон хөвгүүд, охидын сургуулийн танхим нээж, насан багад элдэв зүйлийн бичиг заан сургаж, оюуны судлуулан олон түмний хэрэгт туслалцуулахыг хичээж, бага сургууль байгуулахаар шийдсэн (1921.08.14) нь сурч боловсрох эрхээ бүх нийтээр үнэ төлбөргүй чанартай эдлэх эхний суурь үндэс болсон юм. Улсын түр цагийн хурлыг байгуулах тухай бичиг ба дүрэмд (1921.09.20) ноёд түшмэд бичээчин төдийгүй эрдэм бодлого бүхий ард хүнийг сонгохоор зааж, эмэгтэйчүүд ч төлөөлөх боломж анхлан олгосон байна. Испани, Британийн Магна Картатай дүйх Тангаргийн гэрээг (1921.11.01) Богд хаантай ардын засгийн газар байгуулж, хэмжээт эрхт хаант ёсыг бататгасан түүхтэй.

21 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, II боть, УБ, 2010 он. 19-354 дэх тал.

22 Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл, УБ., 1972. 17-18 дахь тал.

23 Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл, УБ., 1972. 18 дахь тал.

Хожим Богд хаан таалал төгсөхөд (1924.04.17) Бүгд найрамдах засгийг байгуулахаар зориг шулуудан шийдвэрлэсэн (1924.06.13) ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын (БНМАУ) Үндсэн хуулиа (1924.11.26) боловсруулан баталсан. Үүнд эрэгтэй эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрх эдлэх, Улсын Их, Бага хурал ба нутгийн хурлуудад төлөөлөх, сонгох, сонгогдох, хөдөлмөрлөх эрхийг²⁴ анх удаа баталгаажуулсан билээ. БНМАУ-ын Бага сургуулийн танхимын дүрэм, хэмжээ (1926.03.19) дотор охид, хөвгүүд тусдаа байрлах, сургуулийн бүсгүй хүүхдийн энгийн суух, амрах, унтах орон гэрийг тусгайлан бэлтгэх, сургуулийн хөлс, сүйтгэл хураахгүйгээр бага сургуульд 8-13 насны хөвгүүд, охидыг хуралдуулан, жил бүр анги дэвшүүлж, сургаж боловсруулах, сурагч хүүхдийн бие махбодыг хортойгоор жанчин залхааж сургах хуучин бүдүүлэг суртлыг бүрмөсөн устгахаар зорьжээ. БНМАУ-ын Ардын эрүүлийг хамгаалах газрын ерөнхий хэрэг явуулах дүрэмд (1926.05.21) бие жирэмсэн эмэгтэйчүүд, нялх хүүхдийг хамгаалан татан тэнхрүүлэх, жирэмсэн эмэгтэйчүүдийн нярайлах үр хийгээд дутуу хүнд аргуудыг анагаах эм заслын явдлыг эрхлэх гүйцэтгэснээр эмэгтэйчүүдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх хэрэгжих боломж бүрдсэн ажээ. БНМАУ-ын Иргэний хуулийн I бүлгээр (1926.12.10) асрамж халамжийн, II бүлгээр (1926.12.24) эд хөрөнгийн, III бүлгээр (1927.05.06) гэр бүлийн эрх үүргийн, IV бүлгээр (1927.12.09) эвлэл, хоршооллын, VIII-X бүлгээр (1929.08.17) аливаа иргэний хэргийн учир, харилцан эдлэх ба хүлээх үүргийн харилцааг зохицуулжээ. Сонгох, сонгогдох эрхийн тухай заавар (1929 оны 3 дугаар сар) нь 1924 оны Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох эрхгүй хүмүүсийн буюу бусдыг зарж мөлжин амьдрагсад, худалдааны ба мөнгө хүүлэгчид, урьдын ван гүн хутагт хувилгаад нарт эрх эдлүүлэхгүй, тэдний хүүхэд, бутач хүүхдэд ямар байдлаар тус эрхийг эдлүүлэхийг нарийвчлан заасан. Цаашилбал БНМАУ-ын Хүчнээ үнэлэгчдийн хууль (1930.05.09) хот, хөдөөний захиргаа, үйлдвэр, хоршоо, айл өрх, тариалан зэрэгт ажиллаж байгаа хүний хөдөлмөрийн харилцааг тодотгосон бол Хүчин үнэлэхүйн тухай хуулиар (1933.02.01) хөдөлмөрийн гэрээ, ажлын цаг, амралт, цалин хөлс, шагнал, чадвар алдалт²⁵, үйлдвэрчний эвлэлийн талаар сайтар тусгасан байна. Төр шашныг тусгаарлан явуулах тухай хуулийн (1934.12.27) дагуу шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн ч харын ёст буюу секуляр улс болохоо дахин тунхагласан. Үүгээр шашин шүтэх, сүсэглэх боломжийг хумьсан алхмыг эхэлсэнд тооцно.

2.5. Социалист маягийн БНМАУ-ын үе (1940-1991)

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “БНМАУ болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орон юугаа хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, сэхээтэн) ардын тусгаар тогтносон улс мөн болно”, 1960 оны Үндсэн хуулийн (1960.07.06) 1 дүгээр зүйлд “БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд, (малчид, тариачид) хөдөлмөрч сэхээтний улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн” гэж тодорхойлсон байдаг бөгөөд МАХН улс, төр, нийгмийн бүх байгууллагуудыг удирдан чиглүүлэгч үүрэгтэй гэж намын удирдах чиглүүлэх үүргийг хуульчлан тогтоожээ.

Ард иргэдийн үндсэн эрх ба үүргүүд хэмээх бүлгийг тусгайлан гаргасан, Ажлын сахилга батыг сахих, аж ахуй, соёлыг бүхий л талаар хөгжүүлэхэд авьяас хүчээ дайчлан алба хаах, эх орноо хамгаалах үүргийг хуульчлав. БНМАУ-ын эдийн засгийн үндэс үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээрээ өмчлөх социалист өмч гэдгийг зөвшөөрч, Бүх хүчин чадал, эрдэм

²⁴ Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм (1925.02.14) нь одоогийн Хөдөлмөрийн хуультай нэгэн адил хэм хэмжээ юм. Үүгээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний эвлэлтэй байх, нэгдэх, өвдсөн, жирэмсэн, төрсөн үед чөлөө авах, эмнэлгийн зарлагыг даалгуулахаар заажээ.

²⁵ Тахир дутуу бологсдыг тэтгэх хөрөнгийн тухай дүрмийг (1933.03.17) баталсан.

мэдлэгээ социализм байгуулах үйлсэд бүрнээ зориулах, Үндсэн хуулийг ёсчлон сахихаар хуульчилсан юм.²⁶ Энэ нь өмнөх 1940 оны Үндсэн хуулийн “Бүх газар, түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик завод, төмөрлөг алт боловсруулах явдал, төмөр зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйтнууд улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн” гэсэн агуулгаас үүдэлтэй. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, ажил мэргэжил сонгох, эзэмших, хөдөлмөрлөх, зохистой орон байртай байх, ус ариун цэврийн байгууламжаар хангагдах, аж ахуй эрхлэх зэрэг эрхийг ахиц дэвшилттэйгээр манай улс эдлүүлж, биелүүлж байсан туршлагыг харж болно. Хүн амаа өсгөх бодлогын үүднээс жирэмслэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдээ төлөвлөх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн талаарх зохицуулалтгүй, эхийг удаа дараа төрүүлэх бодлогыг удирдлага болгосон түүхтэй.

Хүснэгт №3. Эрүүгийн хуулиар ажлын байрны бэлгийн дарамтыг хориглосон туршлага²⁷

1926 он XXI бүлэг. Аливаа албаны хүмүүс гэмт явдлаар явах нь	147-р зүйл: Аливаа албаны хүн эрх тушаалдаа эрдэж албан яамны зэрэг газрын хэрэг явдал дор саатал, боогдол болгох ба ард олны амгалан тайван байдлыг сахих хууль дүрмийг зөрчих ба бусдын эрх чөлөө ба эд хөрөнгөн дор халдах, ашгийг хичээж цааз хуулийг зөрчих, аливаа хүнийг айлган сүрдүүлж дарлах аваас 1 сараас 2 жил хүртэл гяндан хорих буюу 50-1200 төгрөг хүртэл торговол зохино.
1929 он XX БҮЛЭГ. Аливаа албаны хүн гэмт явдлаар явах нь	149-р зүйл: Аливаа албаны хүмүүн эрх тушаалдаа эрдэж албан яамны зэрэг газрын хэрэг явдал дор саатал боогдол болгох ба ард олны амгалан байдлыг сахих хууль дүрмийг зөрчих ба бусдын эрх чөлөө ба эд хөрөнгөн дор халдах, ашгийг хичээж цааз хуулийг зөрчих, аливаа хүмүүнийг айлган сүрдүүлж дарлах аваас 1 сараас 2 жил хүртэл хорих буюу 50-1200 төгрөг хүртэл торговол зохино.
1934 он	133 дугаар зүйл. Бие махбодийг хүчирхэн барьж явалдах хийгээд биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан явалдах буюу түүнчлэн эд амьдрал, албаны хувиар эрхэнд буй ашиглан албадах зарчмаар хүчирхэж явалдсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорьж ял шийтгэвэл зохино. Хэрэв хүчирхэн явалдах явдлыг хэд хэдэн хүн хамтран үйлдсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.
1942 он	165 дугаар зүйл. Эмэгтэйчүүдийг хурьцлын холбоонд албадан хавчиж оруулах буюу эсвэл эд амьдарлага ба албан тушаалын талаар эрхэндээ байсан эмэгтэйчүүдтэй зүй бус арга маягаар явалдах болбол 5 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино.
1961 он	89 дүгээр зүйл. Эрхшээлдээ байгаа хүнтэй тулган хавчиж хурьцал үйлдэх. Албан тушаал, эд материал буюу бусад байдлаар өөрийн эрхшээлд байгаа хүмүүсийг тулган шахаж хурьцал үйлдвэл 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.
1986 он	114 дүгээр зүйл. Эмэгтэй хүнийг тулган хавчиж хурьцал үйлдэх Албан тушаал, эд материалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа эмэгтэй хүнийг тулган хавчиж хурьцал үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
2002 он	Зохицуулаагүй
2015 он	12.4 дүгээр зүйл. Бэлгийн дарамт учруулах ²⁸ 1. Хохирогчид ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны, бусад байдлаар хохирол учруулах үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэж бэлгийн харьцаанд орох сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл бэлгийн харьцаанд орохыг шаардсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохирогчид дарамт учруулж бэлгийн харьцаанд орсон бол нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

²⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, V боть, УБ, 2010 он. 159-166 дахь тал.

²⁷ Б.Болорсайхан, Хөдөлмөрлөх эрхийн нэгэн асуудал – АББД, “Жаргал де факто” сонин. Дэлгэрэнгүй: <https://www.jargaldefacto.com/article/khudulmur-lukh-erkhiin-negen-asuudal-abbd>

²⁸ (Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон)

2.6. Орчин үе (1992-2021)

Иргэний болон улс төрийн эрхийг бүрэн дүүрэн эдлүүлж чадаагүй, ангич, социалист шинжтэй үеийн зохицуулалтаа илүү боловсронгуй, хүнд ээлтэй, хүн рүү чиглэсэн хөгжлийн загвараар нягтлан ажилласан бөгөөд хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аливаа хүйсийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилготой, нийгмийн бүлэгт анхаарсан эрх зүйн хэм хэмжээгээр эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулах болжээ. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 1998 онд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр²⁹ боловсруулан хэрэгжүүлсэн төдийгүй 2003 онд Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг баталж мөрдсөөр байна.³⁰ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах баталсан юм.

Жендэрийн үндэсний хорооны ажлын алба, НҮБ-ын Хүн амын сан, Эм Эм Си Жи ХХК тус хуулийн сүүлийн 10 жилд хэрхэн хэрэгжсэн байгааг Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх замаар тодорхойлсныг хүснэгтлэн үзье.³¹

Хүснэгт №4. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаан дахь жендэрийн тэгш байдлын үнэлгээ дүгнэлт

№	Хүрээ, харилцаа	Жендэрийн тэгш байдал
1	Улс төрийн хүрээ	Улс төрийн намын удирдах болон хууль тогтоох түвшин дэх хүйсийн харьцаа гажиж, эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй түвшинд байна.
2	Эдийн засгийн хүрээ	Эдийн засгийн хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах зарчим алдагдахад хүрчээ. Тухайлбал, цалин, бүтээмж, өсөлт өндөртэй салбаруудад эрэгтэйчүүд голлон ажиллаж, улс, орон нутгийн төсвийг хуваарилах шийдвэр гаргах түвшинд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчдийн дунд эрэгтэйчүүд давамгайлж байна.
3	Төрийн алба	Улс төрийн хүрээнд дэх жендэрийн тэгш байдлын баталгаа хангагдахгүй байгаагийн учир эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд албан тушаал ахих, удирдах албан тушаалд томилогдон ажиллах нь улс төрийн нөхцөл байдал, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх бололцоо, нийгэмд тогтсон хэвшмэл буруу ойлголт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байна. Төрийн албаны хууль тогтоомжид жендэрийн үзэл баримтлалыг тусгаагүйгээс шалтгаалж төрийн байгууллага, албан тушаалтнууд төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хариуцлагагүй хандаж иржээ. Төрийн алба жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд манлайлах үүрэг гүйцэтгэх нь дэлхийн жишигт нийцнэ.

29 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолын хавсралт. Дэлгэрэнгүй: <https://www.legalinfo.mn/annex/details/3140?lawid=6881>

30 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт. Дэлгэрэнгүй: <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

31 Жендэрийн үндэсний хорооны ажлын алба, НҮБ-ын Хүн амын сан, Эм Эм Си Жи ХХК, “Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ”, УБ., 2021, 21-22 дахь тал.

4	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа	Үүрэг хүлээгч ажил олгогчдын үүргийн хэрэгжилт ба эрх агуулагч иргэд, ажилтнуудын хууль ёсны эрхийн талаарх мэдлэг, эрхийн хэрэгжилтийг шаардах идэвх, хүчин чармайлт дутагдалтай байдлаас шалтгаалан жендэрийн эрх тэгш байдал алдагдахад хүргэж байна. Ажил олгогч үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай заавар, журам, бодлогын болон мэргэжлийн зөвлөмж өгөх, мөн ажилтандаа эрх үүргийг нь ухамсарлуулж ойлгуулах мэдээлэл сурталчилгааны дэмжлэг хангалтгүй байна. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн улмаас хөдөлмөр эрхлэлтэд жендэрийн тэгш бус байдал, шууд бус ялгаварлан гадуурхалт бий болж байна. Хөдөлмөрийн харилцааны суурь хууль болох Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид жендэрийн хувьд шударга бөгөөд зохистой хөдөлмөр эрхлэлт, эерэг ажлын байр, хүний нөөцийн мэдрэмжтэй удирдлагыг хангах талаарх заалт болон хуулийг хэрэгжүүлэх ажил учир дутагдалтай явж ирсэн байна.
5	Соёл, боловсролын салбар	Боловсролын байгууллагын ажиллагсад, ялангуяа сургуулийн өмнөх боловсролын байгууллага, бага, дунд сургуулийн багш нар, их, дээд, мэргэжлийн сургуулийн суралцагчдын хүйсийн харьцаа, жендэрт суурилсан дарамт зэрэг асуудал тулгамдсаар байтал оновчтой, шаардлагатай тохиолдолд тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар идэвх санаачилга дутмаг байжээ. ЖЭТБХТХ-д Соёлын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах үйл ажиллагаа орхигдсон байна.
6	Эрүүл мэндийн салбар	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, олон нийтийн мэдлэг, хандлага, дадлын дутагдалтай байдлаас шалтгаалан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэнд, дундаж наслалтад ихээхэн зөрүүтэй байдал бий болжээ. Эрүүл мэндийн бодлого нь өөрөө жендэрийн мэдрэмжгүй байгаа нь үүний шалтгаан болж байна.
7	Гэр бүлийн харилцаа	Жендэрийн тэгш бус байдал нэлээд амь бөхтэй байгааг жендэрийн хэвшмэл буруу ойлголтууд болон эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, түүнчлэн боловсрол, эрүүл мэндийн салбарт шууд ба шууд бусаар бий болсон жендэрийн алагчлалаар тайлбарлаж болохоор байна. Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн тэгш бус байдал нь жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн суурь нөхцөл болж байна.

Иргэний оролцооны талаарх зохицуулалт бүхий нийт 109 хуулийн 308 хэсэг, заалтын 74 хувь (81 хууль) тодорхой хэмжээнд хэрэгжиж, тухайн хуульд буй иргэний оролцооны аливаа заалт, зохицуулалт огт хэрэгжихгүй байгаа хуулиуд 24 хувь (28 хууль) эзэлжээ. Цаашилбал нийт 308 зохицуулалтын 31 хувь хангалттай хэрэгжсэн, 33 хангалтгүй хэрэгжсэн, 36 хувь зарим талаар хэрэгжиж байгаа хэмээн хяналт шинжилгээний дүн гарсан нь хуулиудад иргэний оролцооны тодорхой нэг механизм заасан байх боловч тухайн заалтыг төгсгөлд “оролцуулж болно”, “болно” гэх байдлаар тусгасантай холбоотой. Үүгээр тухайн заалтыг заавал биелэгдэх хэрэгжих шинжгүй болгож байна. Ийм заалтын хэрэгжилтийг үнэн зөв үнэлэхэд хүндрэлтэй. Хэрэв тухайн харилцаанд оролцуулаагүй бол тухайн заалтыг хэрэгжүүлээгүй гэж үзэхэд төвөгтэй юм. Учир нь болно гэж заасан нь тухайн заалтыг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтын үзэмжийн асуудал болж хувирах нь элбэг.

Сүүлийн жилүүдэд батлагдсан иргэний оролцооны механизм бүхий Нийтийн сонсголын тухай, Хууль тогтоомжийн тухай, Захиргааны ерөнхий хуулиудын иргэний оролцооны талаарх заалтын хэрэгжилт өнөөдрийн байдлаар хангалтгүй байгаа бөгөөд хуулийн хүчин төгөлдөр үйлчилсэн хугацаа бага тул иж бүрэн дүгнэлт хийх боломжгүй байна. Үндсэн хуульд тусгагдсан төрийн үйл хэрэгт иргэд оролцох, шийдвэрт нь нөлөөлөх боломжийг заасан эрх, үүрэг бүхий зохицуулалт нь холбогдох хуульд тусгалаа олсон ч зарим хуулийг хэрэгжүүлэх нөхцөл үүсээгүй (Ард нийтийн санал асуулгын тухай хууль), зарим хууль нь батлагдаад 20 гаруй жилийн хугацаа өнгөрсөн байгаа нь (Төрийн бус байгууллагын тухай хууль, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль) шилжилтийн үеийг туулсан манай улсын хувьд эрх зүй, нийгэм, эдийн засгийн

орчин нөхцөл өөрчлөгдөж байгаатай уялдуулан эдгээр хуульд шинэ хандлага, баримтлал нэвтрүүлэх бодит хэрэгцээ байгаа ажээ.

Манай улс эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан, хөхиүлэн дэмжсэн, хангасан бүтцийн шинжтэй алхамуудыг төрийн зүгээс авч байгаа ч үйл явцын талаас бодитой биелүүлэх, хэрэгжүүлэх, зохистой санхүү, техникийн, хүний нөөц дутмаг байсаар байна. Хүний эрхийн зөрчлийн шалтгаан – ялгаварлан гадуурхалттай хэрхэн тэмцсэн талаарх Засгийн газрын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцыг хэрэгжүүлсэн тайланд НҮБ-ын шинжээчдийн 1986 оноос хойш өгсөн дүгнэлт зөвлөмжийг багцлахад:

- Эмэгтэйчүүдийг эдийн засгийн талаас чадавхжуулах, эрх мэдэлтэй болгох, хөдөлмөр эрхлэх боломжоор хангуулах;
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийг баталгаажуулах;
- Хавчигдсан, гадуурхагдсан охид, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, боломж, бололцоог хангаж, хөхиүлэн дэмжих;
- Шийдвэр, бодлого гаргах түвшний оролцоог хуулиар жишиг тогтоож нэмэгдүүлэх;
- Охид, эмэгтэйчүүдийн талаар нарийвчилсан тоон мэдээлэл, сантай байх тухай зөвлөдөг. Үүнийг төрийн зүгээс эмэгтэйчүүдийн эрхийг хангахын тулд заавал гүйцэтгэх ёстой хэмээн дүгнэж байна.

Нөгөө талаар олон зууны турш эрхээ эдэлж чадаагүй, соёл, уламжлал, зан заншлын талаас инжээр үнэлэх, эд зүйлээр хэмжих, өөрөө хүсээгүй ч өмнөөс нь шийдвэр гаргаж болно гэж үздэг, эмзэг бүлэгт тооцож ирсэн охид, эмэгтэйчүүдийг хөхиүлэн дэмжиж, эрх тэгш байдлыг хангаснаар эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын хүрээнд ахиц дэвшил гарч, хөгжлийн үйл явцад эерэг нөлөөтэй байх болно.

Улс төрийн сонгуульд хандах эмэгтэй шинэ сонгогчийн хандлагыг тодорхойлох судалгаа

(Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн жишээн дээр)

Б.УЯНГА

МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Шинэ сонгогч, эмэгтэй шинэ сонгогч, эрэгтэй шинэ сонгогч, улс төрийн сонгууль, хандлага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль

Үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулиар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”¹ (УИХ, 1992) гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд сонгууль нь Монголын ард түмний хувьд төрөө байгуулж, төрийн хэргийг хөтлөн явуулахад оролцох чухал хариуцлагатай үйл ажиллагаа бөгөөд ардчилсан нийгэм оршин тогтнох гол нөхцөл юм.

Гэвч “дэлхийн түвшинд нийгэм, улс төрийн амьдралд хамгийн идэвхгүй бүлгийнхэн 18-25 насны сонгогчид байдаг”² (Х.Номингэрэл, 2019/12) бөгөөд манай улсын хувьд мөн адил 18-25 насны залуучуудын хувьд сонгуулийн идэвх хамгийн муу байгаа нь он оны сонгуульд оролцогчдын нэгдсэн дүнгээс харагдаж байна. 2016 онд энэ насны бүлгийн 2 хүн тутмын нэг буюу ойролцоогоор 50 хувь нь сонгуульд оролцоогүй бол 2020 оны сонгуульд 62 хувь нь оролцсон хэдий ч тус сонгуульд саналаа өгсөн нийт сонгогчдын хамгийн бага хувийг эзэлсэн байна.

Тийм ч учраас төрийн зүгээс сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэхэд сонгуулийн үед ихээхэн анхаардаг. Гэвч залуу сонгогчдын оролцоог дээшлүүлэхэд анхаарч тэдэнд чиглэсэн улс төрийн мэдлэг боловсрол олгох, улс төрийн оролцооны ач холбогдлыг ойлгуулах сургалт, сурталчилгааг зөвхөн сонгууль дөхөх үед зохион байгуулах бус 18 нас хүрч анх удаа сонгуульд оролцон саналаа өгөхөөс нь ч өмнө анхааран ажиллах хэрэгцээ шаардлага байна. Өөрөөр хэлбэл шинэ сонгогч буюу 18 нас хүрсэн анх удаа сонгуульд оролцох гэж буй сонгогчдын улс төрийн сонгуульд хандах хандлагыг тодорхойлж, шийдвэр гаргах, сонголт хийх чадварыг нэмэгдүүлснээр тэднийг улс төрийн үйл явцад ухамсартайгаар ханддаг, оролцдог, хариуцлагатай залуу сонгогчид болоход чухал нөлөөтэй юм.

¹ УИХ. (1992). Монгол улсын Үндсэн хууль. Уб.

² Номингэрэл, Х. (2019). Улс төрийн намууд, улс төрчид таалагдахгүй байгаа бол алтернатив сонголтыг бий болго. Нээлттэй улс төр, Уб. хуу 145

Зорилго:

18 нас хүрсэн анх удаа сонгуульд оролцох гэж буй шинэ сонгогчдын улс төрийн сонгуульд хандах хандлагыг тодорхойлох, ингэхдээ шинэ сонгогчдын сонгуульд хандах хандлага дахь жендэрийн ялгаатай байдлыг тодруулахад энэхүү илтгэлийн зорилго оршино.

Зорилт:

- 18 нас хүрсэн шинэ сонгогчийн хөгжлийн онцлог байдлын талаарх эх сурвалж, материалыг судлах
- Анкетын аргаар улс төрийн сонгуульд хандах шинэ сонгогчийн хандлагыг тодорхойлон түүнд боловсруулалт хийх
- Шинэ сонгогчдын сонгуульд хандах хандлага дахь жендэрийн ялгаатай байдлыг тодорхойлох
- Судалгааны үр дүнд үндэслэн шинэ сонгогчдын шийдвэр гаргах, сонголт хийх чадварыг нэмэгдүүлэх тухай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах

Судалгааны арга зүй:

- Баримт бичигт дүн шинжилгээ хийх
- Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга
- Асуулгын арга зэргээр судалгааны мэдээллийг цуглуулан SPSS 25 программ дээр боловсруулсан болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол судлаачид болох Ж.Даваа, Ж.Санжжав нар “18, 19 насны үеийг хүний амьдралын орь залуу үе”³ (Даваа Ж., 2008) гэж үзсэн байдаг. “Сургуулийн ахлах нас буюу орь залуу насанд бие хүн төлөвших үйл явцын өөрийгөө илэрхийлэх үндсэн шинж бүрэлдэн бий болдог”⁴. Өөрөөр хэлбэл энэ нас нь хүний хувийн чанар, ертөнцийг үзэх үзэл итгэл бүрэлдэн тогтож бие даасан амьдрал, үйл ажиллагаанд шилжих буюу бие хүн болж төлөвших хариуцлагатай үе юм.

Дараах өөрчлөлтүүд нь энэ насныхны хөгжлийн явцад илрэх гол онцлогийг тодорхойлж байдаг. Үүнд:

- Сэтгэл санаа тогтворгүй болох
- Бие махбодын эрчимтэй өсөлт
- Нийгмийн дунд биеэ авч явах хэм хэмжээг дагаж мөрдөх
- Эцэг эхчүүд, насанд хүрэгчдээс хараат бус байх, бие даах хүсэл эрмэлзэл нэмэгдэх
- Оюун ухааны эрчимтэй хөгжил явагдах
- Мэргэжил сонголтод анхаарал хандуулах
- Чөлөөт цагаа өнгөрөөх амьдралын хэв маяг өөрчлөгдөх
- Эсрэг хүйсийн хүнээ сонирхох
- “Би” адилтгал эрчимтэй явагдах гэх мэт.

³ Даваа, Ж. (2008). Хүн болох үе шат. Уб, хуу 43

⁴ Санжжав, Д. (2013). Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал. Уб, хуу 51

Манай улсад жил бүр дунджаар 25-35 мянган сурагч ЕБС төгсөж байгаа бөгөөд 2021 оны хувьд эдгээр төгсөгчид 18 нас хүрсэн бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд оролцож саналаа өгөх эрхтэй шинэ сонгогч болж байна.

АНУ-ын бага сургуулийн сурагчдын дунд хийсэн судалгаагаар бага насны охид, хөвгүүдийн ижил тэнцүү хувь нь ирээдүйд сонгуульд албан тушаалд өрсөлдөх хүсэл эрмэлзэлтэй байдаг байна. Гэтэл ерөнхий боловсролын сургууль төгсөх насанд хүрэх үед охидын улс төрийн амбиц ижил насны хөвгүүдийнхээс бага болж өөрчлөгддөг байна. Иймд шинэ сонгогчдын улс төрийн сонгуульд хандах хандлагыг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг мэдсэнээр тэдний улс төрийн сонгуулийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэн дэмжиж ажиллах боломж нээгдэх юм.


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгаанд оролцогчдын түүврийг бүрдүүлэхдээ Монгол улсын Статистикийн газрын хэрэглэдэг бүсчлэлийг жишээлэн баруун, төв, зүүн, хангайн, Улаанбаатар гэсэн 5 бүсийн дараах аймгуудын 18 нас хүрсэн шинэ сонгогчид буюу 12-р ангийн сурагчдын төлөөлөл хамрагдсан болно.

1. Баруун бүсийн Увс, Ховд аймгийн 60 шинэ сонгогч
2. Зүүн бүсийн Сүхбаатар, Хэнтий аймгийн 60 шинэ сонгогч
3. Төвийн бүсийн Төв, Дундговь аймгийн 60 шинэ сонгогч
4. Хангайн бүсийн Хөвсгөл, Булган аймгийн 60 шинэ сонгогч
5. Улаанбаатарын 60 шинэ сонгогч


Шинэ сонгогчдын улс төрийн сонгуульд хандах хандлагыг тодорхойлох зорилготой 14 асуулт бүхий уг судалгаанд дээрх 5 бүс тус бүрээс 60 анкет судалгаа авсан бөгөөд нийт 300 шинэ сонгогч хамрагдсан.

График №1 Судалгаанд оролцогчдын нас, хүйс



Судалгаанд нийт 300 шинэ сонгогч оролцсоноос 213 нь буюу 71 хувь нь эмэгтэй, 87 нь буюу 29 хувь нь эрэгтэй сонгогч байна. Насны хувьд нийт шинэ сонгогчид 18, 19 насныхан бөгөөд үүнээс 275 нь буюу 91.7 хувь нь 18 настай, 25 нь буюу 8.3 хувь нь 19 настай байна.

График №2 Таны бодлоор Монгол улсын хөгжлийн чиг хандлага зөв явж байна гэж үздэг үү?



Энэхүү графикаас үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 300 шинэ сонгогчийн 176 нь буюу 58.6 хувь нь Монгол улсын хөгжлийн чиг хандлагыг зөв эсвэл буруу чиглэлд явж байгаа эсэхийг хэлж мэдэхгүй байна хэмээн хариулсан байна. Энэхүү хариулттай эмэгтэй шинэ сонгогчдын 64 хувь нь, эрэгтэй шинэ сонгогчдын 48 хувь нь санал нийлсэн байна. Харин эрэгтэй шинэ сонгогчдын 48 хувь буюу дийлэнх нь Монгол улсын хөгжлийн чиг хандлагыг буруу чиглэлд явж байна хэмээн хариулжээ. Шинэ сонгогчид ямар учраас Монгол улсын хөгжлийг ийнхүү буруу чиглэлд явж байна хэмээн үзэж буйг тодруулсан “Та яагаад буруу чиглэлд явж байна гэж хариулсан бэ?” гэсэн асуултын 5 ба түүнээс дээш давтамжтай хариултыг дараах хүснэгтэд хариуллаа.


Хүснэгт №1 Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг буруу чиглэлд явж байна гэж үзэх болсон шалтгаан

Хариултууд	Давтамж	Эмэгтэй	Эрэгтэй
Хөгжихгүй байна	20	12	8
Ард түмний амьдрал хүнд байна	18	6	12
Улс төрчид өөрсдийн эрх ашгийг л боддог	13	8	5
Төр засгийн бодлого буруу, муу	11	7	4
Эдийн засаг муу	8	4	4
Мэдэхгүй	7	1	6
Авилга их	6	4	2
Боловсролд анхаардаггүй	6	6	0
Үйлдвэрлэл байхгүй	5	0	5

Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг буруу чиглэлд явж байна гэж үзсэн эмэгтэй болон эрэгтэй шинэ сонгогчдын хариултын давтамжийг харьцуулан үзэхэд эмэгтэй шинэ сонгогчдын дийлэнх нь Монгол улс хөгжихгүй байна, улс төрчид өөрсдийн эрх ашгийг л


боддог, төр засгийн бодлого буруу, авилга их, боловсролд анхаардаггүй гэсэн хариултыг өндөр давтамжтай өгсөн бол эрэгтэй шинэ сонгогчдын хувьд ард түмний амьдрал хүнд байна, мэдэхгүй, хөгжихгүй байна, үйлдвэрлэл байхгүй гэсэн хариултууд илүү өндөр давтамжтай байна. Үүнээс үзэхэд эрэгтэй шинэ сонгогчдоос илүү эмэгтэй шинэ сонгогчид асуудлын шалтгааныг тодорхой, нарийвчлан авч үзсэн хариултыг өндөр давтамжтай өгсөн бол эрэгтэй шинэ сонгогчдын хувьд илүү ерөнхий, тойм байдлаар авч үзсэн хариултыг өндөр давтамжтай өгсөн байна.

График №3 Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд саналаа өгөх эсэх



2021 оны хувьд 18 нас хүрсэн шинэ сонгогчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд оролцож саналаа өгөх эрхтэй болсон. Дээрх графикаас үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 300 шинэ сонгогчоос 204 нь буюу 68 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд оролцож, саналаа өгнө хэмээн хариулсан байна. Үүнээс эрэгтэй шинэ сонгогчдын 62 нь буюу 71.3 хувь, эмэгтэй шинэ сонгогчдын 142 нь буюу 66.7 хувь нь саналаа өгнө гэжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон шинэ сонгогчид эрэгтэй, эмэгтэй байхаас үл хамааран сонгуульдаа идэвхтэй оролцож, саналаа өгнө гэсэн хариултын сонголт хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.

Харин шинэ сонгогчид санал өгөхдөө хэний үзэл бодол, зөвлөгөөг илүү хүлээн авч шийдвэрээ гаргадаг болохыг тодруулсан асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.


График №4 Шинэ сонгогчдын санал өгөх шийдвэрт нөлөөлөх хүчин зүйл

Дээрх графикаас үзэхэд нийт судалгаанд хамрагдсан шинэ сонгогчид хэд хэдэн хүчин зүйлийг сонгох боломжтой, олон сонголт бүхий уг асуултад 243 нь буюу 81 хувь нь саналаа өгөх эсэх, хэнийг, ямар намыг дэмжиж саналаа өгөхөө өөрөө бие даан шийднэ хэмээн хариулсан байна.

Шинэ сонгогчидтой хийсэн фокус бүлгийн ярилцлагад Нийслэлийн Чингэлтэй дүүргийн “А” сургуулийн 18 настай шинэ сонгогч Б “...Эцэг эх, найз нөхөд гээд ойр дотныхоо хүмүүсийн үзэл бодол, ямар нэр дэвшигчийг дэмжих зэрэг яриа, зөвлөгөөг сонсох боловч эцсийн шийдвэрээ өөрөө гарганаа” гэжээ. Үүнээс үзэхэд шинэ сонгогчдын санал өгөх шийдвэрт өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээс илүү хүчтэй нөлөөлөх хүчин зүйл байхгүй болох нь харагдаж байна. Үүнийг шинэ сонгогчдын насны онцлогтой холбон тайлбарлаж болох юм. Өөрөөр хэлбэл энэ насанд өөрийгөө том хүн мэтээр хүлээн зөвшөөрүүлэх, өөрийгөө хэн бэ? гэдгийг таньж мэдэх нь энэ насны гол хэрэгцээ байдаг учир Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд хэн нэгнээс хамааралгүй, зөвхөн өөрийн итгэл үнэмшил, мэдлэг ойлголтдоо тулгуурлан бие даасан шийдвэр гаргана гэжээ.

Увс аймгийн Түүх, нийгэм судлалын багш Г ганцаарчилсан ярилцлагадаа “Сонгуульд анх удаа оролцож саналаа өгөх гэж байгаа шинэ сонгогчид ухаалаг сонголт, шийдвэр хийж чадахгүй гэж боддог. Учир нь энэ насныхан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг харьцуулан судлаад өөрийн үзэл бодлоор шийдвэр гаргах чадвар бага” гэжээ. Үүнээс үзэхэд шинэ сонгогчдод нийгмийн ухааны хичээлээр дамжуулан улс төрийн мэдлэг ойлголт өгч, улс төрийн сонгуулийн талаарх үзэл бодол, байр суурь зэргийг нь сонсож, ярилцаж байдаг нийгэм судлалын багш нарын хувьд шинэ сонгогчдыг бие даан ухаалаг сонголт, шийдвэр хийж чадахгүй, мэдлэг ойлголт дутмаг хэмээн үзэж байна.

Тэгвэл эдгээр шинэ сонгогчид өөрийн сонгуулийн талаарх ойлголт, мэдлэгээ хэрхэн үнэлж буйг тодруулахад дараах хариулыг өгсөн байна.

График №5 Шинэ сонгогчдын сонгуулийн талаарх ойлголт мэдлэг

Судалгаанд хамрагдсан шинэ сонгогчид өөрсдийн сонгуулийн талаарх ойлголт, мэдлэгийг хэрхэн үнэлж буйг тодруулахад нийт шинэ сонгогчдын 121 нь буюу 41 хувь нь өөрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгээ дундаж хэмээн хариулсан бол 113 нь буюу 38 хувь нь өөрийгөө сонгуулийн талаарх ойлголт мэдлэг сайтай хэмээн хариулсан байна. Үүнээс үзэхэд нийт сонгогчийн 87 хувь нь дундаж болон түүнээс дээш мэдлэг ойлголттой хэмээн өөрийгөө үнэлсэн байна. Харин эрэгтэй болон эмэгтэй шинэ сонгогчдын хувьд өөрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгийг хэрхэн ялгаатай үнэлж буйг дараах хүснэгтээр харууллаа.


Та өөрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгээ үнэлнэ үү

		Маш сайн	Сайн	Дундаж	Тааруу	Муу	Бүгд
Таны хүйс	Эрэгтэй	8	40	17	13	4	82
	Эмэгтэй	15	73	104	17	4	213
Бүгд		23	113	121	30	8	295

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдсан нийт эрэгтэй сонгогчдын 40 нь буюу 46 хувь нь өөрийн сонгуулийн талаарх мэдлэг ойлголтоо сайн хэмээн хариулсан бол эмэгтэй сонгогчдын 104 буюу 49 хувь нь өөрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгээ дундаж хэмээн хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл эмэгтэй шинэ сонгогчдоос илүү эрэгтэй шинэ сонгогчид өөрийн улс төрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгээ харьцангуй сайн гэж үзэж буй нь харагдаж байна.

Энэ тухай БЗД-ийн “Б” сургуулийн нийгэм судлалын багш Ө ганцаарчилсан ярилцлагадаа “...Эмэгтэй шинэ сонгогчдоос илүү эрэгтэй шинэ сонгогчдыг ухаалаг, зөв сонголт хийнэ гэж бодож байна. Гэхдээ яагаад гэдгийг мэдэхгүй байна” гэж хариулжээ. Үүнээс үзэхэд нийгэм судлалын хичээл зааж буй багш нарын дунд эрэгтэй учир эмэгтэйгээс илүү дээр, ухаалаг шийдвэр гаргаж чадна гэсэн жендэрийн хэвшмэл ойлголт байсаар байгаа нь харагдаж байна.

График №6 Шинэ сонгогчдын Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуультай холбоотой мэдээлэл авч буй эх сурвалж



Шинэ сонгогчид Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авч буйг энэхүү графикт харуулсан байна. Графикаас үзэхэд олон сонголт бүхий уг асуултад нийт судалгаанд оролцогчдын 255 нь буюу 85 хувь цахим эх сурвалжаас сонгуультай холбоотой мэдээ, мэдээллээ авдаг хэмээн хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлсэн байна.

Шинэ сонгогчидтой хийсэн фокус бүлгийн ярилцлагад Хэнтий аймгийн 18 настай шинэ сонгогч О “...Фэйсбүүкээс өөрт хэрэгтэй мэдээллээ авдаг. Учир нь сонирхолтой бас өөрийн завтай, хүссэн үедээ мэдээлэл авах боломжтой байдаг” гэжээ. **Үүнээс үзэхэд шинэ сонгогчдын хувьд** телевизийн мэдээнээс илүүтэй цахим эх сурвалж буюу **фэйсбүүк, мэдээллийн сайтуудыг** ашиглан хүссэн үедээ хэрэгтэй мэдээллээ төвөггүй олж авах болсон бөгөөд эдгээр цахим эх сурвалжид нийтлэгдэж буй мэдээ, мэдээллийн үндсэн дээр шинэ сонгогчдын улс төрийн сонгуулийн талаарх ерөнхий ойлголт, төсөөлөл бий болж байна.


График №7 Та Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхдөө аль намын нэр дэвшигчийг дэмжих бодолтой байна вэ?



Дээрх графикаас үзэхэд судалгаанд хамрагдсан шинэ сонгогчдын 135 нь буюу 45 хувь нь Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхдөө аль намын нэр дэвшигчийг дэмжихээ мэдэхгүй байна гэж хариулсан байна. Харин ХҮН-ын нэр дэвшигчийг 14 хувь, МАН-ын нэр дэвшигчийг 26 хувь, АН-ын нэр дэвшигчийг 13 хувь нь дэмжих бодолтой байгаа буюу судалгаанд хамрагдсан нийт шинэ сонгогчдын 53 хувь нь Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд аль намын нэр дэвшигчийг дэмжихээ урьдчилан шийдсэн байгаа нь харагдаж байна. Үүнээс эмэгтэй шинэ сонгогчдын 55 хувь, эрэгтэй шинэ сонгогчдын 43 хувь нь нь Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд аль намын нэр дэвшигчийг дэмжихээ урьдчилан шийдсэн байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан нийт шинэ сонгогчдын 246 нь буюу 84 хувь нь Монгол улсын Ерөнхийлөгчийг улс орны ирээдүй, хөгжилд чухал нөлөөтэй хүн хэмээн үзсэн бөгөөд Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн юуг нь хамгийн чухалчлан үзэж сонголтоо хийх вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

График №8 Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигчийн юуг нь хамгийн чухалчилж саналаа өгөх вэ?



Судалгаанд хамрагдсан шинэ сонгогчид Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигчийн эх оронч хандлага, боловсролын түвшин, хийсэн ажил, бүтээсэн зүйл, туршлага, хувь хүний зан чанар болон ажил мэргэжлийг маш чухал хэмээн үзсэн бол эсрэгээрээ тухайн нэр дэвшигчийн сонгогчдод мөнгө, эд баялаг тараах, эд хөрөнгийн байдал, нутаг ус, удам угсаа нь чухал биш хэмээн хариулсан байна.

Уг хариултын хүрээнд эрэгтэй болон эмэгтэй шинэ сонгогчдод ялгаатай байр суурьтай байгаа эсэхийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №2 Ерөнхийлөгчид нэр дэвшигчээс чухалчлан үзэж буй зүйл, хүйсээр

Нэр дэвшигчээс чухалчилах зүйл		Нийт	Эрэгтэй	Хувь	Эмэгтэй	Хувь
Боловсролын түвшин	Маш чухал	240	72	83%	168	79%
Нутаг ус, удам угсаа	Чухал биш	158	51	59%	107	50%
Хийсэн ажил, бүтээсэн зүйл, туршлага	Маш чухал	237	62	71%	175	82%
Эх оронч хандлага	Маш чухал	254	72	83%	182	85%
Хувь хүний зан чанар	Маш чухал	233	68	78%	165	77%
Ажил мэргэжил	Маш чухал	162	45	52%	117	55%
Эд хөрөнгийн байдал	Чухал биш	192	57	66%	135	63%
Мөнгө, эд баялаг тараах	Чухал биш	204	63	72%	141	66%

Дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн шинэ сонгогчдын хувьд эрэгтэй, эмэгтэй байхаас үл хамааран Монгол улсын Ерөнхийлөгч болохоор сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигчид саналаа өгөхдөө чухалчлах зүйл ерөнхийдөө адил байгаа нь харагдаж байна.

Харин нутаг ус, удам угсааг нийт шинэ сонгогчдын 53 хувь нь чухал биш хэмээн үзсэн бол энэ сонголттой эмэгтэй шинэ сонгогчдын 50 хувь, эрэгтэй шинэ сонгогчдын 59 хувь нь санал нийлсэн байна. Өөрөөр хэлбэл 2 эмэгтэй шинэ сонгогч тутмын 1 нь Монгол улсын Ерөнхийлөгч болох хүнийг удам угсаа сайтай эсэх, аль нутаг болохыг чухалчлан үзэж саналаа өгдөг байна.

Хүснэгт №3 Та Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхдөө дараах нэр дэвшигчийн шинжүүдээс алийг нь илүүд үзэх вэ?

Нэр дэвшигчийн шинжүүд		Нийт	Эрэгтэй	Хувь	Эмэгтэй	Хувь
1-р шинж	Олон удаа нэр дэвшсэн хүн	103	21	24%	82	38.5%
	Анх удаа нэр дэвшиж буй хүн	181	57	65.5%	124	58%
2-р шинж	Эрэгтэй нэр дэвшигч	206	64	73.6%	142	66.7%
	Эмэгтэй нэр дэвшигч	79	12	13.8%	67	31%
3-р шинж	Гадаадын томоохон сургуульд суралцсан хүн	220	64	73.6%	156	73%
	Дотоодын Их, дээд сургуульд суралцсан хүн	65	14	16%	51	24%
4-р шинж	Ухаалаг, хүлээцтэй зан чанартай	222	58	66.7%	164	77%
	Шийдэмгий хурц, зан чанартай	67	20	23%	47	22%
5-р шинж	Олны танил хүн	165	47	54%	118	55.4%
	Олны танил биш хүн	122	33	38%	89	41.8%

Дээрх хүснэгтэд үзүүлсэн мэдээллээс дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Шинэ сонгогчдын хувьд Ерөнхийлөгчийн сонгуульд олон удаа нэр дэвшиж өрсөлдсөн хүнээс илүү анх удаа нэр дэвшиж буй нэр цэвэр хүнийг дэмжин саналаа өгөх хандлагатай.
- Эмэгтэй болон эрэгтэй шинэ сонгогчид Монгол улсын Ерөнхийлөгчид эмэгтэй нэр дэвшигчээс илүү эрэгтэй нэр дэвшигч илүү тохирно хэмээн үзэж эрэгтэй нэр дэвшигчийг дэмжих хандлагатай.
- Монгол улсын Ерөнхийлөгч болохоор нэр дэвшиж буй хүн гадаадын томоохон сургуульд суралцан мэдлэг эзэмшсэн байвал шинэ сонгогчид дэмжин саналаа өгөх хандлагатай.
- Шинэ сонгогчид ухаалаг, хүлээцтэй зан чанартай хүнийг Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллахыг илүүд үзэж байна.
- Шинэ сонгогчид олны танил биш хүнээс илүү олон нийтийн дунд хийсэн ажил, бүтээсэн зүйлээрээ танигдсан, олны танил хүнийг дэмжин саналаа өгөх хандлагатай.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар улс төрийн сонгуульд хандах эмэгтэй шинэ сонгогчийн хандлагыг тодорхойлохын тулд эрэгтэй шинэ сонгогчдын хандлагатай харьцуулан судалж үзлээ. Судалгааны үр дүнд орь залуу нас нь бие хүн болж төлөвших чухал нас байдаг тул шинэ сонгогчид өөрийгөө насанд хүрэгчдэд тэдэнтэй эн тэнцүү, том хүн мэтээр хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээ шаардлага бий болдог. Тийм ч учраас насанд хүрсэн хүн бүрд яг ижил олгогдож буй санал өгөх эрхээ хэнээс ч хамааралгүй, зөвхөн өөрийн итгэл үнэмшил, мэдлэг ойлголтдоо тулгуурлан эдэлнэ хэмээн судалгаанд оролцогчдын 81 хувь нь үзсэн байна. Өөрөөр хэлбэл шинэ сонгогчид эрэгтэй, эмэгтэй байхаас үл хамааран 2021 оны Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд идэвхтэй оролцож, саналаа өгөхдөө өөрийн бие даасан шийдвэрийг гаргах хүсэл эрмэлзэлтэй байна.

Түүнчлэн шинэ сонгогчдын хувьд анх удаа нэр дэвшиж буй нэр цэвэр, гадаадын томоохон сургуульд суралцсан боловсролтой, ухаалаг хүлээцтэй зан чанартай, хийсэн ажил, бүтээсэн зүйлээрээ олон нийтэд танигдсан эрэгтэй нэр дэвшигчийг Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллахыг илүүд үзсэн байна. Өөрөөр хэлбэл улс төр, нийгмийн амьдралын орон зай бол эрчүүдийнх гэх хандлагатай эрэгтэй шинэ сонгогчдын 74 хувь, эмэгтэй шинэ сонгогчдын 67 хувь нь санал нийлсэн байна.

Улс төрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгийн тухайд эрэгтэй сонгогчдын дийлэнх буюу 46 хувь нь өөрийн сонгуулийн талаарх мэдлэг ойлголтоо сайн хэмээн хариулсан бол эмэгтэй сонгогчдын дийлэнх буюу 49 хувь нь өөрийн сонгуулийн талаарх ойлголт мэдлэгээ дундаж хэмээн хариулсан байна. Өөрөөр хэлбэл эрэгтэй шинэ сонгогчид эмэгтэй шинэ сонгогчдоос илүү улс төрийн сонгуулийн талаар мэдлэг, ойлголттой гэж өөрийгөө үнэлсэн байна. Улс төрийн талаар сайн мэдлэгтэй хүмүүс улс төрд илүү идэвхтэй оролцдог гэдэг. Гэтэл нөгөөтээгүүр нийгэмд тогтсон жендэрийн уламжлалт хэм хэмжээ болох улс төрийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэй хүн илүү тохирно, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү ухаалаг сонголт, шийдвэр гаргаж чадна хэмээн үзэх нь эмэгтэй шинэ сонгогчдын өөрийгөө бодитоор үнэлэх, тэдний улс төрийн оролцоонд саад болж байгаа юм.

Мөн судалгаанд хамрагдсан шинэ сонгогчдын 85 хувь цахим эх сурвалжаас улс төрийн сонгуультай холбоотой мэдээ, мэдээллээ авдаг хэмээн хариулсан. Иймд цахим эх сурвалжийн шүүлтүүртэй, шүүлтүүргүй олон мэдээ, нийтлэлийг үзэл бодол, итгэл үнэмшил нь төлөвшөөгүй шинэ сонгогчид шүүмжлэн хүлээж авч, нягтлан шалгах мэдлэг чадварыг

нэмэгдүүлэх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл шинэ сонгогчид дан ганц сонгуульд саналаа өгөх эрхээ эдэлдэг иргэн байгаад зогсохгүй нэр дэвшигчдийн тараах материал, мөрийн хөтөлбөрийг харьцуулан судалж сонголт, шийдвэрээ гаргадаг хариуцлагатай сонгогч байх нь чухал юм.

Санал болон шийдэл

- ✓ Сонгогчдын сонгуулийн талаарх ойлголт, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх тухай асуудлыг зөвхөн сонгуультай холбоотойгоор анхаарч үзэх бус ЕБС-д суралцаж байх хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс анхаарах.
- ✓ Анх удаа сонгуульд оролцож саналаа өгөх гэж буй шинэ сонгогчдод “Туршилт сонгууль” зохион байгуулах замаар сонгуульд хэрхэн хандах, яаж ухаалгаар сонголт шийдвэрээ гаргах тухай бодит туршлагыг олгох.
- ✓ ЕБС-ийн багш нарын жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах.

Ашигласан материал

1. Даваа, Ж. (2008). *Хүн болох үе шат*. УБ: МУИС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
2. Мягмар, О. (2012). *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд*. УБ.
3. Санжжав, Д. (2013). *Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал*. УБ.
4. Одгэрэл, Б. (2017). *ЕБС-ийн төгсөгчдийн улс төрийн боловсролын асуудал*. Залуучууд судлал, 46-51
5. Эрдэнэдалай, Б. (2019/12). Залуучуудын сонгуулийн ирц, оролцооны асуудал. *Нээлттэй улс төр*, 103-109 хуу
6. Мягмарцоож, Н. (2021). *Залуу сонгогчдын ирц, түүнд нөлөөлөх хүчин зүйлс*, ikon.mn.
7. Номингэрэл, Х. (2019/12). Улс төрийн намууд, улс төрчид таалагдахгүй байгаа бол алтернатив сонголтыг бий болго. *Нээлттэй улс төр*, 144-148
8. John B. Holbein and Hillygus D. Sunshine. “Making Young Voters: The Impact of Preregistration on Youth Turnout”. *American Journal of Political Science*, Vol 60, Issue 2 (March 2015), pp. 364-382
9. КАСан. Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/ судалгааны тайлан, УБ., 2016 он. Төлбөргүй холбоос: http://ivote.mn/files/kas_45694-1522-18-30.pdf
10. IRIM. Залуучуудын санал бодлын судалгаа, УБ., 2020 он. Төлбөргүй холбоос: https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf
11. Нийгмийн Бодлого Хөгжил Судалгааны Хүрээлэн. Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа, УБ., 2016 он. Төлбөргүй холбоос: https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf
12. www.1212.mn
13. УИХ. (1992). *Монгол Улсын Үндсэн Хууль*. УБ.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эсрэг шинэ хориг саад: цахим хүчирхийлэл, тролл

Т.ТУЯАЧИМЭГ

МУБИС-ийн улс төр судлалын докторант

Түлхүүр үг: Жендэрийн ташаа ойлголт, хандлага, Цахим хүчирхийлэл, Тролл

Судалгааны арга зүй, онолын үндэс

Энэхүү судалгаанд “Үзэл бодлын феминист онол”-д (Standpoint feminist theory) тулгуурласан арга зүйг ашигласан бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулах, тайлбарлахад ашиглав. Тус онол нь нийгэм дэх мэдлэгийг хэмждэг “объектив байдал” гэсэн хэмжүүрийг, “эрх мэдлийн харилцааг тодорхойлох” ийм аргыг шүүмжилдэг. (Stanley & Wise 1993, p.167). Мөн энэ онолын төлөөлөгч судлаач Донна Харавей (1991) мэдлэг бүхэллэг байдлаар оршиж байлаа гэхэд бүх мэдлэг хэсэгчилсэн шинжтэй байдаг гэж үзсэн. Судалгааны арга “хатуу” тоон мэдээлэлд тулгуурласан ч гэсэн хэзээ ч бодитой \цэвэр объектив \ байж чадахгүй. Судлаач нь эрэгтэй, эмэгтэй, за ер компьютер байлаа ч гэсэн мэдээллийг ямар ч субъектив нөлөөгүй боловсруулж чадахгүй гэж үзэл бодлын феминист судлаачид шүүмжилдэг¹. Үүнээс үзэхэд хатуу тоон тэр дундаа ихээхэн хэмжээний тоон мэдээллээр “үнэн” батлагдахгүй бөгөөд судалгааны загварыг, асуултыг тодорхойлохдоо судлаач “туршлага”-даа тулгуурлаж болно.

Энэхүү судалгаанд “Үзэл бодлын феминист онол”-д тулгуурласан феминист судалгааны аргаар анализ хийсэн. Анализ хийх утгыг тодорхойлохдоо 2020 онд нийтлэгдсэн “Цахим ташаа мэдээлэл нь жендэрийн талаарх үзэн ядалтыг өдөөх нь” судалгааны өгүүлэлд тулгуурлав. Тус өгүүлэлд судлаачид эмэгтэй улс төрчдийн эсрэг жендэрийн талаарх цахим ташаа мэдээллийн дараах хэлбэрүүд² байгааг онцлон судалсан. Үүнд:

- Эмэгтэйчүүдийг улс төрийн ажилд тохирохгүй гэх зэргээр бусдад итгүүлэх:
- Эмэгтэйчүүдийг улс төр, олон нийтийн амьдралд хэтэрхий тэнэг гэж буруутгах
- Эмэгтэйчүүдийн сайн туршлага, авч хэрэгжүүлсэн үйл хэрэг, бодлого зэргийн талаар ярихаас эмээх
- Эмэгтэйчүүдийн гадаад төрх байдалд хэт анхаарах тачаангуй гэх зэргээр буруушаах

¹ Nicole Westmarland. (2001). Quantitative/Qualitative Debate and Feminist Research: A Subjective View of Objectivity. *The journal qualitative social research*. Volume 2, No. 1, Art. 13 – February 2001

² Ellen Judson., Asli Atay., Alex Krasodomski-Jones. (2020). *Engendering hate the contours of state-aligned gendered disinformation online*. Retrieved from <https://demos.co.uk/wp-content/uploads/2020/10/Engendering-Hate-Report-FINAL.pdf>

- Хүчирхэг эрчүүд эмэгтэйчүүдийг хамгаална гэж хандах
- Эмэгтэйчүүдийн эрхэмлэдэг үнэт зүйлсийг шүүмжлэх

Судалгааны үр дүн: Хэн тролл вэ?

Жендэрийн талаарх ташаа мэдээлэл гэдэг нь хүйсд тулгуурлан дайрч доромжлох үйл ажиллагаа (контент үүсгэх, хуваалцах, түгээх) хэлбэрээр илэрдэг.

Гүүгл хайлтын системд 2021 оны 10 сарын 6 нд “Эмэгтэй улс төрч 2020” утгаар хайлт хийж илэрсэн мэдээллээс нэг нийтлэлийг сонгон авч шинжлэв. Уг нийтлэл нь 27 өгүүлбэрээс бүрдсэн. 3 хэсэг өгүүлбэрийг томоор бичиж тодотгосон. Нийтлэлийн гарчиг, томоор бичиж тодотгосон хэсэг болон нийтлэлийн агуулгад жендэрийн талаарх ташаа мэдээллийн утгыг задалбал:

Диаграмм 1. Нийтлэлийн агуулга




Дээрх диаграммаас харвал судалсан нийтлэлд эмэгтэй улс төрчдийг улс төр, олон нийтийн амьдралд хэтэрхий тэнэг гэж буруутгах, хүчирхэг эрчүүд нийгэм, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдээс илүү гэсэн хандлага давамгайлж байна.

Нийтлэлд томоор тодруулсан 3 хэсгийн агуулгыг жендэрийн талаарх ташаа мэдээллийн үзүүлэлтээр харвал:

Хүснэгт 1. Нийтлэлийн агуулга дахь жендэрийн ташаа хандлага

Үзүүлэлт/утга	Нийтлэлд тодруулсан хэсгээс
Эмэгтэйчүүдийг улс төрийн ажилд тохирохгүй гэх зэргээр бусдад итгүүлэх:	Сонгогдсон цагаасаа хойш нийтийн эрх ашиг руу хандсан ганц дорвитой хууль санаачлах батлуулах нь бүү хэл хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх ашгийн төлөө хуруугаа ч хөдөлгөөгүй.
Эмэгтэйчүүдийг улс төр, олон нийтийн амьдралд хэтэрхий тэнэг гэж буруутгах	УОК-ын шийдвэрийг урьдчилаад мэдсэн УИХ-ын эмэгтэй гишүүдийн тэрхүү мэдэгдэл, үйлдэл чин сэтгэлийнх гэхээсээ илүү улстөржсөн үйлдэл болж харагдсан.
Эмэгтэйчүүдийн сайн туршлага, авч хэрэгжүүлсэн үйл хэрэг, бодлого зэргийн талаар ярихаас эмээх	Энэ удаагийн парламентын эмэгтэй гишүүд ч мөн адил хууль санаачлах, лоббидон батлуулах ажилд хамтдаа зүтгэсэн гэж лав дуулдаагүй.
Эмэгтэйчүүдийн гадаад төрх байдалд хэт анхаарах тачаангуй гэх зэргээр буруушаах	-
Хүчирхэг эрчүүд эмэгтэйчүүдийг хамгаална гэж хандах	Харамсалтай нь, парламентад гарч ирсэн эмэгтэй гишүүд эрчүүдээсээ дээрдэх юмгүй хулгайч, худалч, албан тушаалд шуналтай болохоо аль хэдийнэ таниулчихаад байгаа.
Эмэгтэйчүүдийн эрхэмлэдэг үнэт зүйлсийг шүүмжлэх	Жендэрийн түрий барьж, зарим нь сохор азаар шахуу гишүүн болсон хүн тэдний дунд бий.

Ганц нэгээр тоологдох нийтлэлд жендэрийн талаарх ташаа ойлголт хандлага нэвт шингэсэн нь ямар сөрөг үр дагавар авчирарх вэ? Нийтлэл эмэгтэй улс төрчдийн талаар жендэрийн талаарх ташаа хандлага бүхий агуулгатай байгаа нь сэтгэгдлийн өнгө аясыг шууд тодорхойлсон байна. Үдиаграмм 2 үзнэ үү.

Диаграмм 2. Нийтлэлийг дагасан сэтгэгдэл

Нийтлэлийн агуулга эмэгтэй улс төрчдийн талаарх жендэрийн ташаа ойлголт хандлагаар бичигдсэн тул сэтгэгдлийн 71% сөрөг байна.

Цахим орчин дахь мэдээ мэдээллийн агуулга нь уг үзэгдэл, үйл явцын талаарх үзэгч/цахим хэрэглэгчийн ойлголт хандлагыг тодорхойлох, нөхцөлдүүлэгч суурь хүчин зүйл болж байна. Сөрөг сэтгэгдлийн дотор нь маш сөрөг, ерөнхийдөө сөрөг гэх зэргээр түвшинчилж харах ялгаа ажиглагдав.

Хүснэгт 2. Сөрөг сэтгэгдлийн түвшин

Хандлага	Сэтгэгдэл
Маш сөрөг	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй хүнээс илүү шуналтай бузарууд Янхан кнопчид Мөөмөө унжуулсан феминистүүд Увайгүй авгайчууд Алаад ч хамаагүй төрөөс зайлуулбал таарна Намын бөгс долоогч янханууд Хоёр нөхрийн өвөр дулаацуулсан банзалууд Бүгд хулгайч дэвсгэр
Дундаж	<ul style="list-style-type: none"> Утсан хүүхэлдэйнүүд Их хуралд квотын ачаар тухалсан хүүхнүүд Хийсэн ажилгүй, суудлын тоо бөглөсөн Азаар гишүүн болсон Хоосон толгойтой
Ерөнхийдөө сөрөг	<ul style="list-style-type: none"> Эмэгтэй гишүүн байгаад нэмэргүй Эмэгтэй гишүүд өрөвдмөөр юмаа Эмэгтэй хүн эх хүний сэтгэлээр Ковид болон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хандаач Амлалтаа биелүүлэхгүй өөрийгөө рекламдаад байна Хэдэн өндөр өсгийтнүүд загвардахаас өөр юу хийдэг вэ.

Эмэгтэй гишүүд огцорвол асуудал шийдэгдэх үү, нийгмийн бүх болохгүй юм эмэгтэй гишүүдийн асуудал уу, манай нийгмийг троллууд удирдаад байна, үүнийг зарим иргэд ойлгохгүй байна зэрэг төвийг сахисан сэтгэгдлүүд байгаагаас сэтгэгдэл бичсэн цахим хэрэглэгчид өөр хоорондоо муудалцсан байсан.

Тролл гэдэг нь «Троллинг» гэж нэрлэгддэг онлайн хүчирхийлэл. Интернет орчинд хүн хоорондын, нийгмийн эсрэг зан үйл бөгөөд онлайннаар дээрэлхэх, дарамтлах хэлбэр ³юм.

Судлаач Ж.Бишоп цахим орчинд улс төрийн аливаа асуудлаар нэгдэл үүсгэн бөөгнөрч байгаа олны дунд троллдох үзэгдлийг судалж тэднийг 12 ангилсан.

Хүснэгт 3. 12 төрлийн тролл ⁴

Хэлбэр	Троллын характер, баримжаа	Тодорхойлолт
“Үзэн ядагч” тролл	Илэрхий биш	“Өшөө хорсол”-д тулгуурласан. Тодорхой хүнийг онилон дагаж троллддог.
	Ноцтой	“Сүйтгэгч” шинжтэй. Баримт ашиглан бусдад үнэнийг олж мэдэхэд туслах зорилготой боловч зөрчилтэй.
	Мэдэгдэхүйц	“Нийгмийн эсрэг” шинжтэй. Зугаа хийх маягаар хор хөнөөл учруулахуйц троллддог.
“Итгэмтгий байдлыг далимдуулдаг” тролл \Lolcow ⁵ \	Илэрхий биш	“Захиалгат” шинжтэй. “Чухал царайлсан” энэ төрлийн тролл нь олонд таалагдах зүйлсийг нийтлэх замаар троллддог.
	Ноцтой	“Үхэл царайлсан” тролл. Өөрийгөө буруутгах, үгүйсгэх замаар бусдаар өрөвдүүлэн троллддог.
	Мэдэгдэхүйц	“Байнгын” шинжтэй. Чат ашиглан бусдыг итгэлийг олж авах замаар троллддог.

³ Shazia Akhtar.(2019) Catriona M. Morrison The prevalence and impact of online trolling of UK members of parliament. *Computers in Human Behavior*, 99, 322–327. <https://doi.org/10.1016/j.chb.2019.05.015>


⁴ Jonathan Bishop. (2014). *Dealing with Internet Trolling in Political Online Communities: Towards the This Is Why We Can't Have Nice Things Scale*. *International Journal of E-Politics*, 5(4), 1-20, October-December 2014

⁵ LOLcow хэмээх үг нь LOL, үхэр гэсэн үгийн нийлбэр. Онлайннаар хэрэглэгчийн итгэмтгий зан авирыг ашиглан тролл хийдэг. 2007 оноос албан ёсоор тэмдэглэн хэрэглэж ирсэн.

“Ташаа мэдээлэл түгээгч” тролл	Илэрхий биш	“Хүлцэнгүй” байдлыг ашигладаг. Бусдын санаа зовнилтой эвлэрэх замаар троллддог.
	Ноцтой	“Бүтээлч” шинжтэй. Бусдад тустай гэж үзсэн контент бүтээж, хуваалцах замаар троллддог.
	Мэдэгдэхүйц	“Нийтэч” шинжтэй. Бусдыг олонтойгоо ижил байхад нь туслах замаар троллддог.
“Их мэдэгч” тролл	Илэрхий биш	“Зааварчилгаа” ашиглан троллддог. Дэмжиж байвал лайк дарна уу, шэйрлэнэ үү гэх зэргээр урхиддаг.
	Ноцтой	“Эмх журамгүй” байдлыг ашигладаг тролл. Бусдыг зугаацуулангаа троллддог. Энэ төрлийн тролл нь нийгэмд инээд наргиа авчирдаг боловч цаад талд нь золгүй явдлыг өдөөн хатгаж байдаг.
	Мэдэгдэхүйц	“Уусгах” замаар троллддог. Ихэвчлэн шинэ хэрэглэгч, шинэ гишүүдэд зориулж туршлагатай хэрэглэгч троллддог.

Энэхүү өгүүлэлд шинжилсэн сайтын нийтлэлийн коментууд “Үзэн ядагч” хэв маягийн троллын шинжтэй байна. Эмэгтэй улс төрчдийн талаар жендэрийн хэвшмэл ойлголт бүхий мэдээ нийтлэл тэдний эсрэг хүчирхийллийн шинжтэй байна. Олон нийтэд хандан үзэн ядалт төрүүлэх, алж устгахыг уриалах, улс төрд ажиллуулах, эмэгтэйчүүдийг сонгохгүй байхыг уриалсан, эмэгтэй хүн улс төрч байгаад ямар ч өөрчлөлт авчиргахгүй гэх мэтээр өдөөн турхирч байна.

Зураг.1 <https://news.mn> сайтын “Эмэгтэй гишүүдээс ичиж байна” гарчигтай нийтлэлийн сэтгэгдлийн үзүүлэлт. 2021 оны 10 сарын 7 өдөр сайтаас шууд татав.



Нийтлэлийн агуулга ямар байна сэтгэгдэл мөн тийм үр дүнтэй гарч байгааг хараад гайхах зүйл алга. Нийт сэтгэгдлийн 65% нь баас \роор\ эможи дарсан байна. Энэхүү баасны дүрстэй эможиг хатуу хог хаягдлын талаар ярихад ашиглагддаг боловч новш эсвэл хог гэсэн үгсийг орлуулахад хэрэглэгддэг. Ихэвчлэн ёжилсон байдлаар ашигладаг⁶. Улс орон бүрд эможиг ялгаатай утгаар хэрэглэх тохиолдол цөөнгүй. Баасны дүрстэй эможиг 1999 онд Японд хэрэглэж эхэлсэн. Япон хэлээр баас (unko) гэдэг үг “аз” гэсэн үгтэй ижил утгатай. 2007 онд Gmail -д зориулж Японы эможи ашиглахаар шийдэж, баасны дүрстэй эможиг Америкчуудад танилцуулсан.⁷ Харин Монголд баасны дүрстэй эможиг санамсаргүй “аз” гэсэн утгаар хэрэглээгүй нь лавтай.

Ийнхүү хэн тролл вэ? гэсэн асуултаа ахин асуух шаардлагатай болж ирлээ. Интернэтийн орчинд жендэрийн мэдрэмжгүй мэдээ нийтлэл бичсэн сэтгүүлч үү? Жендэрийн талаарх ташаа мэдээллийг даган хөөсөрсөн цахим хэрэглэгч үү? Монголын олон уншигчтай өөр нэг сайтад нийтэлсэн нийтлэлд зохиогч “эмэгтэй хүн, эх хүн л яс махаараа мэдэрч, эмзэглэх ийм асуудалд ингэж хандсан хэрнээ сайдын суудал онгойхоор эм хүйсээрээ түрээ барин, албан бичиг шидэж суугааг нь дуугүй харах, жендэрийн мэдрэмжтэй хүн болох гэж

⁶ https://www.macmillandictionary.com/dictionary/british/poop_1

⁷ <https://www.dazeddigital.com/artsandculture/article/246871/what-does-the-stinky-poop-emoji-really-mean>

тэднийг хөөргөх хүсэл даанч төрөхгүй нь”⁸ гэж бичсэн.

“Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжит байлдын шалгуур үзүүлэлт” (2014)-ийг эш үндэс болгон дүгнэвэл хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдалд тустай ёс зүйн код мөрддөг эсэх, хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний агуулга боловсруулахад оролцогч жендэрийн ухамсартай сэтгүүлчидтэй эсэхийг хэмжин сэтгүүлчдэд жендэрийн боловсрол олгох хэрэгцээ шаардлага өнөөдөр ч чухал ач холбогдолтой байна. Жендэрийн мэдрэмжгүй сэтгүүлч гэж хэлүүлэх нэг хэрэг, түүний бичсэн нийтлэл ямар үр дагавар авчирч болохыг нийтлэлд хийсэн шинжилгээнээс харж болно. Нөгөө талаар цахим орчин дахь мэдээ мэдээллийн агуулга нь уг үзэгдэл, үйл явцын талаарх үзэгч/цахим хэрэглэгчийн ойлголт хандлагыг тодорхойлох, нөхцөлдүүлэгч хүчин зүйл болж байгаа тул сэтгүүлч тролл биш биз? Жендэрийн мэдрэмжгүй сэтгүүлч байх, тролл байх хоёр хамрах хүрээ, хор хөнөөлөөрөө ялгаатай.

Жендэрийн талаарх хэвшмэл ойлголт бүхий өгүүлэл, нийтлэл нь:

- эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгмийн өмнө хүлээсэн үүргийг уламжлагдан тогтсон “эмэгтэйлэг”/“эрэгтэйлэг” шинжээр дүрслэн харуулах,
- үүнийг хэвийн, хувиршгүй үзэгдэл гэх ойлголт төрүүлэх,
- эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм дэх бусад боломжит шинж чанар, үүрэг хариуцлагыг үгүйсгэж байвал эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хориг саад учруулсаар байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч буй цахим хориг саад

Цахим орчинд байгаа жендэрийн талаарх ташаа мэдээлэл нь эмэгтэй улс төрч болон улс төрд дөнгөж хөл тавьж буй залуу эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралаас холдуулах, зүй бусаар доромжлох, тэдний дуу хоолойг чухал биш гэж олон нийтэд итгүүлэх зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөн цахим хүчирхийлэл нь хувь хүн талд нь сэтгэл зүйн хямралд оруулах, байнга дайрч давшлах, эрүүл саруул улс төрийн яриа хөөрөө, мэтгэлцээнд оролцох арга замыг хаан боогдуулах, олон нийтэд эмэгтэй улс төрчдийн үүрэг ролийн талаар ташаа мэдээлэл өгөх зэрэг олон төрөл хэлбэртэй.

2010 онд Английн парламентын 239 гишүүнийг оролцуулсан судалгаагаар парламентын гишүүдийн 81% нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн⁹, 18% нь халдлага, 42% нь заналхийлэл, 22% нь эд хөрөнгийн хохирол амссан дүн гарчээ. Судалгаанд хамрагдагсдын 53% -д тэднийг мөрдөн мөшгих, танхайрах явдалтай нүүр тулсан байна. Харин цахим хүчирхийлэлд өртсөн тухайгаа парламентын гишүүдийн 10% нь нийгмийн сүлжээгээрээ мэдээлсэн байна.

Германы Ногоон намын тэргүүн Катерина Шульцд өдөр тутам ирдэг цахим мессэжийн 20% нь хүчирхийлэл бүхий агуулгатай байдаг¹⁰ хэмээн мэдээлжээ. 10 эмэгтэй парламентын гишүүдийн 9 нь цахимаар хэл амаар доромжлуулах зэрэг вербаль хүчирхийллийн золиос болсон байна. Мөн 2019 онд хийсэн судалгаагаар залуу эмэгтэй парламентын гишүүд цахим хүчирхийллийн бай болж байгааг илрүүлсэн. Монголд цахим сүлжээгээр олон нийт, сонгогчид өөр хоорондоо хийж буй явган хэрүүл, шог, хоёрдугаар сувгийн яриа ирээдүйн залуу охид, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлж байвал энэ ардчилал биш.

⁸ “Албан тушаал харахаараа амь ордог гишүүд үү дээ” гарчигтай нийтлэл www.unuudur.mn 2021 оны 1 сарын 29

⁹ Shazia Akhtar.(2019) Catriona M. Morrison The prevalence and impact of online trolling of UK members of parliament. *Computers in Human Behavior*, 99, 322–327. <https://doi.org/10.1016/j.chb.2019.05.015>

¹⁰ Guerin, C., Spring, M. and Webster, L. (2019). *A web of abuse: How the far right disproportionately targets female politicians*, BBC

Монголд цахим хүчирхийлэл бүхий агуулгатай хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн мэдээлэл бичдэг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарынхан тролл маягтай байгаа нь санаа зовоож байна. Хэвлэл мэдээллийн байгууллага төрд хяналт тавих үүргээ гүйцэтгэх явцдаа эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хориг саад болох ёсгүй. Нийгмийг соён гэгээрүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих шударга ёсны үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх үүргээ умартаж болохгүй.

Дүгнэлт

Эмэгтэй улс төрчдийн талаарх цахим нийтлэл жендэрийн ташаа хандлагатай байна. Түүн дотроо эмэгтэй улс төрчдийг улс төр, олон нийтийн амьдралд хэтэрхий тэнэг гэж буруутгах, хүчирхэг эрчүүд нийгэм, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдээс илүү гэсэн хандлага давамгайлж байна. Нийтлэл эмэгтэй улс төрчдийн талаар жендэрийн талаарх ташаа хандлага бүхий агуулгатай байгаа нь сэтгэгдлийн өнгө аясыг шууд тодорхойлох шинжтэй. Ийм төрлийн нийтлэлийн коментууд “Үзэн ядагч” хэв маягийн тролл. Эмэгтэй улс төрчдийн талаар жендэрийн хэвшмэл ойлголт бүхий мэдээ нийтлэл тэдний эсрэг хүчирхийллийг өөгшүүлж байна. Нийт сэтгэгдлийн 65% нь баас \роор\ эможи дарсан байна. Энэхүү баасны дүрстэй эможиг хатуу хог хаягдлын талаар ярихад ашиглагддаг боловч новш эсвэл хог гэсэн үгсийг орлуулахад хэрэглэж байгааг анхаарахгүй орхиж болохгүй.

Ном зүй

Судалгааны өгүүлэл

1. Nicole Westmarland. (2001). Quantitative/Qualitative Debate and Feminist Research: A Subjective View of Objectivity. The journal qualitative social research. Volume 2, No. 1, Art. 13 – February 2001
2. Ellen Judson., Asli Atay., Alex Krasodonski-Jones. (2020). Engendering hate the contours of state-aligned gendered disinformation online. Retrieved from <https://demos.co.uk/wp-content/uploads/2020/10/Engendering-Hate-Report-FINAL.pdf>
3. Jonathan Bishop. (2014). Dealing with Internet Trolling in Political Online Communities: Towards the This Is Why We Can't Have Nice Things Scale. International Journal of E-Politics, 5(4), 1-20, October-December 2014 Retrieved from file:///C:/Users/Acer/Downloads/doc1JEPaper_TIWWCHNT.pdf
4. Shazia Akhtar.(2019) Catriona M. Morrison The prevalence and impact of online trolling of UK members of parliament. *Computers in Human Behavior*, 99, 322–327. <https://doi.org/10.1016/j.chb.2019.05.015>
5. Guerin, C., Spring, M. and Webster, L. (2019). A web of abuse: How the far right disproportionately targets female politicians, BBC

Вэб сайт:

1. <https://news.mn> сайтын “Эмэгтэй гишүүдээс ичиж байна” гарчигтай нийтлэлийн сэтгэгдлийн үзүүлэлт. 2021 оны 10 сарын 7 өдөр сайтаас шууд татав.
2. www.unuudur.mn “Албан тушаал харахаараа амь ордог гишүүд үү дээ” гарчигтай нийтлэл. 2021 оны 10 сарын 7 өдөр сайтаас шууд татав.
3. <https://www.dazeddigital.com/artsandculture/article/24687/1/what-does-the-stinky-poop-emoji-really-mean>
4. https://www.macmillandictionary.com/dictionary/british/poop_

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх тэдний нийгэм, улс төрийн оролцоонд нөлөөлөх нь буюу Womenomics ойлголтын тухайд

Д.УРТНАСАН

МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй

Нийгмийн ухааны салбарт дэлхий нийтэд шинэ тутамд хөгжиж буй үзэл санаа, ойлголтын агуулгыг судлах, олон улсын сайн туршлагыг харьцуулах, өөрийн улс орны онцлогтой уялдуулан дүн шинжилгээ хийж тодорхой дүгнэлт, зөвлөмж гаргах нь эрдэм шинжилгээ судалгааны ач холбогдлоос гадна үүнийг олон нийтэд түгээснээр нийгэмд тулгарч буй олон асуудлын шийдлийг олоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх түлхэц болдог. Иймд тус нийтлэлд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх, тэдний нийгэм, улс төрийн оролцоонд чухал байр суурийг эзэлдэг талаар чухалчлан үздэг “womenomics” ойлголтын талаар өгүүлэх бөгөөд онолын үндэслэл, ойлголтын зөрүүтэй байдал болон хөгжил, зарим улсын туршлага, Монгол улсын нөхцөл байдал зэрэг агуулгын хүрээнд дэлгэрүүлснээр цаашдын олон судалгааны ажилд тодорхой хувь нэмэр оруулна хэмээн таамаглаж байна.

Удиртгал

НҮБ-ийн эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн гүйцэтгэл захирал Phumzile Mlambo-Ngcuka 2014 оны 09 сарын 13-нд Токио хотноо болсон Дэлхийн Эмэгтэйчүүдийн Ассамблейн нээлтийн үеэр хэлсэн үгэндээ “ Норвегийн амьдралын өндөр түвшин нь зөвхөн газрын тосондоо бус засгийн газраас хэрэгжүүлж буй хүйсийн тэгш байдлын талаар гүнзгий нэвтэрсэн бодлого, дадал зуршлаас үүдэлтэй. Хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд асрахад үзүүлэх төрийн дэмжлэг, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эцэг эхийн үүрэг, хариуцлагын хуваарь зэрэг нь хэдийгээр энгийн зүйл мэт боловч бидний өнөөдрийн түвшинд ирэхэд гол удирдлага болсон.”¹ хэмээн онцолжээ. Үүнээс харахад жендэрийн тэгш байдалтай холбоотой олон асуудалд зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийн талаар бус эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадамж, улс орны хөгжлийн чухал оролцогч талаас нь тодорхойлох хандлага чухал болж буйг харж болохоор байна.

Womenomics хэмээх нэр томъёо нь women /эмэгтэйчүүд/ болон economics /эдийн засаг/ гэсэн үгнүүдийн нийлбэр бөгөөд “эмэгтэйчүүдийн эдийн засгийн ахиц дэвшил нь улс орны эдийн засгийг бүхэлд нь сайжруулах болно”² гэсэн санаан дээр үндэслэдэг.

¹ https://www.unwomen.org/en/news/stories/2014/9/womenomics-in-japan-ed-speech?fbclid=IwAR1SC2WQ9TixMorKIUViKF7WVUqVXDViM_0qa-SUC-DwEWSKbtO-C3CkdF4

² https://www.ny.us.emb-japan.go.jp/en/c/2015/04-Apr/japaninfo-2015-04/03.html?fbclid=IwAR21Qulhjwcf4CH3Q0_w9wsJ_1A8oG4-rx8GwpVYNjhV8RG5Sx-pFdBDeJZc

Үндсэн хэсэг

Японы Ерөнхий сайд асан Шинзо Абе бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад Японы эдийн засагт эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага байгааг хүлээн зөвшөөрч үүний алдагдлыг бууруулах нь түүний засгийн газрын үндсэн чиглэл хэмээн зарлан “Япон улс илүү олон эмэгтэйчүүдийг ажиллуулах замаар эдийн засгийг дээшлүүлэх, ур чадвар, авьяас чадвар, хүсэл тэмүүлэлтэй нь нийцсэн ажлын байр, цалин хөлсөөр хангах ёстой”³ гэсэн “**womenomics**”-ын үндсэн үзэл санааг дэвшүүлсэн байна. Тус үзэл санаа боловсруулагдахад нийгэм, эдийн засгийн хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байна.

- Өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад эмэгтэйчүүд хагас цагаар ажиллах нь эрэгтэйчүүдээс бага цалин авах нөхцөлийг бүрдүүлдэг. 2013 оноос Японд тус үзэл санаанд суурилсан бодлого хэрэгжиж эхлэх үед “бүтэн цагаар ажил эрхэлдэг болон идэвхтэй ажил хайгчдын 85 хувь нь эрэгтэйчүүд байсан бол хагас цагаар болон тогтмол бус ажил эрхлэгчдийн 63 хувь нь эмэгтэйчүүд байжээ.”⁴
- Өндөр наслалт ба бага төрөлт нь хөдөлмөрийн насны ажиллах хүчний хомсдол оруулах болсон. Тухайлбал, Японы хүн амын дундаж наслалт “2013 онд 83,32, 2017 онд 84,21, 2021 онд 84,79”⁵ байна. Бага төрөлтийн хувьд “ихэнх орны хүн амын төрөлт нь нэг эмэгтэйд ойролцоогоор 2,1 хүүхэд байгаа бол Японд 1,4 байдаг нь 127 сая хүн ам нь 2050 он гэхэд 100 сая болж буурах тооцоо судалгаа байна.”⁶
- Гаднын ажиллах хүчний хомсдол. Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний хомсдол бий болбол улс орнууд гадаад ажиллах хүчийг татан авдаг. Гэтэл Япон улс соёлын асуудалд мэдрэг тул гадаад иргэд, цагаачлал бага байдаг. Тухайлбал, “нийт хүн амын дунд эзлэх байнга оршин суудаг гаднын иргэд 2013 онд 1,5 хувь, 2021 онд 2,02 хувийг эзэлж байна.”⁷

“2021 оны байдлаар дэлхий дээр 3,970,238,390 эрчүүд байгаа нь дэлхийн хүн амын 50.42 хувийг эзэлж байна. Харин 3.904.727.342 эмэгтэйчүүд байгаа нь дэлхийн хүн амын 49.58 хувийг эзэлдэг. Дэлхийн ихэнх улс орон, бүс нутгуудад эрэгтэйчүүдээс илүү олон эмэгтэйчүүд байдаг бөгөөд дэлхийн хамгийн их хүн амтай Хятад, Энэтхэг хоёр улсад эрчүүд илүү өндөр хувьтай байгаа нь эрэгтэй эмэгтэй хүн амын хүйсийн харьцаанд ийнхүү нөлөөлж байна.”⁸ АНУ-ын Тагнуулын төв газраас эрхлэн гаргадаг “Дэлхийн баримт мэдээллийн ном 2019-2021”-д дэлхийн хүн амын хүйсийн харьцааг харуулсан газрын зургийг дараах байдлаар дүрсэлсэн байна.

3 https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan?fbclid=IwAR0Riw3tbvK4B6VgbK1iW8dIj_dmv0TCW5GUuGWU3zO9VDuE_nlcLHR4Kjw

4 Мөн тэнд


5 https://www.macrotrends.net/countries/JPN/japan/life-expectancy?fbclid=IwAR39_wDaEs8ZjPrfdFu6PA2GEnFD3hvSHmG24sBqmYmQPEfeBwrr2ksQRq0

6 https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan?fbclid=IwAR0Riw3tbvK4B6VgbK1iW8dIj_dmv0TCW5GUuGWU3zO9VDuE_nlcLHR4Kjw

7 <https://www.japantimes.co.jp/news/2013/08/29/national/foreigners-make-up-1-5-of-populace/?fbclid=IwAR2nbd0RXvEuT1ibaAqspV4xdw-d1zUnlWNYIe-MiEOonJbr14NjLAjvcgVI>

8 <https://statisticstimes.com/demographics/world-sex-ratio.php>

Зураг 1: Дэлхийн хүн амын хүйсийн харьцаа



Эх сурвалж: The CIA World Factbook 2019-2020 By Central Intelligence Agency

2020 оны Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр⁹ Монгол улсын нийт хүн амын тоо 3,357,542 түүний 1,648,979 буюу 49,11 хувийг эрэгтэйчүүд 1,708,563 буюу 50,89 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Ийнхүү эмэгтэйчүүд нийт хүн амын тал хувийг бүрдүүлдэг учир :


- ✓ Эдийн засагт эмэгтэйчүүдийн оруулж буй нөлөө, хувь нэмэр, чухал бөгөөд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бол татварын хүчирхэг хэрэгсэл болдог.
- ✓ Улс орны бодлого, шийдвэр мөн тэдэнд чиглэсэн, оролцоог нь хангасан байх учиртай.
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн чадварлаг ажиллах хүч болох боломжтой.

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадамжгүй байдал өрх, гэр бүлийн түвшинд үр хүүхдийн аюулгүй байдал, амьдралын баталгааг хангаж чадахгүйд хүрдэг нь нийгмийн олон асуудлыг авчирдаг бол шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог бууруулах нэг үндсэн нөхцөл болдог. Иймд Womenomics-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд юун түрүүнд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоог бууруулдаг шалтгаануудыг тодруулах ёстой.

- Боловсролын хүртээмж ба мэргэжил сонголт

⁹ https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect=_1&Sex_select_all=0&SexSingleSelect=_1_11_12&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table


Зураг 2: Их, дээд сургууль, коллежийн нийт төгсөгчид, мянган хүн, хүйсээр, 2001-2012 он



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тайланд, 2019 он

Үндэсний Статистикийн Хорооны тайланд¹⁰ дурдсанаар Монгол улсад 2001-2002 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийг нийт 177,000 оюутан төгссөнөөс 118,000 мянга буюу 66,6 хувь нь эмэгтэйчүүд, 59,000 мянга буюу 33,3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байсан бол 2017-2018 хичээлийн жилд 292,000 оюутан төгссөнөөс 175,000 буюу 59,9 хувь нь эмэгтэйчүүд, 117,000 буюу 40,1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байжээ.

Зураг 3: Их, дээд сургууль, коллежийн нийт төгсөгчид, хүйсээр, салбараар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тайлан, 2019 он


¹⁰ Үндэсний Статистикийн Хороо. (2019). Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ. Улаанбаатар., хууд. 15

Эмэгтэйчүүдийн хамгийн их суралцдаг салбар нь анагаах ухаан, боловсрол, нийгмийн ухааны салбарууд байхад эрэгтэйчүүдийн хамгийн их суралцдаг салбар нь үйлчилгээ, техник, технологи, хөдөө аж ахуйн салбарууд байна. Хэдийгээр эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмших түвшин эрэгтэйчүүдийнхээс 19,8 нэгжээр өндөр байгаа хэдий ч суралцах чиглэлийн ялгаа нь “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрхлэх ажлын ялгаанд нөлөөлж, улмаар шинжлэх, ухаан, технологи, инженерчлэл, математикийн чиглэлд шинээр бий болж буй ажлын боломжийг хүртэх магадлал эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдээс бага байна.”¹¹ Тиймд боловсролын хүртээмжийн асуудлаас гадна шинэ тутамд хөгжиж буй ажлын байранд тохирох мэргэжил сонголтын талаарх охид эмэгтэйчүүдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах нь чухал байна.

- Хөдөлмөр эрхлэлт ба цалин хөлс

“Ажил эрхлэлтэд жендэрт суурилсан ялгавартай байдлыг бий болгох нь жендэрийн зөрүүтэй байдлыг улам гүнзгийрүүлж, харилцаа, эрх мэдэл, ур чадвар, орлого бүрдүүлэх, ажил эрхлэх боломж зэрэгт тэгш бус байдлыг үүсгэнэ.”¹²

Зураг 4: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, 2015-2020 он



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан¹³

2015 онд эрэгтэй хөдөлмөр эрхлэлтийн түвшин 62,5 хувь, эмэгтэй хөдөлмөр эрхлэлтийн түвшин 51,7 хувь буюу 10,9 нэгжээр бага байсан бол 2020 онд эмэгтэй хөдөлмөр эрхлэлтийн түвшин 13,3 нэгжээр эрэгтэй хөдөлмөр эрхлэлтийн түвшнээс бага байна.

11 Ариунзаяа, А., & Мөнхмандах, М. (2019). Монголын эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй. Улаанбаатар: Монгол дахь Фридрих-Эбертийн-Сан, хууд. 1

12 IRIM судалгааны хүрээлэнгийн судалгааны баг, & Швейцарийн Хөгжлийн Агентлаг. (2014). Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа. Улаанбаатар, хууд. 43

13 https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_006V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T2_T3_T1&Indicator_select_all=0&IndicatorSingleSelect=_5&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018_2017_2016_2015&viewtype=-columnchart

Зураг 5: Монгол улсын нийт ажиллагчдын тоо болон цалингийн мэдээлэл, 2020 он.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Хүйс	Ажиллагчдын тоо	Сарын дундаж цалингийн хэмжээ
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Эрэгтэй	154,190	962.4
	Эмэгтэй	122,266	932.5
Уул уурхай, олборлолт	Эрэгтэй	42,545	2,855.8
	Эмэгтэй	9,028	2,949.7
Боловсруулах үйлдвэрлэл	Эрэгтэй	45,096	1,275.3
	Эмэгтэй	44,629	1,031.7
Цахилгаан, хий, агааржуулалт	Эрэгтэй	9,467	1,572.1
	Эмэгтэй	4,910	1,524.9
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Эрэгтэй	3,641	1,003.4
	Эмэгтэй	4,672	936.1
Барилга	Эрэгтэй	65,964	1,252.8
	Эмэгтэй	11,320	1,332.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	Эрэгтэй	83,972	1,079
	Эмэгтэй	82,624	918.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Эрэгтэй	52,574	1,175.4
	Эмэгтэй	13,967	1,291.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Эрэгтэй	6,601	760.7
	Эмэгтэй	23,392	712.1
Мэдээлэл, холбоо	Эрэгтэй	10,108	1,308.4
	Эмэгтэй	8,719	1,075.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Эрэгтэй	10,239	1,735.4
	Эмэгтэй	19,115	1,291.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Эрэгтэй	1,177	1,520.3
	Эмэгтэй	2,233	1,174.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Эрэгтэй	6,972	1,689.8
	Эмэгтэй	4,640	1,608
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Эрэгтэй	10,870	1,083.2
	Эмэгтэй	7,179	1,086.6
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Эрэгтэй	44,670	1,147
	Эмэгтэй	38,699	1,014.6
Боловсрол	Эрэгтэй	29,725	1,040.3
	Эмэгтэй	81,009	1,004.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Эрэгтэй	12,795	1,133.9
	Эмэгтэй	47,397	1,102.4
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	Эрэгтэй	5,426	849.3
	Эмэгтэй	5,386	839.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Эрэгтэй	12,314	1,096.1
	Эмэгтэй	17,439	944.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	Эрэгтэй	1,586	933.6
	Эмэгтэй	1,707	882.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Эрэгтэй	1,867	1,831.9
	Эмэгтэй	775	1,816.6

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг нэгтгэв.

Дээрх мэдээллээс харахад сарын дундаж цалингийн хэмжээ хамгийн өндөр уул уурхай олборлолтын салбарт эрэгтэй ажиллагчид 42,545 байхад эмэгтэй ажиллагчид 9,028 буюу тав дахин бага байна. Харин сарын дундаж цалингийн хэмжээ хамгийн бага зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт эрэгтэй ажиллагчид 6,601, эмэгтэй ажиллагчид 23,392 буюу 3,5 дахин их байна. Тус нөхцөл байдал нь 2014 онд хийгдэж байсан Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаанд “Монгол улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах албан ёсны стратегид эрэгтэйчүүдийн түлхүү ажилладаг салбарууд багтсан бөгөөд эдгээр салбарууд нь эдийн засгийн үр ашиг илүүтэй салбарууд болох хандлагатай байгаа юм. Үүнд: аж үйлдвэр, барилга, тээвэр, байгалийн нөөц, олборлох салбар, эрчим хүч гэх мэт салбарууд багтана. Харин үүний эсрэгээр эмэгтэйчүүд түлхүү ажилладаг салбарууд нь ихэнхтэй улсын төсвөөс санхүүждэг, хамгийн бага цалинтай ажил мэргэжлүүд байдаг ажээ. Эмэгтэй ажилтнууд эдийн засгийн хувьд харьцангуй тогтвортой ч цалин, хөлсний хэмжээ доогуур байдаг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамж, соёл урлаг зэрэг салбаруудад түлхүү ажиллаж байна.”¹⁴ гэсэн дүгнэлтээс зарчмын хувьд өөрчлөгдөөгүй байна.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн орлого, гэр бүлдээ зарцуулах цаг хугацааны зөрүүтэй байдлаас үүдэн эмэгтэйчүүд түр болон удаан хугацаагаар ажлын байраа орхидог. Зарим тохиолдолд нийгмийн хамгааллын болон эдийн засгийн бодлогын зохицуулалтууд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж байдаг. Тухайлбал, Япон улсын хувьд эрэгтэйчүүдийн 52 хувь, эмэгтэйчүүдийн 59 хувь нь дээд боловсролтой боловч ажил эрхлэлт болон орлогын хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага үзүүлэлттэй байдаг. Энэ нь эдийн засгийн бодлого, нийгмийн хамгааллын бодлого, соёл болон нийгмийн хэм хэмжээ зэрэг хүчин зүйлстэй холбоотой байдаг. “Ихэнх Япон гэр бүлд нөхрүүд нь гол орлогын эх үүсвэр болдог бөгөөд Японы татварын системд эхнэр нь жилд 1,03 сая иенээс бага орлоготой тохиолдолд нөхрийнх нь төлөх татварын хэмжээг бууруулдаг.

Зарим шинжээчдийн үзэж буйгаар олон эмэгтэйчүүдийг ажлын амбицаа бууруулж, бага цалинтай, хагас цагийн ажил эрхлэх нөхцөлийг тус хуулийн зохицуулалт бүрдүүлдэг гэж үзжээ.”¹⁵ Иймд төрийн бодлого шийдвэр жендэрт суурилсан ялгавартай байдлыг бий болгох нөхцөлөөс сэргийлсэн, нийгмийн гишүүдийн олон талын эрх ашгийг хангасан, судалгаа шинжилгээтэй, нарийн зохион байгуулалтай байх учиртай.

- Гэр бүл төлөвлөлт ба үүрэг хариуцлага

Ихэнх эмэгтэйчүүдийн хувьд ажил, карьер болон гэр бүлдээ хүлээх үүрэг хариуцлагыг хамтад нь зохицуулахад бэрхшээл, хүндрэлүүд тохиолддог. Үүнийг Double standard буюу “давхар ачаа”¹⁶ хэмээн тодорхойлох бөгөөд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо болон ажил мэргэжилдээ тушаал ахих, тогтвор суурьшилтай ажиллах зэрэгт хүндрэл учруулдаг байна. Тухайлбал, “Япон эмэгтэйчүүдийн 60 орчим хувь нь анхны хүүхдээ төрүүлснийхээ дараа ажлаа орхидог”¹⁷ бол “70 орчим хувь нь эргээд 10 орчим жилийн дараа ажилдаа ордог”¹⁸ ажээ.

14 IRIM судалгааны хүрээлэнгийн судалгааны баг, & Швейцарийн Хөгжлийн Агентлаг. (2014). Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа. Улаанбаатар, хуудсд. 70-71

15 https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan/?fbclid=IwAR0YKljB4Sg3WptGtcQY-RQ_YJwDFXbmROTMaFybZXXN78YM-iGHaHZco-7Y

16 Бямбахан, Л. (2020). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс. Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (хуудсд. 25-61).-Д Улаанбаатар, хууд. 50

17 https://www.ny.us.emb-japan.go.jp/en/c/2015/04-Apr/japaninfo-2015-04/03.html?fbclid=IwAR3ElcMxl5wW1g8Wtv-6gmLRXyCDurFtrq0oOm__9g-5TRk5s17bFKiObf0w

18 https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan/?fbclid=IwAR0Riw3tbvK4B6VgbK1iW8dlj_dmv0TCW5GUuGWU3zO9VDuE_nlcLHR4Kjw

Монгол Улсын Хүн ам, өрхийн мэдээллийн санд 2020 оны байдлаар анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэй 29, эмэгтэй 26 байна. Мөн гэрлэсэн хүн амын насны бүлэг болон хүйсээр авч үзвэл 16-24 насанд эрэгтэйчүүдийн 5,2 хувь, эмэгтэйчүүдийн 10,7 хувь, 25-34 насанд эрэгтэйчүүдийн 55,7 хувь, эмэгтэйчүүдийн 65,1 хувь, 35-44 насанд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 82,9 хувь нь гэрлэсэн байна. Тус статистикаас харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс насны хувьд илүү эрт гэрлэдэг байна.

Судлаач Б.Бүжинтуул 12830 эмэгтэйчүүдийг хамруулсан түүвэр судалгаанд 75.8 хувь буюу 9720 эмэгтэй дор хаяж нэг хүүхэд төрүүлсэн бөгөөд тэдгээр эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн насны тархалтыг авч үзэхэд “Хүүхэд төрүүлсэн 9720 эмэгтэйчүүдээс ойролцоогоор 23 хувь нь 20 нас хүрэхээсээ өмнө, 59 хувь орчим нь 20-24 насандаа, 15 нь 25-29 настайдаа, үлдсэн 3.3 хувь нь 30 нас хүрсний дараа анхны хүүхдээ төрүүлжээ. Эрт буюу 15 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн цөөн тохиолдлыг (0.1) эс тооцвол, анх төрөх үеийн нас хамгийн багадаа 15, хамгийн ихдээ 42, дундаж нас 22.4 байв.”¹⁹ Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх идэвхтэй нас бөгөөд энэ үед эмэгтэйчүүд илүүтэйгээр хүүхдээ асрах ажилд цаг зарцуулдаг.

Судлаач Б.Алтанцэцэг “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн эрүүл мэнд хөгжилд улсын цэцэрлэгийн үзүүлэх нөлөө” судалгааны танилцуулгад “Хүүхэд төрүүлэх, асрах нь эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг бууруулдаг гол хүчин зүйл. Тухайлбал, 25-39 насны хүн амын дунд ажиллах хүчний оролцооны хүйсийн ялгаа хамгийн их байна. Хөдөлмөрийн насны бүх эмэгтэйчүүдийн хувьд хүүхдийн асаргаа нь тэтгэвэрт гарсан болон суралцдаг гэсэн шалтгаануудын дараагаар ажиллах хүчинд оролцохгүй байх гурав дахь гол шалтгаан болдог.

Харин хоёр хүртэлх настай хүүхэдтэй ээжүүдийн ажиллах хүчинд оролцохгүй байгаа хамгийн гол шалтгаан нь хүүхдийн асаргаа юм.”²⁰ хэмээжээ.

- Соёл ба нийгмийн хэм хэмжээ

Дорнын соёлтой улс орнуудын хувьд эмэгтэйчүүд хань нөхрөө дэмжих, үр хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, ахмад настнаа асрах, өрх гэрийн ажлаа цалгардуулахгүй байх ёстой гэсэн нийгмийн хүлээлт их байдаг. Түүнчлэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд байгууллага, хамт олны соёл нөлөөлж байдгийг дурдах нь зүйтэй. Тухайлбал, Японд эмэгтэй ажил эрхлэлтийг дэмжихэд тулгардаг хамгийн том саад нь нийгэм өөрөө байдаг хэмээн үзэж байгаа бөгөөд “ажлын байранд тушаал дэвшихийн тулд удаан хугацаанд тогтвортой ажиллахын зэрэгцээ илүү цагаар ажиллах, ажлын дараах хамт олны уулзалтад оролцох явдал Японы албан байгууллагуудын соёл болдог. Энэ нь хүүхэдтэй эмэгтэйчүүдэд бүтэн цагаар ажиллах, тогтвортой ажиллахад бэрхшээл болдог.”²¹

Эмэгтэйчүүдийн улс төр болон шийдвэр гаргах түвшний оролцоонд тэдний хөдөлмөрийн оролцоог бууруулдаг дээрх шалтгаанууд суурь шинжтэйгээр нөлөөлөх бөгөөд эмэгтэйчүүд илүү бие даасан, хүчирхэг, өө сэвгүй имижийг бүрдүүлж байж олон нийтэд хүлээн зөвшөөрөгддөг байна. Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хийгдсэн “Монгол дахь жендэрийн эрх тэгш байдал”²² судалгааны тайлан, Жендэрийн Үндэсний

https://www.ny.us.emb-japan.go.jp/en/c/2015/04-Apr/japaninfo-2015-04/03.html?fbclid=IwAR3ElcMxi5wW1g8Wtv-6gmLRXyCDurFtrq0oOm__9g-5TRk5s17bFKiObf0w

19 Бүжинтуул, Б. (2018). Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн нас, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс. Монголын хүн амын сэтгүүл, Дугаар 28, хууд. 11


20 <https://ikon.mn/n/1z9w?fbclid=IwAR3D6TSJ2fgPAXZkgFvKqPhpOircOr9Vimv8Ug--IzaXRbQFalkCbD1t34>

21 https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan?fbclid=IwAR0Riw3tbvK4B6VgbK1iW8dIj_dmv0TCW5GUuGWU3zO9VDuE_nlcLHR4Kjw

22 Цолмон, Б., & Долгион, А. (2014). Монгол Монгол дахь Жендэрийн эрх тэгш байдал. Улаанбаатар: Швейцарийн Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны

Хороо, НҮБХХ: “Улс төрийн шийдвэр гаргалт дахь эмэгтэйчүүдийн оролцоо”²³ судалгааны тайланд тус тус эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо бага байх, улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл ороход бэрхшээл ихтэй байгаа нь эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих насны бүтэц, нэр хүнд, олонд танигдсан байдал харьяалагддаг намын нэр хүнд, боловсрол, үзэл бодол, хувийн зан байдал, санхүүгийн байдал, эмэгтэйчүүдийг үл дэмжих хандлага, нийгэм, соёлын тогтсон ойлголтуудтай холбоотой хэмээн тэмдэглэсэн байна.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн оролцоо, олонд танигдах байдалд хамт олон, харьяалагдаж буй бүлгийн дэмжлэг чухал байдаг. ХБНГУ дахь улс төрийн салбарт ажилладаг эмэгтэйчүүд зарим бэрхшээлийн талаар дурдахдаа “энэ салбарт ажилладаг эрчүүдийн ихэнх нь өөрийн карьер, байр суурийг бэхжүүлэхийн тулд ойр дотно, цааш хамтарч ажиллахад илүү их боломжийг бий болгож чадах хүмүүсийг хайдаг бөгөөд энэ нь ихэнхдээ эрчүүд байдаг хэмээжээ.”²⁴ Иймд эмэгтэйчүүдийн нийгэм, улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах түвшний оролцоог хангахын тулд нэн түрүүнд эдийн засгийн чадамжийг сайжруулах шаардлагатай байна.



Эх сурвалж: <https://florinroebig.com/workplace-discrimination-women/?fbclid=IwAR3pohkr-logtWNSXN6SYZM4MxNNYx0gPxGgamONAK-n-QpO1wq0gB69w>

Эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхжуулахад бүтээмжтэй хөрөнгө оруулалт, дэд бүтэц, зах зээл, шинэ техник технологи нэвтрүүлэх, тухайлбал, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд дэд бүтэц, нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмж, эмэгтэйчүүдийн ачааллыг багасгах, эрүүл мэнд, боловсролыг сайжруулах, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг дэмжсэн нийгмийн хамгааллын бодлого чухал. Хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмж нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт болон орлогын хэмжээнд хэрхэн нөлөөлж буйг “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн эрүүл мэнд хөгжилд улсын цэцэрлэгийн үзүүлэх нөлөө” судалгаанд “улсын цэцэрлэгийн үйлчилгээ нь эцэг эхийн ажил эрхлэлт болон цалинд богино хугацаанд эерэг нөлөөтэй байна гэж тус судалгааны багийнхан үзжээ. Тухайлбал, ээжийн тухайн үеийн ажил эрхлэлтийг 8.3 хувиар, харин аавынхыг 2.9 хувиар өсгөдөг, ээжийн тухайн үеийн болон өмнөх нэг жилийн хугацааны ажил эрхлэлтийг 10.5 хувиар, харин аавынхыг 1.8 хувиар өсгөдөг, ээж, аавын цагийн цалинг 6 хувиар өсгөдөг”²⁵ хэмээн тогтоожээ.

хүрээлэн

23 Жендэрийн Үндэсний Хороо, & НҮБХХ. (2012). Улс төрийн шийдвэр гаргалт дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл. Улаанбаатар

24 https://www.dw.com/en/in-german-politics-women-still-have-a-long-way-to-go/a-46226146?fbclid=IwARIT_cuZhMQsHzTY3PDxrg_wZY4JAWD-B32UNTQh7toWQ5U95Y2R1vJw3mhQ

25 <https://ikon.mn/n/1z9w?fbclid=IwAR3D6TSJ2fgPAXZkgFvKqPhpOurcOr9Vtmv8Ug--IzaXRbQFalkCbD1t34>

Түүнчлэн ажил олгогчдын жендэрийн мэдрэмжтэй ажил төлөвлөлтийн стратегийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хэлэлцүүлэг, сургалтыг тогтмол зохион байгуулснаар байгууллагын соёлд нөлөөлж болно. Их, дээд сургууль болон бүх шатны боловсролын байгууллагад нийгэм, улс төр, эдийн засгийн хичээлийн хөтөлбөрт womenomics хичээлийг тусгаж энэ талаарх мэдлэг мэдээллийг түгээх боломжтой. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны үндсэн дээр эмэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл хүргэх байнгын, харилцаа холбоо тогтооход хялбар сувгийг бий болгох хэрэгтэй байна. Тухайлбал, ХБНГУ-д эмэгтэйчүүдийн боловсрол, мэргэжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлдэг, зөвлөгөө өгдөг олон төвүүд ажилладаг бөгөөд тэднээс онцолбол Ажил, мэргэжил боловсрол, ажил эрхлэлтийн талаарх асуултын лавлах /<https://www.frauen-berufsperspektive.de/>/ утас ажлын өдрүүдээр байнгын /Hotline/, ямар нэг ярианы үнэ тарифгүй ажилладаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэх, улс төрийн оролцоог тогтвортой байлгахын тулд олон нийтийн асуудал, орон нутгийн байгууллагуудын шийдвэр гаргахад оролцох, дуу хоолойгоо хүргэхэд нь туслах хөгжлийн бичил бүлэг, холбоог хөгжүүлэх нь үр дүнтэй байдаг. Тэгвэл эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлдэг нэг чухал хүчин зүйл нь намын санхүүжилтийн асуудал байдаг. Финландын улсын төсөвт улс төрийн намуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тогтмол төсөв тусгадаг бөгөөд “Намуудад төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийг Парламентад эзлэх суудлын тоонд нь үндэслэн олгодог. Холбогдох тогтоол заасанчлан санхүүгийн дэмжлэг авсан улс төрийн нам тэтгэлгийн 8 хувийг эмэгтэйчүүдийн санаачилга, үйл ажиллагааг санхүүжүүлэх, намын орон нутгийн байгууллагад олгох ёстой бөгөөд 8 хувийг олон улсын үйл ажиллагаанд зарцуулахыг мөн шаарддаг ажээ.”²⁶ Эмэгтэйчүүд өөрсдийгөө нийгэмд таниулах санал, санаачилга, үйл ажиллагаа явуулахад намын санхүүгийн дэмжлэг авснаар сонгуульд эмэгтэйчүүдийн хувь оролцоо квотгүй өсөх боломж бий болдог. Квот болон намын санхүүжилтийн талаарх акцуудын үр дүнд “парламентын гишүүдийн эзлэх хувь 1962-1991 онд 13,5-38,5 хувь, 2007 онд болсон Парламентын сонгуулиар нийт депутатын 41,5 хувьд хүрсэн. 2007 онд хотын захиргаанд сонгогдсон хүмүүсийн 37 хувийг эмэгтэйчүүд эзэлж, тэд нийт сонгогчдын 42 хувийн дэмжлэгийг хүлээсэн байна.”²⁷ Мөн олон орнууд нэр дэвшигчдэд адил боломжийг бий болгох үүднээс сонгуулийн сурталчилгаа болон бусад зардлыг бууруулах, сонгуулийн компани ажилд өгөх хандивын хэмжээг хязгаарласан хуулийн зохицуулалтууд хийдэг байна.

Дүгнэлт

2014 оны 09 сарын 13-нд Токио хотноо болсон Дэлхийн Эмэгтэйчүүдийн Ассамблейд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон хэлсэн үгэндээ “ Эмэгтэйчүүд, охидын эрхийг хассанаар дэлхий ертөнц тогтвортой ахиц дэвшилд хүрч чадахгүй. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхэд нийгэм, улс үндэстэн, дэлхийн эдийн засгийн үзүүлэлтийг үнэхээр нэмэгдүүлдэг.”²⁸ хэмээжээ.

Улс орнуудад жендэрийн тэгш байдалтай холбоотой олон асуудалд зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийн талаар бус эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадамж, улс орны хөгжлийн чухал оролцогч талаас нь тодорхойлох хандлага чухал болж байна.

²⁶ Балтын тэнгис Төв Сан. (2012). Финландын нийгмийн 100 шинэчлэл. Хакапайно, Хельсинки: «Мөнхийн үсэг» ХХК, хууд. 176

²⁷ Балтын тэнгис Төв Сан. (2012). Финландын нийгмийн 100 шинэчлэл. Хакапайно, Хельсинки: «Мөнхийн үсэг» ХХК, хууд. 26

²⁸ https://www.ny.us.emb-japan.go.jp/en/c/2015/04-Apr/japaninfo-2015-04/03.html?fbclid=IwAR0ymS-niNg3k0LkottzBNG5t5vjqJ_IX3YBeoei54VhF2IwkAh5D-nxyG_SY

Үүний нэг чухал үзэл баримтлал нь “womenomics” бөгөөд илүү олон эмэгтэйчүүдийг ажиллуулах замаар эдийн засгийг дээшлүүлэх, ур чадвар, авьяас чадвар, хүсэл тэмүүлэлтэй нь нийцсэн ажлын байр, цалин хөлсөөр хангах ёстой гэсэн санааг дэвшүүлсэн байна. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадамжгүй байдал өрх, гэр бүлийн түвшинд үр хүүхдийн аюулгүй байдал, амьдралын баталгааг хангаж чадахгүйд хүрдэг нь нийгмийн олон асуудлыг авчирдаг бол шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог бууруулах нэг үндсэн нөхцөл болдог. Тиймээс эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоог бууруулдаг шалтгаануудыг тодруулах, түүнийг багасгах арга замыг эрэлхийлэх, энэ талаарх хувь хүн, хамт олон, улс төр, олон нийтийн байгууллагуудын ойлголт мэдлэг, дэмжлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй үйл ажиллагаа чухал юм.

Номзүй

- IRIM судалгааны хүрээлэнгийн судалгааны баг, & Швейцарийн Хөгжлийн Агентлаг. (2014). *Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа*. Улаанбаатар.
- Ариунзаяа, А., & Мөнхмандах, М. (2019). *Монголын эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй*. Улаанбаатар: Монгол дахь Фридрих-Эбертийн-Сан.
- Балтын тэнгис Төв Сан. (2012). *Филандын нийгмийн 100 шинэчлэл*. Хакапайно, Хельсинки: «Мөнхийн үсэг» ХХК.
- Бүжинтуул, Б. (2018). Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн нас, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс. *Монголын хүн амын сэтгүүл, Дугаар 28*.
- Бямбаханд, Л. (2020). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс. *Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (хуудсд. 25-61)*.-Д Улаанбаатар.
- Жендэрийн Үндэсний Хороо, & НҮБХХ. (2012). *Улс төрийн шийдвэр гаргалт дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл*. Улаанбаатар.
- Үндэсний Статистикийн Хороо. (2019). *Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ*. Улаанбаатар.
- Цолмон, Б., & Долгион, А. (2014). *Монгол дахь Жендэрийн эрх тэгш байдал*. Улаанбаатар: Швейцарийн Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн.

Цахим эх сурвалж

- https://www.unwomen.org/en/news/stories/2014/9/womenomics-in-japan-ed-speech?fbclid=IwAR1SC2WQ9TiXMorKIUViKFn7WVUqVXDViM_0qa-SUcDwEWSKbtO-C3CkdF4
- https://www.ny.us.emb-japan.go.jp/en/c/2015/04-Apr/japaninfo-2015-04/03.html?fbclid=IwAR21Qulhjwcf4CH3Q0_w9wsj_IA8oG4-rx8GwpVVNjhV8RG5SxpFdBDeJZc
- https://asiapacificcurriculum.ca/learning-module/womenomics-japan?fbclid=IwAR0Riw3t-bvK4B6VgbK1iW8dlj_dmv0TCW5GUuGWU3zO9VDuE_nIcLHR4Kjw

- https://www.macrotrends.net/countries/JPN/japan/life-expectancy?fbclid=IwAR39_wDaEs8ZjPrfdFu6PA2GEnFD3hvSHmG24sBqmYmQPEfeBwrr2ksQRq0
- <https://statisticstimes.com/demographics/world-sex-ratio.php>
- https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect=_1&Sex_select_all=0&SexSingleSelect=_1_11_12&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table
- <https://ikon.mn/n/1z9w?fbclid=IwAR3D6TSJ2fgPAXZkgFwKqPhpOurcOr9Vtmv8Ug--lZaXR-bQFalkCbD1t34>
- https://www.dw.com/en/in-german-politics-women-still-have-a-long-way-to-go/a-46226146?fbclid=IwAR1T_cuZhMQsHzTY3PDxrg_wZY4JAWDB32UNTQh7toWQ5U95Y2R1v-Jw3mhQ

Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг үнэлэх нь

Г.ЦЭЛМЭГ (МВА)

Хураангуй

Монгол эмэгтэйчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж барашгүй. Монгол эмэгтэйчүүд гэр бүл, үр хүүхдээ асарч хамгаалахаас эхлүүлээд ажил хөдөлмөр эрхлэх зэргээр улс орныхоо эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг.

Энэхүү судалгаагаараа Монгол эмэгтэйчүүдийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралд оруулж буй олон сайхан хувь нэмрүүдээс багахан хэсгийг нь онцолж, үнэлэхийг оролдсон болно. Тухайлбал: Ажил хөдөлмөр эрхэлж буй олон мянган хөдөлмөрч, бүтээлч эмэгтэйчүүдийнхээ Монгол улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд оруулж буй хувь нэмрийг Соловын урт хугацааны эдийн засгийн өсөлтийн загвар ашиглан үнэлсэн болно.

Судалгааны хүлээгдэж буй үр дүнг эмэгтэйчүүдийнхээ маань эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр эрчүүдийнхээс дутахгүй, бараг илүү байх болов уу гэж төсөөлж байсан.

Судалгаагаар дараах үр дүнгүүд гарлаа:

1. Эмэгтэйчүүд, эрчүүдийг эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг жендэрийн нь ялгаж үнэлэх нь үр дүнгүй байна.
2. Эмэгтэйчүүд, эрчүүд маань хамтдаа нэгдмэл байдлаар эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг болохыг регрессийн шинжилгээний үр дүн харууллаа.
3. Бүсгүйчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр эрчүүдтэй ижил, тэнцүү байна.
4. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд капиталын хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Улс эх орны хөгжилд эмэгтэйчүүд, эрчүүд маань нэгдмэл байдлаар өөрөөр хэлбэл нэгэн цул (гэр бүл) болж тэнцүү хэмжээтэй хувь нэмэр оруулдаг байна.

Түлхүүр үгс: Эмэгтэйчүүд, эдийн засаг

Оршил

Эмэгтэйчүүдийн маань улс эх орныхоо хөгжилд оруулж буй хувь нэмрийг дурдвал дуусахгүй урт жагсаалт гарч ирнэ. Монгол улсад ажил хөдөлмөр эрхэлж буй иргэд тэр дундаа эмэгтэйчүүдийн маань эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дата мэдээлэлд суурилан судалсан байдал цөөн байдаг нь ажиглагдсан.

Иймээс энэхүү судалгааны ажлаараа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, статистик тоон мэдээлэл, дата ашиглан эмэгтэйчүүд мөн эрчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхой хэмжээнд үнэлж, дүгнэхийг зорьсон болно.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь бүсгүйчүүд тэр дундаа ажил хөдөлмөр эрхэлж буй бүтээлч Монгол эмэгтэйчүүдийн Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд оруулж буй хувь нэмрийг үнэлэхэд оршино.

Судлагдсан байдал

Олон улсад ажил хөдөлмөр эрхэлж буй бүтээлч эмэгтэйчүүдийн эдийн засгийн урт хугацааны өсөлтөд оруулж буй хувь нэмрийг үнэлсэн судалгааны ажлууд цөөнгүй байдаг. Эдийн засгийн өсөлтөд оруулж буй эмэгтэйчүүдийн хувь нэмэр эерэг байдаг (Rodriguez, 2017).¹ Эмэгтэйчүүд шинэ мэдлэг, аргыг хөдөлмөрийн зах зээл дээр авчирдаг ба энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байдаг (J. D. Ostry, 2018).² Эмэгтэйчүүдэд эрх тэгш хөдөлмөр эрхлэх боломжийг олгосон улс орнуудын эдийн засгийн хөгжил өндөр байдаг (Jörg Baten, 2013).³ Жендэрийн тэгш байдлыг хангасан эдийн засгийн хөгжил хурдсаж нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн болон орлого нэмэгддэг байна (Jinyoung Kim, 2016).⁴

Манай улсын хувьд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эмэгтэйчүүдийн хувь нэмэр, оролцоог үнэлсэн бүтээл, судалгааны ажил хомс байна. Монголын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжид нөлөөлөх нөлөөллийг судалсан эрдэмтдийн судалгаа ховор, бодлого боловсруулагчид нь шийдвэр гаргалтандаа төдийлөн анхаарч үздэггүй (Мөнхмандах, 2019).⁵

Ажлын байр, хөдөлмөрийн зах зээлд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцооны түвшинг (АХОТ) нэмэгдүүлж тухайн улсын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг (АХБ, 2020)⁶. Эмэгтэйчүүд боловсролын түвшин болон ур чадвараасаа үл хамааран эрэгтэйчүүдээс доогуур үнэлэгдэх нь элбэг байна (А.Гантуяа, 2020)⁷. Хэдийгээр ҮСХ, жил бүрийн статистикийн эмхэтгэлд хүйсээр ангилсан мэдээлэл оруулдаг ч эдгээр мэдээллийг бүх шатанд, бодлого боловсруулах, төлөвлөхөд хангалттай түвшинд ашиглаж чадахгүй байна. Тиймээс сонгосон

1 Rodriguez, *Economic growth and gender inequality: an analysis of panel data for five Latin American countries*, *Cepal Review* 122, page.99

2 J.D.Ostry, *Economic Gains from Gender Inclusion: New Mechanisms, New Evidence*, IMF 2018, page.20

3 Jörg Baten, *Female autonomy generates superstars in long-term development: Evidence from 15th to 19th century Europe*, *American Economic Review* 2013, page.2260

4 Jinyoung Kim, *A Model of Gender Inequality and Economic Growth*. ADB Economics Working Paper Series 2016, page.20

5 М.Мөнхмандах, *Монгол эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй*, Фридрих Эбертийн сан 2019, х.7

6 АХБ, *Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь*, 2020, х.3

7 А.Гантуяа, *Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн жендэрийн тэгш байдалд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөө*, Фридрих-Эбертийн сан 2020, х.23

аль нэг салбарт жендэрт суурилсан дүн шинжилгээ, жендэрийн нөлөөллийн үнэлгээ зэрэг судалгааг чанартай, сайн хийх боломж хязгаарлагдаж байна (Б.Цолмон, 2014)⁸.

Судалгааны аргачлал

Энэхүү судалгаанд Соловын урт хугацааны эдийн засгийн өсөлтийн загварыг ашиглаж эмэгтэйчүүд тэр дундаа ажил хөдөлмөр эрхэлж буй бүтээлч эмэгтэйчүүдийн Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд оруулж буй хувь нэмрийг үнэлсэн болно.

Соловын урт хугацааны эдийн засгийн өсөлтийн загвар (M.Solow, 1956)⁹:

$$Y_t = A * K^a * L^b$$

Y_t - Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн

K - Бодит эдийн засгийн капитал

L - Ажиллагсдын тоо

a - Капиталын мэдрэмжийн коэффициент

b - Ажиллагсдын мэдрэмжийн коэффициент

A - технологийн дэвшил

Соловын эдийн засгийн урт хугацааны загвар нь эдийн засгийн урт хугацааны өсөлтийг эдийн засгийн эргэлтэд байгаа капитал болон ажиллагсдын тоогоор тайлбарласан олон улсад өргөн хэрэглэгддэг загваруудын нэг юм.

Соловын урт хугацааны загварын функцийг Кобб-Дуагласын үйлдвэрлэлийн функц гэж нэрлэдэг. Соловын загвар маань урт хугацааны эдийн засгийн хөгжил капитал буюу хөрөнгө оруулалт, ажиллагсад буюу ажил хөдөлмөр эрхэлж буй иргэд хувь нэмэр оруулдаг гэж үздэг онол юм.

Соловын үндсэн урт хугацааны загварт ажиллагсад буюу хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоог эмэгтэй болон эрэгтэй ажиллагсдын нийлбэрээр авч үздэг.

Ажил хөдөлмөр эрхэлж буй бүтээлч эмэгтэйчүүдийнхээ хувь нэмрийг үнэлэхийн тулд Соловын загвараа өргөтгөх шаардлагатай болно. Соловын загварыг дараах байдалтай өргөтгөсөн болно.

$$(T) \quad Y_t = A_t * K_t^a * L_t^b$$

$$(T-1) \quad Y_{t-1} = A_{t-1} * K_{t-1}^a * L_{t-1}^b$$

$$(1) \quad \log Y_t = \log A_t + a \log K_t + b \log L_t$$

$$(2) \quad \log Y_{t-1} = \log A_{t-1} + a \log K_{t-1} + b \log L_{t-1}$$

Тэгшитгэл 1-ээс 2-р тэгшитгэлийг хасвал:

$$(3) \quad \Delta Y_t \% = \Delta A_t \% + a \Delta K_t \% + b \Delta L_t \%$$

$$(4) \quad \Delta L_t \% = \Delta L_t^f \% * \left(\frac{L_{t-1}^f}{L_{t-1}} \right) + \Delta L_t^m \% * \left(\frac{L_{t-1}^m}{L_{t-1}} \right)$$

⁸ Б.Цолмон, Монгол улс дахь жендерийн эрх тэгш байдал, Швейцарын хөгжлийн агентлагс 2014, х.72

⁹ M.Solow, R. A Contribution to the Theory of Economic Growth. The Quarterly Journal of Economics 1956, page.66

$\Delta L_t\%$ – нийт ажиллагсдын жилийн өсөлт

$\Delta L_t^f\%$ – нийт эмэгтэй ажиллагсдын жилийн өсөлтийн хувь

$\Delta L_t^m\%$ – нийт эрэгтэй ажиллагсдын жилийн өсөлтийн хувь

$\frac{L_{t-1}^f}{L_{t-1}}$ – өмнөх жилийн эмэгтэйчүүдийн нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь

$\frac{L_{t-1}^m}{L_{t-1}}$ – өмнөх жилийн эрчүүдийн нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь

Тэгшитгэл 4-ийн $\Delta L_t\%$ Тэгшитгэл 3-ийн $\Delta L_t\%$ -ээр орлуулбал дараах байдалтай болно.

$$(5) \quad \Delta Y_t\% = \Delta A_t\% + a\Delta K_t\% + b\left(\Delta L_t^f\% * \left(\frac{L_{t-1}^f}{L_{t-1}}\right) + \Delta L_t^m\% * \left(\frac{L_{t-1}^m}{L_{t-1}}\right)\right)$$

Дээрх тэгшитгэлийг өргөтгөвөл:

$$(6) \quad \Delta Y_t\% = \Delta A_t\% + a\Delta K_t\% + b_1\Delta L_t^f\% * \left(\frac{L_{t-1}^f}{L_{t-1}}\right) + b_2\Delta L_t^m\% * \left(\frac{L_{t-1}^m}{L_{t-1}}\right)$$

Дээрх тэгшитгэл 3 болон 6-аас дараах 5 зүйлсийг үнэлж, дүгнэх боломжтой.

1. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг
2. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд эрчүүдийн оруулж буй хувь нэмрийг
3. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд технологийн дэвшлийн оруулж буй хувь нэмрийг
4. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд капитал хөрөнгө оруулалтын оруулж буй хувь нэмрийг
5. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд ажлын байрны оруулж буй хувь нэмрийг


Судалгаанд ашигласан дата, өгөгдөл

Дээрх тэгшитгэл (3) болон (6) – ын үр дүнг үнэлж дүгнэхэд бидэнд Монгол улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, Эдийн засгийн капиталын хэмжээ, бодит ДНБ-ний өсөлтийн хувь, ажиллагсад, эмэгтэй болон эрэгтэй ажиллагсдын тоо, эмэгтэй болон эрэгтэй ажиллагсдын нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь болон эмэгтэй болон эрэгтэй ажиллагсдын жил бүрийн өсөлтийн тоон мэдээлэл хэрэгтэй болно.

Бодит ДНБ болон ажиллагчидын тоон мэдээллийг Үндэсний статистикийн хорооны www.1212.mn вебсайтаас, капиталын хэмжээг Fred economic data сайтаас авсан болно.

Монгол улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2005 оны зэрэгцүүлсэн үнээр 2020 онд 7,721 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан.


Graphic 1. Real GDP Mongolia 1990-2020, 2005 constant price /million tugrugs/



Source: National statistics office


Fred economic data сайтад Монгол улсын эдийн засгийн нийт бодит капиталын хэмжээг 2019 оны эцэст 2017 оны зэрэгцүүлсэн үнээр 174 тэрбум ам.доллар байна гэж тооцоолсон байна.

Graphic 2. Capital stock Mongolia 1992-2019, 2017 constant price (million usd)




Source: Fred economic data

2020 оны эцсийн байдлаар нийт 1 сая 162 мянган иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд үүнээс 611 мянган эрэгтэй ажиллагсад, 551 мянган эмэгтэй ажиллагсад байна.

Graphic 3. Number of female workers and male workers 1992-2020

Source: National statistics office

Эмэгтэйчүүдийн ажиллагсад эзлэх хувь 2007 онд 51 хувьд хүрч байсан бол 2020 онд 47.4 хувьд хүрсэн байна.

Graph 4. Female workers percentage in total workers 1992-2020

Source: National statistics office

Судалгааны үр дүн

Судалгааны шинжилгээ хэсгийг дээр дурдсан дата, өгөгдөлийг ашиглан Eviews програм дээр гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүн дараах байдалтай гарлаа.

Regression 1. Dependent variable DLogRGDP

Variables	Coefficient	Prob
Constant	0.004	0.650
DLogK	1.62***	0.000
DLogF*ratio	0.61	0.112
DlogM*ratio	0.56	0.152

Эх сурвалж: Судлаачийн үр дүн

DLogK - капиталын тоо, хэмжээний натурал логарифм авсан **утгын** 1-р эрэмбийн ялгавар

DLogF*ratio – эмэгтэй ажиллагсдын тоо, хэмжээний натурал логарифм авсан утгын 1-р эрэмбийн ялгаврыг өмнөх жилийн нийт ажиллагсдын тоонд эзлэх хувиар үржүүлсэн утга

DLogM*ratio - ажиллагсдын тоо, хэмжээний натурал логарифм авсан утгын 1-р эрэмбийн ялгаврыг өмнөх жилийн нийт ажиллагсдын тоонд эзлэх хувиар үржүүлсэн утга

DLogRGD - бодит ДНБ-ний тоо, хэмжээний натурал логарифм авсан **утгын** 1-р эрэмбийн ялгавар

Regression 2. Dependent variable LogRGDP

Variables	Coefficient	Prob
Constant	-16.69***	0.000
LogK	1.83***	0.000
LogL	0.75***	0.000

Эх сурвалж: Судлаачийн үр дүн

LogK – капиталын тоо, хэмжээний натурал логарифм авсан утга

LogL – ажиллагсдын тоо, хэмжээний натурал логарифм авсан утга

LogRGDP – бодит ДНБ-ний тоо, хэмжээний натурал логарифм авсан утга

Regression 3. Dependent variable DLogRGDP

Variables	Coefficient	Prob
Constant	0.004	0.660
DLogK	1.62***	0.000
DLogL	0.59***	0.001

Эх сурвалж: Судлаачийн үр дүн

DLogK - капиталын тоо, хэмжээний натурал логарифм авсан утгын 1-р эрэмбийн ялгавар

DLogL - ажиллагсдын тоо, хэмжээний натурал логарифм авсан утгын 1-р эрэмбийн ялгавар

DLogRGD - бодит ДНБ-ний тоо, хэмжээний натурал логарифм авсан утгын 1-р эрэмбийн ялгавар

Регресс шинжилгээ 1-ийн үр дүнд DlogK хувьсагчаас бусад хувьсагч болох тогтмол, DLogF*ratio, DLogM*ratio нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарлаа. Энэ нь жеңдэрийн хувьд ялгаж эмэгтэйчүүд, эрчүүдийн хувь нэмрийг тусад авч үзэх нь үр дүнгүй болохыг илтгэж байна.

DlogK хувьсагчийн коэффициентийн утга статистикийн хувьд 99.9 хувийн ач холбогдолтойгоор 1.62 гарсан нь Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд капитал хөрөнгө оруулалт чухал болохыг харуулж байна.

Регресс шинжилгээ 2-ийн үр дүнд тогтмол коэффициент, LogK, LogL хувьсагчууд бүгд статистикийн 99.9 хувийн ач холбогдолтой гарсан нь урт хугацааны эдийн засгийн хөгжилд капиталын хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг нь үр дүнтэй болохыг харуулж байна.

Капиталын нийт хэмжээ 1 хувиар өсөхөд эдийн засаг 1.83 хувиар, ажлын байр 1 хувиар нэмэгдэхэд эдийн засаг 0.75 хувиар тус тус өсдөг байна. Эдийн засагт капитал хөрөнгө оруулалт хэрэгтэй байгааг харуулж байна.

Регресс шинжилгээ 3-ийн үр дүнд тогтмол коэффициент статистикийн хувьдагч холбогдолгүй. Харин DlogK, DlogL-ийн мэдрэмжийн коэффициент статистикийн хувьд 99.9 хувийн ач холбогдолтой нь тус тус 1.62 болон 0.59 гарсан байгаа нь өмнөх регресс 2-ийн үр дүн болох 1.83 болон 0.75 утгатай ойролцоо байна.

Энэ нь Монгол улсын урт хугацааны эдийн засгийн урт хугацааны өсөлтөд капиталын хөрөнгө оруулалт, ажлын байр чухал ач холбогдолтой болохыг дахин баталж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

1. Эмэгтэйчүүд, эрчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг жендэрийн нь ялгаж үнэлэх нь үр дүнгүй байна.
2. Эмэгтэйчүүд, эрчүүд маань хамтдаа нэгдмэл байдлаар эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг болохыг регрессийн шинжилгээний үр дүн харууллаа.
3. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр эрчүүдтэй ижил, тэнцүү байна.
4. Монгол улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд капиталын хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Зөвлөмж

1. Эмэгтэйчүүд, эрчүүдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг жендэрээр нь ялгаж үнэлэх зохимжгүй байна. Нэгдмэл байдлаар үнэлэх нь үр дүнтэй байна.

Ном зүй

- J. D. Ostry, J. A. (2018). Economic Gains from Gender Inclusion: New Mechanisms, New Evidence. *IMF Discussion note*, 1-28.
- Jinyoung Kim, J.-W. L. (2016). A Model of Gender Inequality and Economic Growth. *ADB Economics Working Paper Series*, 1-35.
- Jörg Baten, A. d. (2013). Female autonomy generates superstars in long-term development: Evidence from 15th to 19th century Europe. *American Economic Review*, 2227-2264.
- M.Solow, R. (1956). A Contribution to the Theory of Economic Growth. *The Quarterly Journal of Economics*, 65-94.
- Мөнхмандах, А. А. (2019). Монголын эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй . “Эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй” хэмээх бүс нутагт хэрэгжиж буй, 1-26.
- Rodriguez, A. V. (2017). Economic growth and gender. *Cetal*, 80-106.

- А.Гантуяа. (2020). Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн жендэрийн. *www.fes-mongolia.org*, 1-32.
- АХБ. (2020). Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд. АХБ, 1-18.
- Б.Цолмон, А. (2014). Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа. *Швейцарийн Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн*, 1-112.

Зүйр цэцэг үг болон Монголын түүхэн сурвалжуудад илэрч буй эмэгтэйчүүдийн дүр, үүрэг

Д.ЦЭРЭНЖАМЦ

Оюунлаг сургуулийн багш

Abstract: Mongolian proverbs are intellectual culture of heritage. Gender stereotype is transmitted by proverb.

Key words: Proverb, gender, gender-insensitive words, gender stereotype, culture, sex role.

Үндэслэл

Зүйр цэцэн үг нь соёл болохынхоо хувьд тодорхой хэм хэмжээ, үнэлэмжийг илэрхийлж, өвлүүлж дамжуулна. Жендэрийн мэдрэмжгүй зүйр цэцэн үгсийн илэрхийлж буй утга, үнэлэмж нь нэгэнт хуучирсан, одоогийн Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго, зорилтод нийцэхгүй юм. Үүний сацуу Монгол Улсын нэгдсэн олон улсын гэрээ, конвенцын үзэл санаанд ч харш юм.

Тогтвортой хөгжлийн тавдугаар зорилго бол “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” байдаг бөгөөд “жендэрийн хэвшмэл ойлголтыг дамжуулах, хүйсээр ялгаварлахын эсрэг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, ялгаварлан гадуурхалтын жишээ туршлагыг үгүй болгох хүрээнд судалгаа явуулах” гэсэн зорилт бий. Хэл шинжээчдийн гаргасан зүйр цэцэн үгний хэд хэдэн тайлбар толь, судалгааны зохиолууд нь жендэрийн онолын болон эрх зүйн асуудлыг харгалзахгүй байна. Мөн монголын түүхэн сурвалжууд эмэгтэйчүүдийг нийгэм, улс төрийн асуудалд оролцох нь зохимжгүй гэсэн санааг илэрхийлсэн олон тохиолдол байна.

Зорилго

Монгол ардын зүйр цэцэн үг, түүхийн эх сурвалжууд дахь эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн оролцооны талаар илэрхийлж буй ойлголтод дүн шинжилгээ хийх.

Дэвшүүлсэн асуулт, асуудал

Монголын өв соёлыг хадгалан хамгаалах, өвлөн дамжуулах зорилгын үүднээс монгол ардын зүйр цэцэн үгийг судлаачид эмхэтгэн хэвлүүлж байна. Гэвч энэ үйл ажиллагаандаа жендэрийн мэдрэмжгүй үг, жендэрийн хэвшмэл ойлголтыг бий болгож, дамжуулж буй үгсийг хэвлэн, нийтэлж байгаагийн дээр жендэрийн тэгш бус байдлыг байх ёстой зүйл мэт тайлбарлаж байна. Энэ нь хүйсээр ялгаварлан гадуурхах үзэгдлийг бууруулах, үгүй болгоход саад болж байна.

Судалгааны арга зүй, аргачлал

Жендэрийн мэдрэмжгүй үгс, жендэрийн хэвшмэл ойлголтыг дамжуулж буй үгс болгоныг түүвэрлэв. Жендэрийн мэдрэмжгүй үгс, жендэрийн хэвшмэл ойлголтыг дамжуулж буй үгс болгоныг түүвэрлэсний дүнд Монгол ардын зүйр цэцэн үг, түүхэн сурвалжуудын илэрхийлж буй эмэгтэйчүүдийн дүр үүрэг нь эмэгтэйчүүдийг нийгэм, улс төрийн амьдралд оролцох талаар ямархуу ойлголт бусдад нийгэмд төрүүлж буй талаар судалсан.

Онолын хэсэг

Жендэр (Gender). “Жендэр гэдэг нь эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн харилцаанд зохицсон, нийгмийн бүтэц, соёлын хэм хэмжээг илэрхийлэн гаргасан багц шинж чанарыг хэлнэ.” (Түмэндэлгэр, 2019, х.13.) Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд: “жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг” хэлнэ гэж тодорхойлсон. Лорбер (1994) “жендэр бол өдөр тутмын амьдрал, нийгмийн байгууллагын үйл явцад суурьшсан нийгмийн институт” (Түмэндэлгэр, 2019, х.14.) гэжээ. “Жендэр бол нийгмийн бүтцийн нэг хэсэг, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааны талаарх таамаглалыг тусгаж, бэхжүүлдэг нийгэм, соёлын практикийн цогц.” (Richard J Gelles, Ann Levine, 1999, p.361.) Энд жендэрийг соёлын хэм хэмжээ, үнэлэмжээр тодорхойлогддог ойлголт талаас нь авч үзэх бөгөөд уг хэм хэмжээ, үнэлэмжийг зүйр цэцэн үгээр дамжуулдаг, илэрхийлдэг гэж үзлээ.

Хүйсийн үүрэг (sex role). “Жендэрийн үүрэг гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүст ногддог нийгмийн үйл ажиллагаа, ялгаатай байр суурийг хэлнэ. Энэ нь эр ба эм хүйсийн шинж төрхийг ойлгох газар газрын болон нийгэм, соёлын үзэл хандлага бөгөөд түүн дээр үндэслэн нийгмийн нөөц, бололцооноос хүртэх боломжийг тодорхойлдог.” (Онон, Амгалан, Болормаа, Цэдэнбал, Баясгалан, Эрдэнэчимэг, Болормаа, Биндэрья, 2006, х.174.) Жендэрийн үүрэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алинд нь тодорхой үүрэг хариуцлага, хязгаарлалтыг ногдуулдаг ба ингэхдээ эмэгтэйчүүдийн хараат байдлыг хэвээр хадгалдаг бөгөөд зүйр цэцэн үгэнд уг байдал ажиглагдаж байна.

Жендэрийн тэгш байдал (Gender equality). “Жендэрийн эрх тэгш байдал гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.” (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.2) “Жендэрийн тэгш байдал гэдэг нь нийгмийн баялаг, бүтээгдэхүүнийг /аливаа боломж, бололцоо нөөц, баялагийн хуваарилалт/ эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хүртэх ёстойг хэлж байна.” (Онон, Амгалан, Болормаа, Цэдэнбал, Баясгалан, Эрдэнэчимэг, Болормаа, Биндэрья, 2006, х.176.) Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст олгогдох боломж адил тэгш байхыг хэлнэ. Жендэрийн мэдрэмжгүй зүйр цэцэн үгсийн илэрхийлж буй үнэлэмж, эрэгтэй эмэгтэй хүмүүст оноож буй үүрэг жендэрийн эрх тэгш байдлыг тогтоох зорилгод харш юм.

Жендэр ба соёл (**Gender and culture**). “Соёлыг амьдрах загвар, хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулахад ашигладаг нийтлэг ойлголт”(Richard J Gelles, Ann Levine, 1999, p.84.) гэж тодорхойлж болно. “Тухайн нийгмийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүр – үүрэг нь нийгмийн бүтцээр тодорхойлогддог. Дүр үүрэг нь зан үйлийн хүлээлт, хэм хэмжээ болохын хувьд

соёлоос хамаардаг” (Түмэндэлгэр, 2019, х.19.) байна. Н.А.Бердяев “Соёл нь өвөг дээдсээ шүтэхүй, хууч яриа болон уламжлалтай холбоотой. Соёл нь оюуны өөр үйл ажиллагааны тэмдэг ба төсөө бүхий ариун бэлгэдлээр дүүрэн байдаг” гэж тодорхойлжээ. (Дорждагва, 2010, х.56.) Жендэрийн тухай тодорхойлолтыг дээр нэгэнт авч үзсэн соёлын үнэлэмж, хэм хэмжээ дамжуулдаг нь хэл мөн, зүйр цэцэн үг хэл болох юм. Зүйр цэцэн үгээр дамжуулж буй үнэлэмж, хэм хэмжээ нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бий болгож, дамжуулж буй юм. Доктор С.Түмэндэлгэр: “Аливаа хэл үүргийнхээ дагуу жендэрийн хэвшмэл ойлголтыг (gender stereotype) нэг үеэс нөгөө үед залгамжлуулдаг тул хэлэн дэх жендэрийн хэвшмэл ойлголтыг дамжуулах үгс, хэлц үгсийг хэрэглэхээс татгалзах нь жендэрийн зор тэгш байдлыг тогтооход ихээхэн тустай” хэмээн тэмдэглэжээ. (Түмэндэлгэр, 2019, х.21.)

Монгол ардын зүйр цэцэн үг ба жендэр

Жендэрийг тодорхойлох маскулини (masculine), фемини (feminine) гэсэн хоёр хандлага байдаг. Зүйр цэцэн үгэнд хүйсийн үүргийг (sex role) харуулахдаа маскулини (masculine) хандлага зонхилж байна. Доорх хүснэгтэд жендэрийн мэдрэмжгүй зүйр цэцэн үгсийн илэрхийлж буй хүйсийн үүргийг авч үзлээ.

	Зүйр цэцэн үг	Илэрхийлж буй ойлголт	
Жендэр эрхэмнэл	Элээ муу боловч мэлхийдээн зөв, эр муу боловч эмдээ зөв Эм хүн эргүй бол биед нь эзэнгүй Эм хүнтэй хэлэлцдэггүй, гүү мориор уралддаггүй Эр муу боловч эмийн дээр, эмээл муу боловч морины дээр Эрийн сайн гэрийн гадаа, эхнэрийн сайн гэрийн дотор Эзэн муутын хороо хүйтэн, ээж муутын хоол хүйтэн	Эр	Эм
		Би эрэгтэй хүн тул өрхийг тэргүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, гэр бүлээ төлөөлөх нь ёстой.	Нийгмийн амьдралд идэвхтэй байдал эмэгтэй хүнд зохимжгүй, нөхрөө халамжилж, үр хүүхдээ халамжлах нь илүү чухал.
Хүйсийн үүрэг	Эзэн муутын хороо хүйтэн, ээж муутын хоол хүйтэн Муу эм хормой баастай, сайн эм атга баастай Эр хүний жаргал эзгүй хээр, эм хүний жаргал гэрийн тал Охины муу өглөө мэдэгдэх Эр үхрийн эвэр хатуу, залуу бэрийн идээ хатуу Сайн эр хоёр төрд зүтгэдэггүй, сайн эм хоёр эрд нөхцдөггүй Эрийн сайн гэрийн гадаа, эхнэрийн сайн гэрийн дотор	Эр	Эм
		Гэр бүлийн харилцаанд ноёлох байр суурь эзэлж, аж ахуйн үйлд үл оролцохын сацуу улс төр, эдийн засаг, бусад нийгмийн харилцаанд тэргүүлэх, гэр бүлээ төлөөлөх.	Үр хүүхдээ халамжлах, гэр ахуйгаа тордох зэрэг үйлийг гүйцэтгэх ёстой.

Зүйр цэцэн үгсийн эмхэтгэл бүтээлүүдийн нийт 10000 гаруй үгнээс дээрх 42 үгийг жендэрийн мэдрэмжгүй үгс хэмээн түүвэрлэв. Нийт зүйр цэцэн үгний 0.42 хувийг эзэлж байна. Тэдгээр үгсээс хүйсээр ялгаварлан гадуурхсан 22 үг байна. Мөн эмэгтэй хүнийг эр хүнээс хараат байдгийг заасан 9 үг бусад 11 үг нь өөр зонхилж буйгаас өөр утгатай үгс байна.

1. Зүйр цэцэн үгийн утга ба онолын тайлбар

Доорх хүснэгтэнд зүйр цэцэн үгсийг онолын хэсэгт дурдсан онолуудын дагуу шинжлэн, тайлбар хийлээ.

№	Зүйр цэцэн үг	Хэл шинжээчийн тайлбар	Жендэрийн онолын дүн шинжилгээ
1	Эе эвдрүүлдэг эхнэр, газар эвддэг гахай	Хэрүүлч эхнэр, гахай хоёрын уршгийг жишсэн нь гахайндаа биш эхнэртээ, угийн хүмүүжил дэггүй хүүхнийг жишсэн хэллэг	Бэлгэ тэмдгийн онолын үүднээс тайлбарлавал энэ үг эмэгтэй хүнийг эе эвдрүүлдэг гэсэн сөрөг шошго нааж байна.
2	Эзгүй - гэр эргүй эхнэр	Эх захаа алдсан, дураараа дургих оромж гэсэн егөөдөл	Эмэгтэй хүнийг эрэгтэй хүнээс хамааралтай байдаг гэсэн санааг эзгүй гэртэй адилтган зүйрлэжээ. Уг үг нь эцгийн эрхэт ёсны соёлын итгэл, үнэмшлийн нэгэн хэлбэр.
3	Эзэн муутын хороо хүйтэн, ээж муутын хоол хүйтэн	Хүн, малд халамжлах ёстой этгээд нь эс халамжлах гэсэн егөөдөл	Ээж хүн үр хүүхэддээ халамж тавих ёстой гэсэн санааг илэрхийлсэн үг. Бүтэц чиг үүргийн онолын үүднээс тайлбарлавал эмэгтэй хүн үр хүүхдээ халамжлах илэрхийллийн үүргээ биелүүлэхгүй байна. Либерал феминизмийн үүднээс яагаад зөвхөн ээж нь хүүхдээ халамжлах ёстой вэ? Аав нь яагаад халамжлахгүй байна вэ? гэсэн асуултыг тавина. Мөн асрах үүргийг гэр бүлд бүхэлд нь оноох ёстой.
4	Эм хүн долоон ходоодтой	Эхнэр, эмэгтэйчүүд юманд сэтгэл ханадаггүй	Эмэгтэй хүнийг долоон ходоодтой мэт аливаа зүйлд ханадаггүй, шуналтай гэсэн утгыг илэрхийлжээ. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онолоор бол эмэгтэй хүн “шуналтай” гэсэн шошго нааж байна.
5	Эр муу ч эмийн дээр, эмээл муу ч морины дээр	Ахуй амьдралын үзэгдэл дэх жам ёсны байр суурь, харилцааны зүйрлэл	Эрэгтэй хүн ямагт эмэгтэйчүүдээс давуу байр суурьтай байдаг гэсэн санааг илэрхийлжээ.
6	Эр хүний хэлсэн тосон дээгүүр, эм хүний хэлсэн усан доогуур	Эзэрхэг засгийн үед эр, эм хүнийг ялгаварлан үзэж эр хүний үг үнэтэй, эм хүний үг үнэгүй гэж жишсэн өрөөсгөл ухагдахуун	Эр хүний хэлсэн зөв, эмэгтэй хүний хэлсэн буруу, эмэгтэй хүний хэлснийг дагавал үр ашиггүй, хохирно гэсэн санааг илэрхийлжээ.
7	Эд нь эзнээрээ болдог, эхнэр нь эрээрээ болдог	Айл гэрийн эд хөрөнгө, эхнэр нь өрхийн тэргүүлэгчийн хэр зэрэг авч яваагаас шалтгаалах гэсэн санамж	Энэ зүйр үгийн утгыг жендэрийн нүдээр харвал эхнэр хүн цаашлаад айл гэрийн өнгө төрх зөвхөн нөхрөөсөө бүрэн хамаарч шалтгаалж амьдардаг гэсэн санааг тусгажээ. Энэ нь патриарх буюу эцгийн эрхт ёсны онолын үүднээс ихэнх эрчүүд “Бид байгалаас эмэгтэйчүүдээс илүү заяагдсан тул өөрсдийн амьдралаа залж явах чадвар бидэнд илүү бий” гэдэгт хатуу итгэн эрх мэдэл, хянах эрх бүхий эрэгтэй хүйс нийгмийн “шилдэг” гэх хөлстэй ажил хөдөлмөрөөс эм хүнийг хасах, эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийн хамаарах явдлыг хадгалах замаар хөдөлмөрийн зах зээл хийгээд өрхийн хүрээнд эрчүүд эмэгтэйчүүдийг мөлждөг гэдэг утгаар тайлбарлагдана. Мөн гэрийн хөдөлмөр нь эмэгтэйчүүдийн гүйцэтгэх ёстой үндсэн ажил, орон гэр бол байх ёстой газар болдог тул гэрийн хөдөлмөрийн ачаалал эмэгтэйчүүдийн нуруун дээр байдаг.
8	Эмээ дагаж төрхөмд нь зарагдах, өр ширэнд баригдаж төрөгсдөө зовоох	Урагшгүй доройхон эрийн амьдралын төөрөг, дүр төрхийг дүрсэлсэн хэллэг	Жендэрийн харилцааны феминист онол нь эмэгтэйчүүдийн талаарх энэ зүйр үг мэтийн буруу ташаа ойлголт домгуудын алдааг засахад анхаардаг.

9	Эр сайтай эм төлөв, эзэн сайтай морь номхон	Өрх гэрийн эзний зан чанар нь гэрийн эзэгтэй хийгээд эзэлдэг мал сүрэгт нь нөлөөлдөг	Тус зүйр үг нь гэр бүлийхний хувьд эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүд хамааралтай, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд нөлөөлдөг гэсэн утгыг илэрхийлж буй бөгөөд эрчүүд бол хөрөнгөтнүүд тиймээс эрчүүд хүч чадал, заль мэхээрээ эмэгтэйчүүдэд ажлын норм тогтоож, тэднийг хараат байдалд байлгаж байдаг, мөн эрэгтэйчүүдийн давуу талыг нийгмээс тогтоож өгсөн соёлын хэм хэмжээ, үнэлэлт дүгнэлт улам лавшруулдаг гэсэн өрөөсгөл санааг томруун харуулж буй бөгөөд эцгийн эрхэт ёсны бүтэц, соёлын итгэл үнэмшил, үнэлэмж, хэм хэмжээнээс хамааран хүйсийн нэг бүлэгт давуу боломж олгож, нөгөөгийн эрхийг хааж буй аливаа үйлдэл, эс үйлдэл нь жендэрийн ялгаварлан гадуурхалтын илрэл мөн гэсэн үзлийг үгүйсгэсэн утгыг агуулж буй нь алдаатай болно.
10	Эр үхрийн эвэр хатуу, залуу бэрийн идээ хатуу	Идээ цагаагаа хийж дадаагүй бэрийн ажлыг егөөдөж зүйрлэсэн	Залуухан гэрийн эзэгтэйг идээ цагаагаа сайн хийж чадахгүй, цаашдаа сурах ёстойг үүрэг болгож байна. Постмодернизмын үүднээс эмэгтэй хүнийг идээ цагаагаа сайн хийж сурах ёстой гэсэн ойлголтыг төрүүлж, хөлсгүй гэрийн хөдөлмөрийг зөвхөн эмэгтэйчүүд хийх ёстойг эмэгтэй хүнээр өөрөөр нь хүлээн зөвшөөрүүлж, эрчүүдийг гэр бүлийн харилцаанд ноёрхох нөхцөлийг бүрдүүлж байна. Бүтэц чиг үүргийн онолын үүднээс энэ нь гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг хангаж буй хэрэг болно.
11	Эргүй эм задгай, эрэггүй ус халимтгай	Нөхөргүй хүүхэн хааж хамгаалах юмгүй учир шалиг, завхай дураараа гэсэн зүйрлэл	Эмэгтэй хүнийг эр хүний хараат байх нь зөв, ингэснээр эмэгтэй хүн аз жаргалтай байна гэсэн ойлголтыг төрүүлж байна. Уг үг нь эцгийн эрхэт ёсны соёлын итгэл, - үнэмшлийн нэгэн хэлбэр юм.
12	Эр хүн зорьсондоо эс хүрвэл эм шинжийг олно, эр морь харайсандаа эс хүрвэл гүү шинжийг олно	Эр, морь хоёр зорьсондоо эс хүрэл эм шинжтэй болно. Тэгвэл эр амьтан байхгүй болох нь уу гэсэн егөөдөл.	Энэ зүйр үг нь эмэгтэй хүнээс эрэгтэй хүнийг давуу гэдгийг илэрхийлсэн утгыг агуулж байна. Бид байгалиас эмэгтэйчүүдээс илүү заяагдсан хэмээн үздэг эцгийн эрхт ёсны онолын санаа.

Зүйр цэцэн үгийн тайлбарыг: “Н.Ням-Осор, Б.Өлзийсүрэн. (2011). Монгол хэлний зүйр цэцэн үгний товч тайлбар толь. УБ.,” –аас авав. Монголын түүхэн сурвалжууд дахь эмэгтэй хүний дүр үүрэг

Монголын нууц товчоонд “Алангоог үнэнхүү гоо сайн, алдар нэр ихтэй, Алангоо нэртэй ...” (Монголын нууц товчоо. §7. 2019. Х 9.) хэмээсэн байдаг. Өгэлүн үжинг “өнгө зүс бустай” (Монголын нууц товчоо. §54. 2019. Х 22.) буюу ер бусын гоо өнгө зүстэй хэмээж дүр төрхийг нь магтжээ. Бөртэг “нүүрэндээн гэрэлтэй, нүдэндээ галтай” (Монголын нууц товчоо. §66. 2019. Х 28.) хэмээсэн байна. Бөртэг Хөх Сударт “... өглөөний туяа мэт тунгалаг, гийвэн зүсэд үлитгэшигүй гарьд галбингын нүдтэй. Үүл арилсан огторгуйн хөмсөг урт хасаар зүлгэсэн чиг сайхан хамар, шүрээр шигтгэсэн мэт улаан товчийн уруул, нүд дүүрэн гал, хацар дүүрэн гэрэл, бэлхүүс нарийн, бие гянгалхан, аван үзвээс есөн тэнгэрийн хувилгаан охин мэт ...” (Инжиннаши. 2005. Х 128.) гэжээ. Эмэгтэй хүний зүсийг тодорхой өгүүлсэн нь Элбэг нигүүлсэгч хаан “энэ цасан мэт цагаан нүүртэй, энэ цусан мэт улаан хацартай эм болтугай хэмээвээс ... Харгучуг хунтайжийн гэргий Өлзийт хун гоо бэйжийн өнгө гэрэл нь үүнээс үлэмж гоо ...” (Саган сэцэн. 2015. Х 158.) хэмээдэг. Дээрх мэдээнүүдээс дүгнэн үзэхэд эмэгтэй хүний дүр төрхийг тодорхой өгүүлээгүй ч “гэрэлтсэн цагаан царай, цус мэт улаан хацар” гэх мэтээр эмэгтэй хүний гадна төрхийг бичжээ.

Мөн Алангоо эхийн сургаал болон Өүлэн хатны үгсийг ажиглавал Өүлэн үжин Тэмүжинг зэмлэхдээ:

*“Харвисаа хазах
Хасар нохой мэт
Агуураан даран ядах арслан мэт
Сүүдэртээн довтлох шонхор мэт
Сэмээр залгих цурхай мэт
Ботгоныхоон борви хазах буур мэт
Бороонд шахах чоно мэт
Хөвүүдээн гилэн ядаж
Хөвүүдээ идэх ангир мэт
Хэвтишээн хөндвөөс өмөөрөх цөөвөр мэт
Барьж үл саарах барс мэт
Балмад довтлох баруг мэт барав”* (Монголын нууц товчоо. §78. 2019. Х 37-38.) гэж хэлжээ.

Түүхэн сурвалжуудад *“Мандухай сэцэн хатан”* хэмээн Мандухай хатныг тэмдэглэсэн байна. Мандухай хатан Хорчины Өнөболд вангийн гэргий болохоос татгалзан долоон настай Батмөнхийг үхэгт тээн Ойрадыг довтлон ялсан ажээ. (Сагансэцэн. 2015. Х 186.) Мөн түүнийг *“ухаант Мандухай”* хэмээн тэмдэглэсэн байна.

Түүхэн сурвалжуудад эмэгтэйчүүдийг тэмдэглэхдээ ихэвчлэн царай төрхийг онцлон тэмдэглэсэн байна. Мөн эмэгтэйчүүдийг “нөхрөө зөв сонгосон, үр хүүхдүүдээ сайн хүмүүжүүлсэн” гэсэн шалгуураар “ухаантай” хэмээн тэмдэглэжээ. Түүхэн сурвалжуудад эмэгтэйчүүдийн үйл хэргийг онцлохдоо ихэнх тохиолдолд “хүүхдээ хүмүүжүүлж буй арга”-ыг нь голчлон тэмдэглэж байна.

Дүгнэлт

Зүйр цэцэн үгс нь эмэгтэй хүнд буруу сэтгэгдэл төрүүлэх, нийгэм болон соёлын харилцаанд ялгаварлан гадуурхагдсан мэдрэмж төрүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг улам бэхжүүлж эмэгтэй хүн үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн ойлголт төрүүлэх нэг эх сурвалж болж байна. Эрчүүд гэр бүлийн харилцаанд эрэгтэй нь ноёлох, эмэгтэй хүний үзэл бодлыг хүндэтгэхгүй байх, эрэгтэй хүн угаас эмэгтэй хүнээс илүү гэх ойлголтыг төрүүлж байна. Энэ нь жендэр ба тогтвортой хөгжлийн тавдугаар зорилт болох “жендэрийн хэвшмэл ойлголтыг дамжуулах, хүйсээр ялгаварлахын эсрэг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, ялгаварлан гадуурхалтын жишээ туршлагыг үгүй болгох хүрээнд судалгаа явуулах” зорилтын эсрэг чиглэгдэж байна. Өөрөөр хэлбэл зүйр цэцэн үгсийг хүмүүсийн харилцаанд хэрэглэж, хэвлэн нийтэлж албан боловсролын хүрээнд ашиглагдах боломжтой болсон нь тогтвортой хөгжлийн тавын гурав дахь зорилтыг хэрэгжихэд саад болж байна. Хуульд тодорхой заасан ялгаварлан гадуурахгүй байх, тэгш эрхтэй байх зэргийг тэгш бус байдлыг өгүүлсэн, ялгаварлан гадуурхалтыг зөвтгөсөн үгсийг хэвлэн нийтэлж буй нь зохимжгүй юм.

Түүхэн сурвалжуудад эмэгтэйчүүдийг тэмдэглэхдээ ихэвчлэн царай төрхийг онцлон тэмдэглэсэн байна. Мөн эмэгтэйчүүдийг “нөхрөө зөв сонгосон, үр хүүхдүүдээ сайн хүмүүжүүлсэн” гэсэн шалгуураар “ухаантай” хэмээн тэмдэглэжээ. Түүхэн сурвалжуудад

эмэгтэйчүүдийн үйл хэргийг онцлохдоо ихэнх тохиолдолд “хүүхдээ хүмүүжүүлж буй арга”-ыг нь голчлон тэмдэглэж байна.

Санал зөвлөмж

- Жендэрийн мэдрэмжгүй үгсийг харилцаандаа хэрэглэхгүй байх
- Жендэрийн мэдрэмжгүй үгсийн талаар тусгай сургалтуудыг явуулах
- Зүйр цэцэн үгсийг тайлбарлахдаа жендэрийн агуулгыг харгалзах

Ашигласан материал:

1. *Richard J Gelles, Ann Levine, 1999, Sociology.*
2. Аким Г. (2001) Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь. УБ.
3. Дашдорж Ж, Ринчэнсамбуу Г. (2008) Монгол ардын зүйр цэцэн үг. УБ.
4. Дорждагва. Соёл судлал. 2010.
5. Гидденс. А. (2006) Социологи. УБ.
6. Ням-Осор Н, Өлзийсүрэн Б. (2011). Монгол хэлний зүйр цэцэн үгний товч тайлбар толь. УБ.
7. Одгэрэл Ц, Түмэндэлгэр С, Батзаяа Б, Туяачимэг Т, Үүрийнтуяа Т. (2018) Боловсрол дахь жендэр. УБ.
8. Смелзер. Н. (2018) Социологи. УБ.
9. Түмэндэлгэр С. (2019) Нийгэм ба жендэр. Социологиор төсөөлөхүй. УБ.
10. Монголын нууц товчоо. §66. УБ., 2019. Тал 28. Хөрвүүлж тайлбар үйлдсэн Ш.Чоймаа.
11. В.Инжаннаши. Хөх судар. УБ., 2005. Тал 128. Хөрвүүлж тайлбар үйлдсэн Ш.Чоймаа.
12. Сагансэцэн. Эрдэнийн товч. УБ., 2015. Тал 158. Хөрвүүлэг, тайлбар хийсэн М.Баярсайхан.
13. Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж оршвой. УБ., 2015. Тал 63. Хөрвүүлэг, тайлбар хийсэн Ц.Шагдарсүрэн.
14. Габаншарав. Дөрвөн Ойрадын түүх. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд. УБ.,2002. Тал 77. Тод болон худам монгол бичгээс кирилл бичигт буулган, тайлбар хийсэн На.Сүхбаатар.

Автомашинь засварчин, гагнуурчин мэргэжлээр элсэн суралцах охидын асуудал

Г.УРАНЧИМЭГ

Товч агуулга: Нийгэмд эрэгтэй, эмэгтэй гэх хүйсийн ялгааг бид өөрсдөө гаргадаг. Эхээс төрөхдөө бид эр, эм хүйсээр ялгаатай төрдөг ч нэг нь нөгөөгүйгээрээ оршин тогтнох боломжгүй билээ. Тиймээс бид өөрсдийн ялгаатай талыг асуудал биш боломж хэмээн хүлээн зөвшөөрөх нь зөв юм. “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох нийгэм, соёлд тулгуурласан ялгаа. Тодорхой нэг нийгмийн зүгээс эрэгтэй, эмэгтэй хүмүүст зохистой гэж үзэн тогтоосон үүрэг, зан төлөв, хандлага бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөрчлөгддөг.” Тиймээс хүнд хүчир ажил хөдөлмөрийг ч бас эмэгтэйчүүд эрэгтэй хүнтэй адил бие даан ажиллаж чадах юм. Тэр дундаа автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр яагаад заавал эрэгтэй хүн ажиллах ёстой гэж. Эмэгтэй хүн ч бас бусдын адил ур чадвар, мэдлэгээрээ бусадтай адил түвшинд ажиллаж чадна..

Автомашинь засварчин, гагнуурчин мэргэжлийг нэр томъёо, онол, хөдөлмөрийн аюулгүй байдал талаас нь судалсан ном бүтээл их байдаг. Мөн тухайн мэргэжлийн онцлог давуу тал, ажлын байрны эрэлт хэрэгцээ, хувь хүний карьер, ажлын байранд хийж гүйцэтгэх үүрэг гэх мэт олон талаас нь судалсан байдаг боловч жендэрийн асуудлыг хараахан судлаагүй байна. Тиймээс жендэрийн асуудлыг google from, spss судалгааны аргыг ашиглан энэхүү нийтлэлийг бичихийг зорилоо.

Түлхүүр үг: автомашины засварчин, гагнуурчин, охид, тэгш байдал, жендэр

НЭГ.АВТОМАШИНЫ ЗАСВАРЧИН, ГАГНУУРЧИН МЭРГЭЖЛЭЭР ЭЛСЭН СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ЯЛГАА

1.Сүүлийн жилүүдэд автомашины засварчин, гагнуурчин мэргэжлийн эрэлт хэрэгцээ их байна. Тэр дундаа эдгээр мэргэжлээр элсэн суралцах суралцагчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа нь сайшаалтай юм. Доорх хүснэгтэд ²2018-2019 оны хичээлийн жилд 24999 суралцагч мэргэжлийн боловсрол олгох сургалтын хүрээнд шинээр элссэн суралцагчид өмнөх жилийнхээс 28.1 хувиар өссөн байна. Мөн 9485 буюу нийт элсэгчдийн 37.9 хувь нь эмэгтэй суралцагч байна. Шинээр элсэгчдийн 7521 буюу 30.1 хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын 9 дүгээр ангийг төгссөн суурь боловсрол эзэмшигчид, 4905 буюу 19.6 хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын 12 дугаар анги төгссөн бүрэн дунд боловсрол эзэмшигчид, 25.0 хувь нь ажилгүй иргэдээс, 22.3 хувь нь ажиллагчдаас, 3.1

1 http://portal.merit.mn/dataset/37eada02-cb75-448a-8991-a4a0b5a3dcf6/resource/1ebf8ddd-dc27-455d-9db7-42dfb5dcc989/download/intro-to-gender-and-gender-mainstreaming-in-project-cycle-mng_updated.pdf

2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл

хувь нь бусад сургуулиас элссэн байна.” Энэ нь мэргэжлийн боловсрол олгох сургалтын эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Үзүүлэлт	Хичээлийн жил					
	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Шинээр элсэгчид	20921	20804	20961	18769	19519	24999
Үүнээс эмэгтэй	8821	8445	8214	7631	7854	9485
эрэгтэй	12100	12359	12747	11138	11665	15514
Шинээр элсэгчдээс тухайн жилд 9-р анги төгсөгчид	9944	10982	10388	5455	5809	7521
Шинээр элсэгчдээс тухайн жилд 12-р анги төгсөгчид	5738	5130	3195	4416	3246	4905
Ажиллагчдаас	1639	1378	2319	2818	4228	5571
Ажилгүй иргэдээс	2999	2616	4530	5309	5709	6238
Бусад сургуулиас	601	752	529	771	527	764

Эх сурвалж: Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл


2.2018-2021 оны автомашины засварчин, гагнуурчин мэргэжлийг сонгосон суралцагчдын хүйсийн харьцуулалт

Гагнуурчин				
Он	Анги бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Охидын эзлэх хувь
2018	Га-1а	26	0	0
	Га-1б	21	0	0
2019	Га-1а	28	0	0
	Га-1б	24	0	0
2020	Га-1а	36	0	0
	Га-1б	36	1	0,02
2021	Га-1а	37	0	0
	Га-1б	34	0	0

Автомашины засварчин				
Он	Анги бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Охидын эзлэх хувь
2018	Авто-1а	39	0	0
	Авто-1б	37	0	0
2019	Авто-1а	40	2	0,04
	Авто-1б	39	2	0,05
2020	Авто-1а	38	0	0
	Авто-1б	36	1	0,02
2021	Авто-1а	35	0	0
	Авто-1б	36	0	0

Монгол Улсын эмэгтэйчүүдийн аж байдалд ардын хувьсгал үлэмж их өөрчлөлт авчирсан юм. 1924 онд батлагдсан Монгол Улсын анхны Үндсэн хуульд ³“Тус улсын харьяат ард түмэн, иргэн угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаагүйгээр нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино” гэж хүйсийн тэгш байдлыг тунхагласан байдаг. Энэ хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулж, бие хүнд эрх чөлөө олгож, гэрлэх хүнээ өөрсдөө сонгох эрхийг олгосноор өөрчлөлт гарчээ. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэй хүнтэй адил эрх эдлэх гарцыг нээж өгсөн гэж хэлж болно. Харин одоо хорин нэгдүгээр зуунд монгол улсын эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил түвшинд хөдөлмөр эрхлэх эрх бий болсон ч бодит байдал дээр хүйсийн ялгаатай байдал ажиглагдсан хэвээр байна. Үүний нэг жишээг дээрх хүснэгтээс харж болно. Үүнд: Монгол-Солонгосын Политехник Коллежийн 2018-2021 онд автомашины засварчин-300, гагнуурчин-209 суралцагч элсэн сонгосноос гагнуурчин мэргэжлийн эмэгтэй оюутны эзлэх хувь 0.004% харин автомашины засварчин-0.01%-ийг эзэлж байна. Энэ хуульд эрх тэгш байдлыг заасан ч амьдрал дээр уг хууль хэрэгжихгүй эмэгтэйчүүдийн оролцоог орхигдуулж буйг илтгэж байна.

2018-2021 оны автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр элсэн орсон суралцагчдын хүйсийн харьцааг графикаар илэрхийлбэл:



3 Монгол Улсын үндсэн хууль. Баримт бичиг.УБ, 2004, 43х

Тухайн мэргэжлээр элсэн орсон суралцагчдын хүйсийг харьцааг дүгнэж үзвэл. Эмэгтэй суралцагчид нийт суралцагчдын 1% -д хүрэхгүй байгааг ажиглаж болно. Энэ нь автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр элсэн орж байгаа суралцагчдын дунд эмэгтэй суралцагч цөөн буюу өдрийн од шиг ховор байгааг илтгэнэ. Манай улс “эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад 1992 оноос хуулийн шинэ орчинг бүрдүүлсэн юм. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд манай улсын эрэгтэй, эмэгтэй бүх иргэн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэйг баталгаажуулжээ. Түүнчлэн, ялгаварлан гадуурхахгүй байх, тахир дутуу иргэн өндөр настанг асрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхийг нь хуульчилсан юм.” Энэ нь заавал засварчин, гагнуурчин гэхээр эмэгтэй хүнээс хол хийж болохгүй мэргэжил мэтээр ойлгох нь буруу юм. Охид ч бас хөвгүүдийн адил боловсрол эзэмшиж бие даан ажиллах боломжийг эрэл хийж буйг бид нийгмээс харж болно. Жишээ нь: Гагнуурчин мэргэжлээр элсэн суралцсан Э.Уужимсэтгэлт Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зарлигаар “Шилдэг залуу ажилчин” шагнал хүртэж, Төрийн ордонд шагналаа гардан авсан юм. Энэхүү шагналыг 10 сая төгрөг дагалдах юм байна. Э.Уужимсэтгэлт «Монгол ур чадвар 2018» уралдаанд хоёрдугаар байрт орж, “Оюу Толгой” компанид 10 сар бэлтгэл хийжээ. Энэхүү уралдаан 2018 оны нэгдүгээр сард болсон бөгөөд эмэгтэй оролцогч сүүлийн шатанд өрсөлдөхөөр үлдсэн нь олон хүний анхаарлыг татсан гэдэг. Энэхүү шалгаруулалтын эцсийн тэмцээн 2018 оны 12 дугаар сарын 6-д болоход, ялагчаар Т.Оюун-Эрдэнэ шалгарч дэлхийн тэмцээнд эх орноо төлөөлөн оролцохоор болсон. Гэхдээ Э.Уужимсэтгэлт үндэсний тэмцээнд хоёрдугаар байранд орсон ч гагнуурчин мэргэжлийн сайхныг мэдэрч олон залууст урам өглөө. 18 настай охин Э.Уужимсэтгэлт Монголд цөөн байдаг эмэгтэй гагнуурчдын нэг юм. Тэрбээр 15 настайдаа Монгол-Солонгосын политехник коллежийн гагнуурын ангийн оюутан болж байжээ. 2,5 жил суралцаж, гагнуурын мэргэжлээр төгссөн ч инженерийн байгууламжийн технологийн техникч мэргэжлээр үргэлжлүүлэн сурч байгаа аж. Түүнд ажлын саналууд ирдэг ч сургуульдаа багшлахаар болсон байна. Энэ нь гагнуурчин мэргэжлээр эмэгтэй хүн бусадтай адил боловсрол эзэмшин ур чадвараараа өрсөлдөж чадна гэдгийг харуулсан нэгэн том жишээ юм. Эмэгтэй суралцагчид өөрөө хүсвэл боломж үргэлж нээлттэй юм.

3. Автомашины засварчин, гагнуурчин мэргэжлийн онцлог давуу тал

Автомашины засварчин

1.Хийж гүйцэтгэдэг ажил: Суудлын болон ачааны машин, мотоцикл, тээврийн бусад хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, ажиллагааг мэдэж, түүний эвдрэл гэмтлийг оношилж, засвар үйлчилгээ хийнэ.

2.Мэргэжлийн ур чадвар: Зурж боловсруулах, хурдан шаламгай, хөдөлгөөний эвсэлтэй, төлөвлөх, тооцоолох, зохион бүтээх, тайлагнах, бусадтай харилцах, шийдвэр гаргах чадвартай байх.

3.Бие хүний онцлог шинж чанар, чадварууд: Хувийн зохион байгуулалттай, ой тогтоолт сайтай, сэтгэн бодох чадвартай, харилцааны соёлтой, техник сэтгэлгээтэй, сэтгэл хөдлөлөө хянах, бие дааж ажиллах, багаар ажиллах, шийдвэр гаргах, ачаалал даах чадвартай байх.

4.Ирээдүйд ахих дэвших боломж: Мэргэжлээрээ идэвх зүтгэл, бүтээл гаргаж сайн ажилласан

4 Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого. Жендэрийн тэгш байдал. УБ. 2011. 7х

хүн мэргэжлийн зэрэг ахиулж, зэргийн болон олон жил ажилласны нэмэгдэл авч цалин хөлсөө нэмэгдүүлэх. Мөн энэ ажлаараа ахлах, ээлжийн болон хэсгийн дарга, чанар шалгагч, тоо бүртгэгч, багш гэх мэт ажил мэргэжлээр ахих дэвших. Боловсролоо ахиулж их дээд сургууль, коллеж төгсөж механик, инженер, дарга зэрэг ажил хийх боломжтой.

5.⁵“Тухайн мэргэжлээр гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэл:

Машины эд ангийг шалгаж гэмтэлтэй эд анги, ажиллагааны доголдлыг тэмдэглэж, удирдлагаас болон инженерүүдээс засварын ажлын талаар зөвлөгөө авах.

- ✓ Машин, сэлбэг, бусад тоног төхөөрөмжид тусгай горимын дагуу тослогоо хийнэ. Үйлдвэрийн заавар, журмын дагуу машины эд анги, сэлбэг хэсгийг суурилуулах, солих, задалж авах.
- ✓ Машиныг гар багаж, гинжит оосор, өргүүр, кран, өргөгч ашиглан задалж эд ангийг авна. Машинд хийсэн засварлах, арчлах ажлуудыг хөтөлж, бүртгэнэ. Машиныг засаж арчлахад шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмыг тодорхойлохын тулд ажлын даалгавар, удирдамжийг уншиж танилцах.
- ✓ Машинд тохиргоо хийж ажиллуулан, ажиллагааг тохируулах удирдлагыг тааруулна. Машиныг хөдөлгөх, сэлбэг болон тоног төхөөрөмжийг засах, шилжүүлэхэд бусад ажилчидтай хамтран ажиллана. Машины засвар, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг, материалыг захиалж, нөөц бүрдүүлэх.
- ✓ Кран, өргөгч, түрэгч ашиглан ажлын байр, агуулахын хооронд машины сэлбэг, багаж, тоног төхөөрөмж болон бусад материалыг зөөвөрлөх.
- ✓ Эвдэрсэн, хуучирсан хаягдал сэлбэг, материалыг цуглуулж, ажлын байрнаас гаргаж, цэвэрлэх.
- ✓ Цэвэрлэгч шингэн, даавуу, хийн буу, хоолой, тоос сорогч болон бусад тоног төхөөрөмжийг ашиглан машин болон эд ангиудыг цэвэрлэх.”

Гагнуурчин

1. Хийж гүйцэтгэдэг ажил: Гагнуурчин нь хийн ба цахилгаан гагнуурын төрөл бүрийн гагнуурын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан металл хэсгүүдийг гагнах ба таслах бүх төрлийн гагнуурын ажил хийж гүйцэтгэнэ.
2. Мэргэжлийн ур чадвар: Зурах, загварчлах, төлөвлөх, тооцоолох, техник тоног төхөөрөмжтэй харьцах чадвартай, техникийн мэдлэгтэй
3. Бие хүний онцлог шинж чанар, чадварууд: Хувийн зохион байгуулалттай, ой тогтоолт сайтай, сэтгэн бодох чадвартай, харилцааны соёлтой, техник сэтгэлгээтэй, сэтгэл хөдлөлөө хянах, бие дааж ажиллах, багаар ажиллах, шийдвэр гаргах, ачаалал даах чадвартай байх.
4. Ирээдүйд ахих дэвших боломж: Авто засвар, үйлдвэрлэл, техникийн үйлчилгээний салбарт мэргэших, мастер, үйлдвэрлэлийн дадлагад багшлах мөн мэргэжлээрээ

5 <http://hudulmur-halamj.gov.mn/occ/show/id/86>



идэвх зүтгэл, бүтээл гаргаж сайн ажилласан хүн мэргэжлийн зэрэг ахиулж, зэргийн болон олон жил ажилласны нэмэгдэл авч цалин хөлсөө нэмэгдүүлэх. Мөн энэ ажлаараа ахлах, ээлжийн болон хэсгийн дарга, чанар шалгагч, тоо бүртгэгч, багш гэх мэт ажил мэргэжлээр ахих дэвших. Боловсролоо ахиулж их дээд сургууль, коллеж төгсөж механик, инженер, дарга зэрэг ажил хийх боломжтой.

5. Гүйцэтгэх үүрэг:

- ✓ Гагнуурын аппаратын дөл, гагнуурын электрод хоёрыг гагнах материалын уулзвар луу тааруулан барьж халаах, электрод төмрийг хайлуулан халсан металл дээр нааж нийлүүлэх.
- ✓ Тайрагч хөрөө ашиглан электродыг тодорхой хэмжээ, хэлбэрээр тайрна. Төмрийн хавчаар ашиглан ажлын материалыг бэхэлгээнээс салган авч агаар усаар хөргөх.
- ✓ Ажлын материалын холбоосыг цэвэрлэхийн тулд түүнийг цэвэрлэгээний уусмалд дүрж сойзоор үрнэ. Гагнаасыг шалгаж доголдолтой болон эвдрэлтэй хэсгүүдийг дахин гагнах.
- ✓ Гагнуурын галын хэсэг рүү шланкийг холбож тохируулагч крант болон хийтэй цилиндрээс гарсан шланкийг гагнуурын толгойд холбох.
- ✓ Хийн урсгалыг гаргаж галыг асаахын тулд крантыг эргүүлж галын хэмжээ дөлний өнгийг тодорхой түвшинд хүргэхийн тулд крантыг тохируулж эргүүлэх.
- ✓ Металлын исэлдэх явцаас урьдчилан сэргийлэхийн тулд хамгаалах шингэнийг ажлын материал дээр болон гагнуурын электрод дээр багсаар түрхэх.
- ✓ Ажлын материалыг бэхэлгээ хийж гагнахад тохируулах. Металлыг гар гагнуурын аппарат буюу шарах шүүгээ ашиглан халааж гагнасан уулзварыг салгах ба буруу гагнаасыг засварлах.
- ✓ Өгөгдлийн хүснэгт буюу ажлын захиалгын дагуу гагнуурын хошуу, металл хамгаалах шингэн, гагнуурын электродыг сонгох.
- ✓ Хатуу гагнуурын машинаар металлыг халаах холбох температурт хүргэхийн тулд цахилгааны гүйдэл, давтамжийн хугацааг тохируулах.

ХОЁР. АВТОМАШИНЫ ЗАСВАРЧИН, ГАГНУУРЧИН МЭРГЭЖЛИЙН ЖЕНДЭРИЙН АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

1.Автомашинь засварчин, гагнуурчин мэргэжлээр элсэн суралцахад хүйсийн ялгаатай байдал ажиглагдаж байсан уу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Тийм	16	51.6	51.6	51.6
	Үгүй	14	45.2	45.2	96.8
	бусад	1	3.2	3.2	100.0
	Total	31	100.0	100.0	

Тухайн мэргэжлээр элсэн суралцаж буй суралцагчид дээрх асуултад тийм-51.6%, үгүй-45.2%, бусад-1% гэж хариулжээ. Энэ нь хүйсийн ялгаатай байдал 50%-аас дээш буй мэдэгдэхүйц ажиглагдаж байна гэсэн үг юм. Мэдэгдэхүйц ажиглагдаж буй шалтгаан нь тухайн ангийн суралцагчдын 90%-с дээш эрэгтэй харин эмэгтэй суралцагчид 1-2%-д хүрэхтэй үгүй байгаа нь том шалтгаан юм. Энэ нь тухайн мэргэжлээр элсэн суралцагчдын хувьд асар том хүйсийн ялгааг гаргаж байна. Мөн манай улсад “жендэрийн тэгш бус байдлын индекс нь хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалах хүний хөгжлийн гурван хэмжүүр болох нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал болон шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс юм. Үүнд:

- ✓ “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтийг эхийн эндэгдлийн түвшин, өсвөр насны охидын төрөлтийн түвшнээр;
- ✓ Боловсролын түвшин, шийдвэр гаргах эрх мэдлийн үзүүлэлтийг 25, түүнээс дээш насны хүн ам дундаас дээш боловсрол эзэмшсэн эмэгтэй, эрэгтэй хүн амын хувийн жингээр, үндэсний парламент дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жингээр;
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн оролцооны үзүүлэлтийг ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр тооцож авч үзнэ” Тиймээс ямарваа нэг байдлаар хүйсийн ялгаатай байдал үүсгэж ялгаварлан гадуурхаж болохгүй юм.

Мөн мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино хэмээн заасан байдаг. Энэ нь хүн өөрөө хүсвэл хүссэн мэргэжлээрээ боловсрол эзэмшиж болох юм.

2. Автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр төгссөн эмэгтэй суралцагчдад ажлын байр олддог уу.

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	10	32.3	32.3	32.3
	үгүй	4	12.9	12.9	45.2
	бусад	17	54.8	54.8	100.0
	Total	31	100.0	100.0	

Тухайн мэргэжлээр төгссөн эмэгтэй суралцагчдад өөрсдийнхөн онолын мэдлэг, авьяас, ур чадвар, практик туршлага, харилцааны соёл, цаг баримтлах болон багаар ажиллах чадвар зэргээс харгалзан ажлын байрны олдоц, ажлын санал ирдэг байна. Энэ нь тухайн хүний нөөц бололцооноос шалтгаалж хувь хүний карьер өсөх боломж нээгдэж байна. Мөн тухайн мэргэжлээр суралцаж буй суралцагчдад ажлын байрны олдоц бусад мэргэжлийг бодвол харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна. Мөн автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр сонгон суралцсан суралцагчид ажлын байранд гараад ажил олгогчийн талаас хүлээх үүрэг нь хөдөлмөр хамгаалал-хөдөлмөрийн процесст хүний ажлын чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж, аюулгүй ажиллагааг хангаж чадах нөхцөлийг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, нийгэм эдийн засаг, зохион байгуулалт, техник, ариун цэвэр эрүүл ахуйн арга хэмжээний систем. Аюулгүйн техник- ажиллагчдын эрүүл мэндэд үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд нөлөөлөхөөс хамгаалахад чиглэгдсэн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ, техник хэрэгслийн систем. Аюулгүйн техник- ажиллагчдын эрүүл мэндэд үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлүүд нөлөөлөхгүй байх хөдөлмөрийн нөхцөл байдлыг манай улсад одоогоор хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль байхгүй учраас энэхүү харилцааг хөдөлмөрийн хуулиар зохицуулсаар ирсэн.

Автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр суралцахад зориулсан сургалтын орчны тухайд: Автомашины бүтэц зохион байгуулалтыг тайлбарлах чадамжийн нэгжийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, материал түүхий эдийн жагсаалтыг МБС-ын стандартад заагдсан маягтын дагуу бичсэн болно. Байгальд ээлтэй, хүнд хор хөнөөлгүй орчин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал, эмэгтэй, эрэгтэй хүний ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө тусдаа байх.

Автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр суралцаад олж авах боловсрол нь автомашины засварчин мэргэжлээр суралцагч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, автомашины бүтэц зохион байгуулалт, ажиллагааг мэдэх, түүний эвдрэл гэмтлийг оношлох, техник үйлчилгээ, засвар, тохируулга хийх чадамжийг эзэмшинэ. Гагнуурчин мэргэжлээр суралцагч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, ширээлтийн машин төхөөрөмж, хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, ажиллагааг мэдэх, засвар үйлчилгээ, тохируулга хийх, ширээлтийн орчин үеийн дэвшилтэд техник, технологиор гагнуурын ажил гүйцэтгэх чадамжийг эзэмшинэ.

3.Тухайн мэргэжлээр суралцаж буй суралцагчдын дунд ур чадварын ажил дээр хүйсийн ялгаатай байдал гардаг уу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	11	35.5	35.5	35.5
	үгүй	16	51.6	51.6	87.1
	бусад	4	12.9	12.9	100.0
	Total	31	100.0	100.0	

Автомашинны засварчин, гагнуурчин мэргэжлээр суралцаж буй суралцагчдын дунд ур чадварын ажил дээр хүйсийн ялгаатай байдал ажиглагдаж буй нь тэдний ур чадвар, авьяас билэг, онолын мэдлэг, практик туршлагаас нь хамаарч байна. Мөн 7^м “жендэр гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүйсээс, мөн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаанаас хамаарч нийгэмд бий болж буй шинж чанар ба боломжуудын тухай асуудал юм. Эдгээр шинж чанар, боломжууд нь нийгмийн харилцааны үр дүн мөн бөгөөд хүний нийгэмших явцад төлөвшин бий болдог.” Тиймээс эрэгтэй хүн заавал машин техникт сайн байх албагүй харин ч охид тэдэнтэй адил тэнцүү өрсөлдөж чадна гэдгийг илтгэж байна.

3. Таны бодлоор автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр эмэгтэй хүүхэд суралцах боломжтой юу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	боломжтой	28	90.3	90.3	90.3
	боломжгүй	3	9.7	9.7	100.0
	Total	31	100.0	100.0	

Автомашинны засварчин, гагнуурчин мэргэжлээр эмэгтэй хүүхэд элсэн суралцах боломжтой юу гэх асуултад хөвгүүдийн 90% нь элсэн суралцах боломжтой гэсэн хариуг сонгожээ. Энэ нь эмэгтэй хүүхэд өөрөө хүсвэл тухайн мэргэжлээр элсэн суралцах боломжтойг илтгэж байна. Мөн 8^м “эмэгтэйчүүдийн эрх мэдлийг ихэсгэх гэдэг нь эмэгтэйчүүд өөрсдийн амьдралаа өөрийнхөөрөө авч явах эрх мэдэлтэй байхыг хэлнэ. Үүнд эмэгтэйчүүд өөртөө итгэлтэй байх, тэдний сонголт хийх боломжийг өргөжүүлэх, нөөц баялгийг хүртэх ба түүнийг захиран зарцуулах боломжийг нэмэгдүүлэх мөн түүнчлэн жендэрийн тэгш бус байдлыг үүсгэж буй нийгмийн институцийг өөрчлөх зэргийг хамруулж ойлгодог.”

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.1. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид ажил, мэргэжлийн ангилал тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ. 9.2.2. мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр шинэ техник эзэмших, өөрчлөлтөд зохицож хөгжих, тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар олгох; 9.2.3.мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжлийн үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх, тухайн мэргэжлээр сонгон мэргэшүүлэх. Энэ хуульд зааснаар

7 НҮБ Эмэгтэйчүүд 2017

8 НҮБ Эмэгтэйчүүд 2017

бол мэргэжлийн боловсрол эзэмшихэд нас, хүйс харгалзан мэдлэг боловсролыг ялгаатай олгон гэсэн хуулийн заалт байхгүй тул автомашин, гагнуурчин мэргэжлээр эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүн мэргэжил эзэмших боломжтой юм. Өөрөөр хэлбэл хүн өөрийн хүссэн мэргэжлээрээ ажиллахад хүйсийн ялгаатай байдал саад болох нь хорин нэгдүгээр зуунд байж болохгүй зүйлийн нэг юм. Харин тухайн мэргэжлээрээ ажиллахад боловсрол, туршлага, ур чадвар, нөөц бололцоог нь харгалзан сонгон шалгаруулах нь шударга юм. Мөн автомашины засварчин, гагнуурчин мэргэжлийн ажиллах орчин хэвийн гэж тодорхойлогддог байна.

5. Тухайн мэргэжлээр суралцаж буй суралцагчид дадлага ажил хийхэд хүйсийн ялгаатай байдал гардаг уу.

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Тийм	23	74.2	74.2	74.2
	Үгүй	7	22.6	22.6	96.8
	бусад	1	3.2	3.2	100.0
	Total	31	100.0	100.0	

Тухайн асуултад суралцагчид дараах хариултыг өгчээ. Үүнд: тийм-74%, үгүй-22%, бусад-3%. Энэ нь хүнд юм зөөх, өргөх ажилд хүйсийн ялгаатай байдал ажиглагдаж байгаа бол ур чадварын ажил дээр охид хөвгүүдтэй энэ тэнцүү байдаг гэж тухайн хичээлийг зааж буй багш нар хэлсэн. Энэ нь тухайн мэргэжлээр охид сурч хөгжих боломжтойг харуулж байна. Мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч тэдний ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзэх ёстой ба жендэрийн эрх тэгш байдал нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангахыг хэлнэ гэдийг бид хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм. Бид өөрсдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч түүнийг ойлгосноор асуудал гарах нь бага юм.

Жендэрийг зарим хүмүүс ойлгохдоо⁹ “эрэгтэй, эмэгтэй хүнд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноон, хуваарилсан дүр төрх, үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, эрх мэдлийг илэрхийлдэг ойлголт юм. Эрэгтэй эсвэл эмэгтэй байхаас хамааран тухайн хүнд нийгмээс юу хийх, юу хийж болохгүйг тулгаж, ямар байр суурь эзлэхийг тодорхойлж, ямар үүрэг хариуцлага хүлээхийг хуваарилж, энэхүү хүлээлт, шаардлагын дагуу биеэ авч явж, зан үйлээ тохируулж байгаа эсэхийг нь үнэлдэг, шаарддаг, шахалт үзүүлдэг” ойлголт гэж хардаг гэвч энэ нь үнэндээ жендэрийн ялгаатай үнэлэмж ба өөрөөр жендэрийн ялгаварлан гадуурхалт юм. Бид хэн нэгэн хүнийг чи эмэгтэй учраас эрчүүдтэй адил түвшин ажил хийж болохгүй гэж дарамт, шахалт үзүүлж буй хэрэг бөгөөд бид харин өөрсдийн ялгаатай талыг боломж шинэ гарц хэмээн ойлгосноор амжилтад хүрнэ. Яг үүнтэй адил автомашины засварчин, гагнуурчин мэргэжлийн дадлага ажил хийхэд гарч буй хүйсийн ялгаатай байдлыг шинээр суралцах боломж дадлага туршлага хэмээн ойлгосноор энэхүү асуудлыг шийдэж чадах юм.

9 Энхжаргал, Д. Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх. Уб. 2016. 27х

Дүгнэлт

Эмэгтэй суралцагчид өөрөө хүсвэл автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр хөвгүүдтэй энэ тэнцүү сурч боловсрох боломжтой байна. Тухайн мэргэжлээр охидыг сургууль болон ажил олгогч байгууллагын талаас элсүүлэн авах сонирхолтой байгаа нь ажиглагдсан. Энэ нь нийгэмд эзлэх эмэгтэйчүүдийн байр суурь дээшилж буй эерэг хандлагыг илтгэж байна.

Мөн автомашины засварчин, гагнуурчин мэргэжлээр эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн мэдлэг, ашиг сонирхлыг анхаарч тэдэнд хүртээмжтэй сургалтын хөтөлбөр өөрчлөлтийг оруулж, нийгэмд заавал тухайн мэргэжлээр эрэгтэй хүн ажиллах ёстой гэсэн хэвшмэл ойлголтыг өөрчлөх ёстойг юм. Ингэснээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч тэдний ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг харгалзаж жендэрийн эрх тэгш байдал нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангахыг хэлнэ гэдгийг ойлгох нь чухал юм.

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг.УБ, 2004
2. НҮБ Эмэгтэйчүүд 2017
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл. 2018-2019 оны хичээлийн жил. УБ. 2019
4. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого. Жендэрийн тэгш байдал. УБ. 2011
5. Энхжаргал.Д. Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх. УБ. 2016

Ашигласан веб сайт

1. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2700_004V1
2. http://portal.merit.mn/dataset/37eada02-cb75-448a-8991-a4a0b5a3dcf6/resource/1ebf8ddd-dc27-455d-9db7-42dfb5dcc989/download/intro-to-gender-and-gender-mainstreaming-in-project-cycle-mng_updated.pdf
3. <http://hudulmur-halamj.gov.mn/occ/show/id/86>



Монгол Улс дахь
Конрад-Аденауэр-Сан
Меру Тауэр
Жамьян гүний гудамж 18-2
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот 14210
Монгол Улс

www.kas.mongolia
www.facebook.com/kas.mongolia
www.kas.edu.mn